

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 11
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12 - 114
1.	<i>“Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	13 - 36
2.	<i>“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	36 - 103
3.	<i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	103 - 114

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 8 дугаар сарын 21-ний өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Болормаа, Д.Ганмаа.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын нэгдүгээрт оруулж хэлэлцүүлэх гэсэн горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	4
Бүгд:	18

77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Б.Түвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 94.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Нэг. “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Ж.Чинбүрэн, А.Ариунзаяа, Б.Бейсен, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара, Ж.Баясгалан, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

**Л.Энхнасан:** “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, мөн яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга А.Халиунаа, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Э.Хулан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ж.Баясгалан, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, Б.Бейсен, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал нар хариулж, тайлбар хийв.

*-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энхнасан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.19 дэх дэд заалтын “инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	13
Бүгд:	19

31.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	9
Бүгд:	19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Тогтоолын төслийн 2.1.1.19 дэх дэд заалтын “инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болон” гэж өөрчлөх гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Алимаа нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	10
Бүгд:	19

47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 13  
Бүгд: 19  
31.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан: 2.**Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.21 дэх дэд заалтын “стандартыг” гэсний дараа “албан байгууллага,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 7  
Бүгд: 19  
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан: 3.**Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь дэд заалтыг нэмэх:

“2.3.2.8.сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 7  
Бүгд: 19  
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан: 4.**Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралт 1-д Хүний хөгжлийн бодлогын 2.1.1.2 дахь дэд заалтад “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулна” гэснийг “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүй хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, М.Нарантуяа-Нара, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 16  
Бүгд: 19

15.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан:** 5.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.10 дахь дэд заалтад “хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** 6.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Тогтоолын төслийн 2.2.3.2 дахь дэд заалтад “Багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын тогтолцоог бий болгож” гэснийг “Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн” гэж өөрчлөн, “бэлтгэх замаар” гэсний дараа “багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 11

Бүгд: 19

42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Тогтоолын төслийн 2.2.3.2 дахь дэд заалтад “Багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын тогтолцоог бий болгож” гэснийг “Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн” гэж өөрчлөн, “бэлтгэх замаар” гэсний дараа “багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** 7.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.10 дахь дэд заалтад “Суралцангаа хөдөлмөрлөх – хөдөлмөрлөнгөө суралцах хосмог ажлын

байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** 8.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.31 дэх дэд заалтад “залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай нөхцөл бүхий орон сууцын тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** 9.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.30 дахь дэд заалтад “төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	10
Бүгд:	19

47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	9
Бүгд:	19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Тогтоолын төслийн 2.1.1.30 дахь дэд заалтад “төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8



Бүгд: 19  
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан: 10.** Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төслийн 2.1.1.23 дахь дэд заалтын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулах” гэж нэмэх, “хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн С.Зулхар, Ж.Баясгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 16  
Бүгд: 19  
15.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан: 11.** Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төсөлд “4.1.3.4.иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах. Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 11  
Бүгд: 19  
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 9  
Бүгд: 19  
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Тогтоолын төсөлд “4.1.3.4.иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах. Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 8  
Бүгд: 19

---

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан: 12.** Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Тогтоолын төслийн 4.1.3.5 дахь дэд заалтад “иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тогтолцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан: 13.** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.6 дахь дэд заалтад “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж” гэсний дараа “жил бүр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, С.Зулпхар нар үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 14

Бүгд: 19

26.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан: 14.** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төсөлд “4.1.3.4.тендэр үнэлгээнд төсөл хөрөнгө оруулалт шууд дам нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 12

Бүгд: 19

36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан: 15.** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун нарын гаргасан, Тогтоолын төслийн 2.3.4.3 дахь заалтын “эрүүл мэндийн ажилтны” гэсний дараа “цалин хөлс,” гэж нэмэх, “алслагдсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ц.Идэрбат, С.Зулпхар нар үг хэлж, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 11

Бүгд: 19  
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан:** 16.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 2.1.2.2 дахь дэд заалтад “Хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, С.Зулпхар, Ц.Идэрбат нар үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 11  
Бүгд: 19  
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

*Төслийн 1, 2, 3, 4 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын

аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн В.Содномдаржаа, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ц.Идэрбат, Д.Үүрийнтуяа нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 5 цаг 16 минут үргэлжилж, 21 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 90.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 54 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим  
11 цаг 38 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа, Жадамбаагийн Баясгалан, Буланы Бейсен, Хүрэлбаатарын Булгантуяа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Мөнхтөрийн М.Нарантуяа-Нара, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Банзрагчийн Түвшин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Сүхбаатарын Эрдэнэбат, мөн Б.Хэрлэн гишүүн оролцож байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирсэн учраас Байнгын хорооны ирц 85.7 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Нэгдүгээрт,** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргэнэ.

**Хоёр дахь асуудал.** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл.

Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

**Гурав дахь асуудал.** “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгнө үү.

**А.Ариунзаяа:** Эрхэм Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах горимын санал гаргаж байна.

Учир нь төсвийн ажлын хэсэг Аюулгүй байдлын байнгын хороон дээр хэлэлцэх асуудал нь дуусаагүй байгаа учраас хамгийн сүүлийн асуудал буюу Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай энэ тогтоолыг хэлэлцэхийг нэгдүгээрт оруулах ийм горимын санал гаргаж байна.

**Л.Энхнасан:** Горимын санал дээр санал хураах. Санал хураая.

Нэгдүгээр асуудлаар хэлэлцье гэсэн горимын санал дээр санал асуулга явъя. Дэмжье гэсэн саналаар. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

Ц.Идэрбатын аппарат ажилласангүй. Дэмжсэнээр тооцье. Б.Бат-Эрдэнэ гишүүний аппарат бас ажилласангүй. Дэмжсэнээр тооцье. Б.Түвшин гишүүнийх бас ажилласангүй. Дэмжсэнээр тооцье.

Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгье. Саналаа илэрхийлье гэсэн.

**Ж.Баясгалан:** Санал давхацсан. Тийм. Байр сольё гэж хэлэх гэж байсан юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Ойлголоо.

Тэгэхээр хэлэлцэх асуудал гуравдугаар асуудлаа ярилцъя.

---

### Нэг. “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

---

2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Эмийн үнийн өсөлтийг шалгах нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 2-т заасны дагуу хэрэгжилттэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар эрх бүхий албан тушаалтан санал холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн

бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн саналаа ирүүлсэн болно.

Та бүхэнд Улсын Их Хурлын 38 дугаар тогтоол болон хэрэгжилтийг хангуулах тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Та бүхэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн болон холбогдох яамны мэргэжилтнүүдээс асуулт асууж болно.

Яамны мэргэжилтнүүдийг танилцуулъя.

Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

С.Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. М.Нарантуяа-Нараг асуулт асуухаар тусгая. Ж.Чинбүрэн гишүүн танилцуулна уу. 5 минут.

**Ж.Чинбүрэн:** Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны даргалагчид бас мэнд хүргэе.

Чухал асуудлыг бид энд хөндөж тавьж байгаа юм.

Өнгөрсөн парламентын үед нэг хийсэн чухал олон нийтийн сонсгол бол энэ эмийн чанар хүртээмжийн асуудалтай холбоотой сонсгол хийсэн.

Үүнтэй холбоотой бид чухал чухал зүйл баталсан. Нэг нь Эм эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өнгөрсөн парламент хаврын чуулганаараа баталж дуусаж амжсан.

Ингээд энэ хууль маань одоо 10 сарын 01-нд. Одоо ерөөсөө хаяанд тулсан байна. 10 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх ёстой.

Үүнтэй холбоотой Монгол Улсын зах зээл дээр байгаа эмийн чанарыг

хэрхэн сайжруулах талтай холбоотой бид тогтоол тухайн үед гаргаж Засгийн газарт үүрэг өгч байсан.

Сая энэ ээлжит бус чуулган эхэлсэнтэй холбоотой миний бие Гаалийн ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагууддаа эрүүл мэндийн чухал нэг зэвсэг болж байгаа эмийн асуудалтай холбоотой ажлууд, өгсөн үүрэг даалгавар хэрхэн явж байгаа талаар асуухад ерөөсөө урагшилсан нэг ч алхам алга байна. Бахь байдгаараа л хэвдээ л байж байна.

Тийм учраас Их Хурлын дарга болон даргын дэргэдэх зөвлөлд зориуд санал гаргасан юм.

Тогтоолын төсөл Та бүхэнд хүргээд байгаа.

Үүний эхний нэг дэх чухал зүйл нь юу байна вэ гэхээр бид “итгэлцлийн зохистой дадлага” гэдэг зүйлийг хэрэгжүүлбэ гэдэг хуульдаа хүртэл заалт орсон. 16.9 дээр, 51-ийн хэд билээ дээ, тэндээ 2 чухал заалт орсон.

Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр өндөр хөгжилтэй тухайн улсын эм нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад тухайн Засгийн газрынх нь явуулж байгаа үйл ажиллагаа, эм нь итгэлцэлтэй найдвартай тийм эмүүдийг Монгол Улсад бүртгэхдээ заавал тэр чанар шаардлага хангаж байна уу гэдэг судалгаа шинжилгээ, лабораторийн шинжилгээ хийгээд байх шаардлагагүй.

Тэр итгэлцлийн гэрээгээр Монгол Улсад тухайн өндөр хөгжилтэй, тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улс, Сингапур ч гэдэг юм уу. Тийм ээ. Эдгээр улсууд.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас бүр улсуудынх нь жагсаалт нь гарчихсан байгаа.

Тэр найдвартай эмийг эх орондоо хангаж ажиллаж шалгаж чаддаг улсууд гээд.

Тэр дагуу Монгол Улсдаа хэрэглэдэг байх энэ зохицуулалтыг яаралтай хэрэгжүүл ээ гээд энэ нэг дээр Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчилсэн найруулгын хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, итгэлцлийн зохистой дадлагыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтыг эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах гээд ингээд оруулчихсан.

Ингээд яах вэ гэхээр Эрүүл мэндийн яам, Эмийн агентлаг маань тухайн улсын Засгийн газартай хамтын ажиллагааны гэрээ, ойлголцлын гэрээ хийгээд тэгээд тухайн улсад мөрдөгдөж байгаа тэр эмийн жагсаалтуудыг Монгол Улс гааль дээр бүртгэлийг нь харах, хянах, энэ улс нь тухайн улсдаа бүртгэлтэй бол Монгол Улсад шууд хэрэглэх боломжтой болгоё гэсэн ийм санаа энд явж байгаа шүү. Үүний ар талд.

**Л.Энхнасан:** Ж.Чинбүрэн гишүүнд 1 минутыг нэмж өгье.

**Ж.Чинбүрэн:** Та бүхэн үүнийг бас ойлгочихвол их чухал байгаа.

Тэгэхээр бид өнгөрсөн тэр Хянан шалгах түр хорооны сонсгол дээр нэг хэлсэн зүйл бол ерөөсөө бөөний үнээр ханган нийлүүлж байгаа байгууллагууд эмийнхээ үнийг би тэдэн төгрөгөөр нийлүүлж байна гэдгээ килограмм тонноор биччихдэг.

Тэгтэл аптека дээр иргэн хүн гар дээрээ авахдаа 0.5, 1 грамм ч гэдэг юм уу, хэдэн миллилитр ч гэдэг юм ингэж авдаг байхгүй юу.

Тэгэхээр нөгөө үнэ нь хэдэн төгрөг болоод ард иргэд дээр хэд нугалараад очиж байгааг мэдэх боломж байхгүй.

Тийм учраас үүнийг мэдэхийн тулд яах ёстой вэ гэхээр гааль, татвар, манай Эрүүл мэндийн яам Эмийн агентлагтайгаа хамтраад энэ мэдээллээ тэр худалдах нэгжээрээ тавьж байх ёстой юм.

Жишээ нь, бөөний үнээр би энэ аспирын 0.5-ыг тэдэн төгрөгөөр оруулж ирлээ шүү гэдгээ гааль дээр мэдүүлэх энэ тогтолцоог л хийж өгөх гээд байгаа юм. Ажил ерөөсөө эхлээгүй байна.

Тэгээд иргэн хүн аптекаас авахдаа миний эм энэ компани тэдэн төгрөгөөр оруулж ирснийг би тэдэн төгрөгөөр авч байгаа юм байна гэдгээ мэдэх ёстой байхгүй юу.

Ингэж бид үнийг хянахгүй бол өөрөөр бид хянах ямар ч боломж байхгүй юм билээ.

Энэ зүйлийг 2 дугаар зүйлээр оруулж өгсөн шүү.

3 дахь зүйл нь болохоор.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Минут дууссан учраас холбогдох асуудалд.

Б.Бейсен гишүүн асуултаа асууна уу.

**Б.Бейсен:** Та бүгдэд өглөөний мэнд хүргэе.



Би эмийн шалгах түр хороонд ороод ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч байгаа. Одоо энэ хөнгөлөлттэй эмийн асуудал байгаа. Хөдөөгийн иргэд ерөөсөө авч чадахгүй байгаа.

Та бүгд харж байгаа. Аймгийн төв Улаанбаатар хотод бөөгнөрсөн баахан аптектай. Хөдөө сум, багийн түвшинд ерөөсөө эм авч чадахгүй байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн газар сум, багийн түвшинд эмийн сангийн асуудлыг багийн түвшинд явуулья.

Сумын төвд эм хангах асуудлыг шийдэхгүй бол ерөөсөө хөнгөлөлттэй эмийг авч чадахгүй байгаа. Энэ дээр нэлээн анхаарч ажиллахгүй болохгүй нь.

Тийм учраас Эрүүл мэнд яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн газар энэ дээр онцгой анхаарах шаардлагатай.

Нөгөө талаар зарим гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой сумын эмнэлгүүд тоног төхөөрөмжийн дутагдалтай. Жишээлбэл, эрс тэс уур амьсгалтай манай улсын ихэнх иргэд сум, багийн түвшинд, аймгийн түвшинд ч гэсэн, хотод ч гэсэн хатгаагаар өвддөг.

Гэтэл сумын эмнэлгүүд дээр ерөөсөө рентген аппарат байхгүй.

Рентген аппарат байхгүйтэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч чаддаггүй асуудлууд гарч байгаа.

Тийм учраас үүнийг төсөвт тусгах тал дээр бас анхаарах шаардлагатай байгаа.

Нөгөө талаар Эм, эмнэлгийн хэрэгслийн газар маань одоог хүртэл байргүй. Түрээсийн байранд. Баталгаат эмийн лаборатори нь ч найдвар тун муутай.

Түрүүн бид газар дээр нь очоод шалгахад. Жилийн өмнө. Бүх стандарт бодисуудаа нэг юундаа хийчихсэн. Бүгд галогенийн нэгдэл шүү дээ. Тус тусдаа байх ёстой. Гэтэл цаад талын “Монос” дээр очиход тус тусдаа хадгалсан байдал гарсан.

Тэгэхээр энэ асуудал дээр нэг анхаарах шаардлагатай.

Нөгөө талаар Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн газрынхан байгаа дээр эмийн үнэтэй холбоотой хөдөөгийн эмнэлгүүд. Ихэнх нь эмийн өртэй.

Одоо энэ аймгуудын нийт өрийн бараг 90 хувь нь тэр эмийн өр байх шүү.

Тэгэхээр хэчнээн аймагт ямар өртэй байна. Жишээлбэл, түрүүн Баян-Өлгий аймагт тэрбум 700 сая орчмын өртэй гээд гарч байсан.

Тэгэхээр энэ асуудал дээр дүгнэлт хийгээд ажиллаад эрүүл мэндийн хурал дээр Эрүүл мэндийн сайд тэгээд хэдэн төрийн нарийнаа бид муулаад байдаг. Гэтэл төрөөс баримтлах асуудал дээр нэлээн анхаарахгүй бол энэ үндсэн аюулгүй байдалтай холбоотой асуудал шүү дээ.

Тэгэхээр энэ асуудал дээр ямар байр суурьтай байна?

**Л.Энхнасан:** 1 минутыг нь өгье.

Тэгэхдээ Б.Бейсен гишүүний санал тогтоолтой холбоогүй юм байна.

Тэгэхээр хариулт өгөхгүй. Б.Бейсен гишүүнд тэгэхдээ 1 минутыг нь өгье.

**Б.Бейсен:** Энэ тогтоол уг нь холбоотой ч асуудлууд байгаа л даа, энэ чинь.

Эмийн хүртээмжийн асуудал, чанар аюулгүй байдлын асуудал гээд тогтоолд тусгасан байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариу авмаар байх юм.

**Л.Энхнасан:** Ж.Чинбүрэн гишүүнд микрофоныг нь өгье.

**Ж.Чинбүрэн:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр тогтоолын 3 дахь зүйлийг Та хараарай.

Эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар судлан санал танилцуулга хийж байгаа.

Энд яг таны хэлж байгаа яаж алслагдсан газар эмийн хүртээмжийг хангалттай байлгах вэ. Санхүүгийн дарамтгүй өгөх вэ. Нөгөө хөнгөлөлттэй эмүүдийг хүртээмжтэй байлгах асуудлыг энэ дотор оруулж Эрүүл мэндийн яам танилцуулах ёстой.

Тэгэхээр 3 дугаар зүйлээр энэ асуудлууд орчихно.

Нөгөө талаасаа Эрүүл мэндийн яам Их Хурлаас гарсан тогтоолын дагуу 11 сард тайлангаа тавина. Тийм ээ. 11

сард тайлан тавих учраас бид бас тайлангаараа энэ эмийн чанартай холбоотой, хүртээмжтэй асуудалтай холбоотой зүйлээр мэдээлэл дэлгэрэнгүй авч болно.

**Л.Энхнасан:** Б.Бейсен гишүүний асуултад төсөв хэлэлцэхэд хариулж болно. Тэр үед яамнаас мэргэжилтнүүд, сайд хариулна.

Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Хэд хэдэн юм байна. Би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байсан.

Эмтэй холбоотой хэрэглэгчийн гомдол асар өндөр байдаг.

Эмийн хэрэглээтэй холбоотой, эмийн чанартай холбоотой асуудлууд их өндөр байдаг юм. Тэгээд шинжлэх лабораторитой холбоотой асуудлууд энд тусгагдсан л байна л даа.

Нэг хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, энэ эм шинжлэх лабораторийн хүний нөөцийн асуудал ер нь яаж явдаг юм бэ?

Сая Ж.Чинбүрэн гишүүн хэлж байна. Тоног төхөөрөмжийн асуудлуудыг бид тодорхой хэмжээнд шийдвэрлээд ингээд явж байна. Түрээсийн байрны асуудал гээд ярьж байх шиг байна.

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудынхан тухайн эрүүл мэндийн салбарынхан ярихдаа танайх тоног төхөөрөмжийн хувьд тодорхой хэмжээнд сайжирч байгаа. Хүний нөөцийн хувьд

одоо сайжрах шаардлага байна гэдгийг байнга эдэлж байгаа.

Тэгэхээр одоо бид эм шинжлэх лабораторийн хүний нөөц дээрээ яаж анхаарах юм бэ?

Яагаад гэхээр энэ чинь өнөөдрийн байгаа нөхцөл байдалд гэр бүлд нь өвчингүй ч хүн алга, хүнс авах мөнгөөрөө эм авдаг болсон байна.

Тэгэхээр бид энэ эмтэй холбоотой асуудал дээр ялангуяа энэ лабораторийн асуудлыг хөндөхөөс өөр арга алга.

Тэгээд энэ бол яалт ч байхгүй энэ Улсын Их Хурлын 38 дугаар тогтоолтой холбоотой асуудал дээр нэгдүгээрт орсон байна.

Хоёрдугаар асуудал нь, Ж.Чинбүрэн гишүүн өөрөө сонголын үеэр хэлж байсан.

Лаборатори эмийн музей болсон гээд. Лаборатори нь эмийн музей болчихсон юм бол эм нь түүхийн олдвор болох юм уу, юу болох юм?

Аюулгүй байдлаар бид эм аюулгүй гэж бодоод л, үзээд л, аваад л, уугаад л байдаг.

Гэтэл энэ чинь музейд шинжилж байгаа эм чинь өөрөө аюултай юм уу, аюулгүй юм уу? Үүнийг асуумаар байна.

Гуравдугаарт, бид эмийн эмчилгээний идэвхжилтийг судлах зайлшгүй шаардлагатай гэж ойлгож байгаа. Энэ бол манай Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллахад их ирдэг гомдлуудын нэг.

Тэгээд манайх дээр нэг дутагдалтай юм, зүгээр олон улсын бусад хөгжилтэй орнуудыг хараад байхаар эмнэлгээний идэвхжилтийг нь судалж болж байна.

Нянгийн идэвхжилтийг нь судалдаг юм уу? Нян нь ямар түвшинд байгаа юм? Ямар хэмжээний идэвхжилттэй байгаа юм?

Үүнийг манайх яг судалдаг юм уу гэдгийг асуумаар байна.

Дөрөвдүгээр асуулт нь, би одоо ерөөсөө өнөөдрийг хүртэл ойлгохгүй яваад байгаа нэг газар байгаа.

Энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар гээд.

Энэ яг ямар чиг үүрэгтэй газар юм? Тэгээд дарга нь байсхийгээд л солигдчихдог. Нэг түрээсийн байранд байсан. Тэгээд л дарга цэргийн асуудал гээд л дандаа л хүний нөөцтэй холбоотой асуудлууд л хөндөгдөөд байсан.

Тэгээд энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын газрын чиг үүргийг тодорхой болгон эрх зүйн чадамжийг дээшлүүлж байр санхүүжилтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх гээд энэ хяналт шалгалтын асуудал дээр байна л даа.

Тэгээд энэ дээр хариулт авмаар байна.

Сүүлд нь. Лабораторитой холбоотой асуудлуудыг би сая хэлчихсэн.

Энэ эм шинжлэх лабораторийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой нэгтгэнэ гээд. Энэ юу болсон юм бол?

Хамгийн сүүлийнх нь бол.../минут дуусав/

**Л.Энхнасан:** 1 минутыг өгнө үү?  
Б.Бат-Эрдэний микрофон.

**Б.Бат-Эрдэнэ:** Хамгийн сүүлийнх нь Улсын Их Хурлын тогтоолын 2 дээр Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлд хийсэн хяналт шалгалтын явцад төрийн байгууллага дахь эмийн хангамжийн байгууллагын хамаарал, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй хувийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган, иргэд, олон нийгэд нээлттэй мэдээлэхийг Авлигатай тэмцэх газар, хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурорт тус тус зөвлөсүгэй гэсэн ийм тогтоол байна л даа.

Тэгээд энэ маань юу болсон бэ? Хяналт шалгалттай хийсэн авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт ямар түвшинд байгаа вэ гэдэг ийм 6 асуултыг би асууж байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Эхний 3 асуултад Ж.Чинбүрэн гишүүн хариулаад 4, 5, 6 дугаар асуултад ажлын хэсгээс Ш.Энхтуяа хариулахыг хүсье.

**Ж.Чинбүрэн:** Б.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Чухал яг гол амин сүнс асуудлуудыг асууж байна.

Эм шинжлэх лавлагаа, лабораторийн нэг том дутагдал юу байна

вэ гэхээр Монгол Улсад нэг их олон лабораториуд байна. Баахан ижил үнэтэй тоног төхөөрөмжтэй.

Тэгээд бүгд тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг.

Тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг учраас урвалжуудаа авахаар дандаа тусдаа тендер зарлаж авдаг. Баахан үнэтэй урвалжууд авдаг. Боловсон хүчин хангалттай биш.

Одоо жишээлбэл Гаалийн ерөнхий газрын харьяа бүх боомтууд дээр маш мундаг гоё хөрөнгө оруулалт хийгээд хүнс болон эмийг шалгах. Шалгалтын аппаратууд нь ижилхэн шүү дээ.

Ийм лабораториудтай болчихсон. Боловсон хүчин байхгүй.

Би сая Гаалийн ерөнхий газрын даргатай уулзаж ярилаа. Үнэхээр боловсон хүч олдохгүй байна. энэ лабораториудын үйл ажиллагааг жигд явуулахын тулд бид яах ёстой вэ гэдэг асуудлаа ярьж байгаа юм.

Бид энэ сонсголын үеэр нэг хэлсэн зүйл бол ер нь нэгдсэн лаборатори байх ёстой юм байна.

Нэг дээвэр доор удирдлагатай, нэг тогтолцоотой, нэг дата баазтай ажиллах юм бол өртөг зардлын хувьд хэмнэлттэй, тэгээд боловсон хүчний хувьд хүрэлцээтэй ажиллах ийм боломжтой юм байна гээд.

Энэ ч утгаараа бид Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дотор лабораторийн асуудлыг оруулж өгсөн.

Тэгээд тэр лабораторийн хүчин чадал, үйл ажиллагааг зөв явуулах тэр боломжийг нь гаргаж өгсөн.

Хоёр дахь чухал зүйл бол ер нь энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага манай эмийн салбарын үнэлгээг хийхдээ. Эмийн агентлаг нь. Одоо товчхоноор хэлэх юм бол. Тийм ээ. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтыг зохицуулах агентлаг.

Энэ газар доороо өөрийн гэсэн үндэсний лавлагаа лабораторитой байх ёстой гэдэг юм.

Тэгэхээр энэ зайлшгүй лабораторитой байх ёстой учраас бид энэ Эм, эмнэлгийн агентлагийн үйл ажиллагааг хуульд бүхэл бүтэн нэг зүйл заалт болгоод оруулчихсан байгаа юм.

Үүнээс өмнөх хугацаанд ямар нэгэн хуулийн зохицуулалтгүй ажилласан байхгүй юу. Эд нар чинь.

Тийм учраас ерөөсөө дарга нь ч хүртэл дандаа түр орлон гүйцэтгэгч. Бөөн хамаарал бүхий этгээдүүд болчихсон ийм байсан.

Тэгэхээр энэ хуулиараа бид энэ болохгүй байгаа бүх үүд хаалгуудыг хаагаад өгчихсөн шүү.

Бас нэг сонсголын үр дүн бол мэдээж энэ чухал 3 аппаратынх нь 2 нь эвдэрхий.

Нэг ч сайд нар очиж үзээгүй байсан. Энэ лабораторид нь очоод үзчихгүй.

Харин Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 1.4 сая доллар С.Чинзориг сайдын үед тохироод, хөрөнгө оруулалт

хийгээд, одоо тоног төхөөрөмжүүд нь аваад өгчихсөн гэж би ойлгосон.

Саяхан би Эрүүл мэндийн яамны сайдаас мэдээлэл авлаа. Т.Мөнхсайхан сайд хүлээж авсан юм шиг байна. Тийм ээ. Тоног төхөөрөмжүүд.

Тэгэхээр орон байр нь ямар байгаа талаар Та бүхэнд илрүүлж ярих байх. Байр сав нь байхгүй. Нөгөө ХАБҮЛЛ[Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори]-аасаа хөөгдчихсэн. Айлын өрөөнд байгаа юм шиг л байж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлуудыг нь ингээд шийдэж байгаа юм.

Тэгээд бусад бусад асуултад нь Эрүүл мэндийн яам хариулах байх.

**Л.Энхнасан:** Ш.Энхтуяа даргын микрофоныг өгнө үү.

2 номерын микрофоныг өгнө үү.

**Ш.Энхтуяа:** Сайн байцаана уу? Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ш.Энхтуяа.

Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр эмийн идэвхжил, нянгийн асуудлыг сая ярилаа.

Тэгэхээр манайх эмийг Монгол Улсад бүртгэх буюу үйлдвэрлэхдээ pharmacopoeia стандартад заасан дагуу шинжилгээгээ хийж байгаа.

Тухайн эмийг яг үйлдвэрлэхээсээ өмнө эмнэл зүйн болон бусад судалгаа хийгдчихсэн байдаг.

Нянгийн тэсвэржилтийн хувьд тухайн эм өвчтөнд нянгийн эсрэг тариа хэрэглэх тохиолдолд манай эмнэлгийн лабораториуд дээр нянгийн тэсвэржилтийг үзсэний дараа антибиотикийг сонгож хэрэглэдэг.

Энэ бол манай эмнэлгүүд дээр хийгдэж байгаа арга хэмжээ байгаа.

Дараагийн нэг асуудал сая Ж.Чинбүрэн гишүүн бас хэллээ.

Манай лабораторийн хувьд Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа.

Яг лабораторидоо түрээсийн мөнгө төлдөггүй. Төрийн байгууллагууд гэдэг утгаараа ажиллаж байгаа.

Дээр нь тоног төхөөрөмжийн хувьд одоо манайх өнгөрсөн оны 1 сараас саяын 7 сарын 31 хүртэлх хугацаанд тэрбум гаруй төгрөгийн 20 гаруй тоног төхөөрөмжийг аваад суурилуулаад ажиллаж байна.

Байрны хувьд манай сайд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад асуудлыг тавиад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгч, холбогдох хүмүүстэй уулзалт хийгээд ХӨСҮТ<sub>[Халдварт өвчин судлалын үндэсний төв]</sub>-ийн хашаанд баригдсан 6 давхар байранд манай эм шинжлэх лабораторийг оруулах зохицуулалтыг хийхээр хамтарсан уулзалт судалгаа хийгээд, одоо Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөх баг ажиллаад ажлын байрны зураг бүтцээ хийгээд одоо манай байрыг байрыг яг тэнд цогцоор нь лабораторийн байрны

дагуу зохицуулалт хийхээр бэлтгэл ажлуудыг хангаад явж байгаа гэсэн үг.

**Л.Энхнасан:** Тодруулга. 3 номерын микрофоныг өгнө үү.

**Т.Мөнхсайхан:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ер нь энэ эмийн лаборатори чинь өөрөө мэргэжлийн хяналтын харьяанд байсан лаборатори.

Тэгээд 2020 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн агентлаг байгуулах шийдвэрийг нь гаргаад хуулийн өөрчлөлтүүд ороод, энэ явцад энэ лабораторийг Эм, эмнэлгийн хэрэгслийнхээ агентлагийнхаа харьяанд авъя гэдэг шийдвэр гарсан юм.

Тэгэхээр манай Эрүүл мэндийн яамны харьяанд 2021 онд ирсэн гэсэн үг. Тэгээд ер нь энэ агентлагийн чиг үүрэг бусад улсуудад маш их өндөр байдаг.

Манай улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн агентлагийг байгуулснаараа эмийн чанар, аюулгүй байдал дээр ер нь нэг том ахиц гарсан.

Олон улсад үнэлэгдэх үнэлэмж сайжирсан гэсэн боловч өнөөдөр явуулж байгаа үйл ажиллагаа нь төдийлөн сайн болоогүй байна гэж харж байгаа.

Ингээд эмийн сонголтой холбоотой гарсан 38 дугаар тогтоолын дагуу маш олон үйл ажиллагаа, арга хэмжээнүүд бодит.../минут дуусав/

**Л.Энхнасан:** 1 минут нэмнэ үү. Микрофон 3.

**Т.Мөнхсайхан:** Эмийн сонголтой холбоотой гарсан 38 дугаар

тогтоолын дагуу ажлууд нэлээдгүй хийгдэж байна.

Үүн дээр нэгдүгээрт эмийг бид хил гаалиар орж ирсэн цагаас нь авхуулаад үнийг нь тодорхой байлгах, дээрээс нь хил гаалиар орж ирээд эцсийн хэрэглэгч хэн дээр оччихов гэдэг хүртэлх энэ бүртгэл мэдээллийг тодорхой болгоод ажлууд хийгдэж байна.

Хоёрдугаарт, нэгдсэн худалдан авалтууд зохион байгуулах, эмийн үнийн хэмжээг тогтоон барих энэ ажлууд маань ер нь нэлээдгүй гэрээ хэлэлцээрүүд хийгдээд явж байна.

Гуравдугаарт, дараагийн гол асуудал Эмийн зөвлөлийн асуудал.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу энэ дээр сонгон шалгаруулалтыг бид зарлахаар төлөвлөж байгаа.

Гэхдээ хуулийн хэрэгжилт маань 10 сарын 1-нээс.

Тийм учраас бид сонгон шалгаруулалтыг хэрхэн яаж явуулах вэ гэдэг энэ зүйлүүд дээрээ анхаарлаа хандуулаад 9 сарын 01-нээс явуулах, нээлттэй шалгаруулалт хийхээр төлөвлөж байгаа.

**Л.Энхнасан:** Тодруулга байхгүй байна лээ.

С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Манай Байнгын хорооны хамгийн чухал нийгмийн суурь үйлчилгээний нэг эрүүл мэндийн салбартай бид маш сайн танилцаж асуудлыг нь маш сайн судалж байж шийдвэрүүд гаргах ёстой.

Энэ тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Энэ бас нэлээн чухал олон жил хуримтлагдсан асуудлуудыг гаргаж ирсэн.

Гэхдээ бас дутуу хөтүү асуудал байсан.

Энэ эмийн юутай холбоотой. Эм төдийгүй эм, эмнэлгийн хэрэгслийг оруулж ирдэг ганцхан компани хүртэл тэрийг нь оруулж ирдэг.

Маш олон жил ингээд явчихсан.

Үндсэндээ бараг субботник хийдэг. Эрүүл мэндийн даатгалын тэр сангаас өгч байгаа мөнгөний ихэнх өртөг нь ерөөсөө л ганцхан тэр. Ялангуяа тэр мэс заслын хэрэгслүүдээр явчихдаг асуудлууд байсан.

Тэгээд үүнийг би тусад нь оруулж ирэх болов уу гэж бодож байна.

Өнөөдөр зөвхөн эмийн асуудал яригдаж байна гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, үүнтэй холбоотой ашиг сонирхол үүсгэсэн гээд байгаа хүмүүсийнхээ асуудлыг нэлээн сайн тодруулах хэрэгтэй шүү.

Үүний өмнөх Байнгын хороогоор янз бүрийн хүмүүсийг оруулж нэрийг нь зарлаад нийтэд тавьчихсан.

Тэрийгээ яаж шалгаруулсан юм, яаж сонгосон гэдэг нь тодорхойгүй.

Энэ дотор миний нэр хүртэл явж байсан. Чиний хамаатан садан гэдэг хүн дотор нэг тийм хамаарал бүхий хүн байна гээд. Би тэрийг хүртэл хайгаад олдоггүй. Тэгээд ингээд яваад байдаг.



Тэгэхээр хүмүүсийг бид энэ төрийн эрхийг олон нийтэд гаргахдаа хүний эрхийн асуудал. Өөрөөс нь ядаж тайлбар авах гэдэг юм уу ийм зүйлийг хийсний дараа олон нийт зарлахгүй бол үүнийг эргээд авч болдоггүй асар том аюултай. Цааш цаашдаа.

Дараагийн асуудал нь, хөдөө орон нутгаар манай Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийнхөн их явсан юм.

Тэгээд зарим аймаг, зарим сумууд дээр ерөөсөө ямар ч аптека байхгүй.

Би Хөвсгөл аймагт очсон. 20 сумд нь ерөөсөө аптека бараг байдаггүй. Нийгмийн даатгалынхаа үйлчилгээг авч чаддаггүй юм билээ.

Яг үүнтэй ижилхэн бараг ихэнх аймагт тийм.

Манай захын гэр хорооллуудад ч гэсэн олигтой сайн чанартай эм зардаг тийм аптекууд маш ховор.

Тэгэхээр **“20 минутын хот”** гээд бидний Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой хэлэхэд энэ хангамжийн асуудлыг нийтийн үүргийг зохицуулах хэрэгтэй байдаг юм билээ.

Өөрөөр хэлбэл томоохон эм бэлтгэн нийлүүлж байгаа компаниуд үүрэгжүүлж, ашиггүй байлаа ч гэсэн зарим цэгүүд дээр заавал байлгах гэдэг энэ тендер гэдэг юм уу, нийлүүлэлтийн юм дээр нь үүрэгжүүлж өгөх ёстой.

Нэмэлт бүтээгдэхүүнүүдийг хориглоно гээд тавьчихаж. Энэ дотор. Нөгөө сурталчлахыг.

Тэгээд үүнийг чинь хориглох нь байтугай бас бид чинь өөрсдөө аваад хүртэл хэрэглэхдэг.

Яагаад аваад хэрэглэхэв гэхээр эмч нар зөвлөөд байдаг байхгүй юу. Чи яг үүнийг хэрэглэ. Ийм эм байвал сайн. Одоо юу ч гэдэг юм.

Одоо ингээд хориглоод хаячихаар чинь манайд хэрвээ үнэхээр сурталчилгааг нь хориглож байгаа юм бол гааль, хилээр оруулж ирэхийг нь бүр хориглочих хэрэгтэй байхгүй юу.

Тэгэхгүй оруулаад ирчихсэн. Тодорхой хэмжээгээр бараг сүлжээний байдлаар манайд ажил амьдралаа залгуулдаг маш олон хүн байгаа.

Тэгэхдээ энэ замбараагаа алдаж байгаа нь үнэн. Зүгээр телевизээр хүн харж байгаад л энэ сайн гэнэ лээ гээд асар их мөнгөө зарцуулж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ асуудал дээр.

Тодруулга 1 минутаа авчихъя.

**Л.Энхнасан:** Тодруулгыг нь 1 минут.

**С.Эрдэнэбат:** Тэгэхээр шууд ингээд хориглоно гээд тавьчихаар Байнгын хорооныхон хоригло гээд тогтоол баталчихсан гээд маргаашаас авхуулаад энэ бөөн нийгмийн асуудал болох юм.

Тэгэхээр энэ тал дээрээ бас бид энэ тогтоолын тодорхой заалт байгаа учраас үүнийг шууд хориглох энэ тэр гэдэг асуудал байна.

Харин наана нь тэр хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэн оруулж ирээд байдаг юм. Манай Эмийн зөвлөл юу гэж үздэг юм. Энэ нь өөрөө яг батлагдсан юм уу, үгүй юм уу гэдэг ийм асуудлыг нь



тодорхой болгож байж бас шийдэх хэрэгтэй байгаа байх.

Ер нь цэгцлэх нь зөв гэж би харж байгаа.

Тэгээд эмийн зөвлөл. Ер нь энэ эмийг нь худалдаж аваад байгаа хүмүүс маань би ямар эм уугаад байгаа вэ гэдэг юмаа мэдээлэл авах. Энэ талаар нь тодорхой эмийн нийлүүлэгч компаниуд болон эмийн зөвлөл, эмч нарыг ч гэсэн тэр даатгуулагч нартай нь хамт уулзаж мэдээллээ авах, солилцох энэ боломжоор нь хангаж өгөх ийм шаардлага байгаа.

Тэгэхээр энэ дээр би тогтоолын төсөл дээр тийм зүйлийг бас оруулах ийм саналтай байна.

**Л.Энхнасан:** Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг өгнө үү. Асуултад хариулна уу.

**Ж.Чинбүрэн:** Тогтоолын төсөлтэй холбоотой хэдүүлээ ярьж байгаа гэж ойлгож байгаа.

Тогтоолын төсөлд бид биологи, нэмэлт бүтээгдэхүүнтэй холбоотой зар сурталчилгааны асуудал ерөөсөө ороогүй байгаа.

Хуульд орчихсон шүү дээ. Бүхэл бүтэн бүлэг болоод орчихсон.

Энэ чухал асуудал шүү. Тэгэхгүй бол нэг биологийн нэмэлт бүтээгдэхүүнийг хорт хавдар эмчилдэг гээд л сурталчлаад байдаг. Хүмүүсийг төөрөлдүүлээд л.

Тэгэхдээ энэ дээр бид зохицуулалт хийж өгч байгаа болохоос юуг сурталчлах вэ, юуг сурталчлахгүй байх вэ гэдэг л мэдээлэл орж байгаа.

Тийм учраас та хуулийг бас сайн харчхаарай.

Тийм учраас бид Их Хурлын индэр дээрээс биологийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүр оруулахыг нь больчих энэ тэр гэж хэлэхлээр бас энэ чинь арай л болохгүй байна шүү. Энэ жоохон үгээ бодож ярихгүй болохгүй.

Хоёр дахь зүйл нь хамаарал бүхий этгээдүүдийн тухай ярилаа.

Тэгэхээр нийтийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой тэр хуульд ямар хүмүүс нэгдмэл ашиг сонирхолтой байгаа вэ гэдгийг хуульд заагаад өгчихсэн.

Тухайлах юм бол тантай 10 жил цуг төгссөн хүн таны нэгдмэл ашиг сонирхолтой болно.

Та ямар нэг төрийн бус байгууллагын удирдах зөвлөлд байвал тантай цуг байгаа, Удирдах зөвлөлд байгаа улсууд нэгдмэл ашиг сонирхолтой болчихно.

Тэгэхээр хуулийн хүрээнд нэгдмэл ашиг сонирхолтой этгээдийн гэдэг нэр томьёон дотор хамаарал бүхий этгээдүүдийн нэр гарсан шүү. Би үүнийг танд олон удаа хэлсэн.

Тийм учраас одоо та Их Хурлын гишүүн болсон учраас “нэгдмэл ашиг сонирхолтой этгээд” гэдэг нэр томьёон дээр гишүүд Та бүхэн анхаарлаа хандуулж ажиллах нь зөв өө.

Хоёр дахь чухал зүйл бид Прокурорын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар хамаарал бүхий этгээдүүдийн нэрсүүдийг бүгдийг нь өгсөн.

Үүнийг өгдөг зорилго нь тухайн хамаарал бүхий компанийнхаа бүтээгдэхүүнүүдийн шийдвэр гаргахад оролцсон эсэхийг тодорхойлуулах гэж байгаа юм. Оролцсон эсэх.

Нэг ёсондоо ашиг сонирхолтой ажилласан уу, үгүй юү гэдгийг нь тодорхой болгоно.

Тэр нэр дурдагдсан хүн болгон ашиг сонирхлын зөрчлөө шийдвэр гаргасан гэсэн үг биш. Тийм ээ.

Тэгэхээр нэгдмэл ашиг сонирхолтой байдлыг нь шүүгээд үзэхээр тэр бараг 250 гаруй хүний нэрс нь гарсан. Дандаа удирдах албан тушаалын ажил хийж байгаа улсууд.

Тэгээд эдгээр улсууд шийдвэр гаргахад оролцсон эсэхийг бидэнд Авлигатай тэмцэх газар, Прокурорын Ерөнхий газар 11 сард тайлангаа өгөх байх.

**Л.Энхнасан:** Гишүүд өнөөдрийн батлах тогтоолтой холбоотой асуулт саналаа хэлнэ үү.

38 дугаар тогтоолын хэрэгжилтийг Байнгын хороонд 11 сард танилцуулна.

Тэр үед илүү дэлгэрэнгүй асуух боломжтой шүү.

М.Нарантуяа-Нарагийн микрофоныг өгнө үү.

**М.Нарантуяа-Нара:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Ер нь яг миний асуух гэж байсан зүйлсүүд сая яригдчихлаа.

Яагаад гэвэл эрүүл мэндийн эм, эмийн бүтээгдэхүүний, ялангуяа эм

ханган нийлүүлэх байгууллагын хувьд иргэдийн дунд асар их санал гомдол байдаг. Тийм ээ.

Энэ яадаг вэ гэхээр ихэвчлэн эм ханган нийлүүлэх газрын зөвшөөрөл төрийн холбоо хамаарал бүхий этгээдүүдэд гардаг.

Энд маш ярвигтай. Тийм ээ. Жирийн нэг иргэн хүн эрхлээд аваад явахад аягүй боломжгүй ийм шат дараалалтай, хүнд сурталтай ийм зүйл байдаг гээд яригддаг. Тийм ээ.

Сая Ж.Чинбүрэн гишүүн хэллээ шүү дээ.

Эм оруулж ирэхдээ бөөний үнэ нь анхны үнэ гаалиар хэдэн төгрөгөөр оруулж ирсэн юм бэ гэдгээ одоогоор бүртгэл тодорхой биш байна гэж байна.

Энэ бүртгэл тодорхой биш байгааг хэн хийж чадах вэ? Иргэн хүн юу ч оруулж ирсэн тэр иргэний бүтээгдэхүүн. Тийм ээ. Бараа, бүтээгдэхүүнийг шалгаад хэдэн төгрөгийн үнэ өртөгтэй юм. Түүнд нь бараг зарим тохиолдолд үндсэн үнээс нь давсан татварын төлбөр ногдуулдаг, нэхэмжилдэг ийм үзэгдэл манай Монгол Улсад байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг хэн хийж чадах вэ?

Төрийн холбоо хамаарал бүхий этгээдүүдийн хийж байгаа хүмүүс л ийм зүйлийг хийж чадна шүү дээ. Тийм ээ. Тийм биз дээ.

Тэгэхээр иргэн хүн бол зүгээр нэг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн бараг хүүхдэдээ бариад ороод ороод ирэхэд л хэдэн ширхгээс дээш вэ гэдэг дээрээ хяналт шалгалтын байгууллагаар ордог.

Тэгэхээр энэ бол сая Ж.Чинбүрэн сайд. Гишүүн өөрөө хэллээ.

Сайд байсан болохоор нь сайд гэгчихлээ.

Тэгээд энэ бол үнэхээр эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн энэ эм эмнэлгийн бүтээгдэхүүний асуудал үнэхээр тодорхой хэмжээгээр төрийн холбоо хамааралтай байдаг гэсэн энэ иргэдийн санал гомдол нь үнэний ортой байдаг юм байна гэдгийг би бас олж мэдлээ.

Тэгээд энэ тогтоолын тухай учраас ингээд юу яая.

Дараагийн асуудал дээр бас тодруулах зүйлсүүд байгаа.

Тэгээд ямар ч байсан ялангуяа эмийн асуудал дээр би яг ингэж бодож асууя гэж бодсон. Бараг өөрсдөө сая зөндөө тодруулаад ярьчихсан учраас иргэд олон нийт болон бас энд байгаа гишүүд мэдэж авсан байх гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** М.Нарантуяа-Нарагийн асуулт биш, санал гэж ойлголоо.

Асуулт дууссан учраас санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Үүрийнтуяа гишүүнийг оруулна уу. Д.Үүрийнтуяагаар тасаллаа.

Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Тогтоол дээр өнөөдөр батлах тухай асуудал яригдаж байна. Авах арга хэмжээний тухай, хэрэгжилтийг хангахтай холбоотой.

Энэ дээр нэг л санал байна л даа. Дандаа л хуультай холбоотой, эрх зүйн орчинтой холбоотой асуудлуудаа яриад байдаг.

Гэтэл хяналт шалгалтын хийсэн нөхцөл байдалтай холбогдуулаад авах арга хэмжээний тухай 2024 оны 5 сарын 02-ны өдрийн тогтоол дээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулах, хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хугацаатай үүрэг даалгавар өгөх гээд.

Яг эмийг хэрэглэж байгаа хэрэглэгчидтэй холбоотой асуудлууд ерөөсөө Улсын Их Хурлын тогтоол дээр орж ирэхгүй байна л даа.

Тэгээд би үүнийг чухал гэж бодож байгаа юм.

Бид өнөөдөр ямар эм авч хэрэглэх вэ гэдэг нь хувь хүний сонголт нэг талдаа мэт боловч нөгөө талдаа бид эрүүл мэндийн боловсролгүйгээсээ болоод энэ дээр буруу эм тариа хэрэглэх асуудлууд үүсчэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг тогтоол дээр, ялангуяа эрүүл мэндийн боловсрол олгох чиглэл дээр нь Улсын Их Хурлын тогтоол дээр бас нэг заалт оруулж өгөөч ээ гэдэг ийм санал тавих гэсэн юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээнэ үү.

**С.Эрдэнэбат:** Тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Түрүүн бас Б.Бат-Эрдэнэ гишүүн хэллээ.

Иргэдийн эмийн талаарх санал хүсэлтийг нь ер нь “Эрсдэлтэй эмийн санал” гээд аптект хүмүүс нэг бичгээ хийдэг. Ихэнх нь бараг хийдэггүй дээ. Ойлгох ч үгүй. Тэрийг.

Энэ тал дээр иргэдийн маш их санал хэлдэг юм билээ. Хүмүүс уг нь.

Сая сонгуулиар энд тэнд явж байхад тэр даралтын эм гээд “Новартис” гээд хөтөлбөрөөр орж ирж байгаа үнэгүй тараагдаж байгаа эм байгаа.

Надад таарахгүй байна, болохгүй байна, миний юуг хөдөлгөөд байна. Тэгээд нөгөө даралтын эмээ авъя гэхээр хөнгөлөлтөөс хасаад хаячихсан гээд.

Тэгэхээр энэ мэтийг нь бид яаралтай аваад судлаад, сурталчлаад, тэр хүмүүстэйгээ уулзаад гэдэг юм уу, иргэдийн чөлөөтэй саналаа өгдөг, түүнийг нь авч хэрэгжүүлдэг тэр механизмыг нь ил тод тодорхой болгох тал дээр тогтоолын төсөл дээр оруулаад өгвөл зүгээр байна.

Түрүүний хэлсэн. Ж.Чинбүрэн гишүүн ээ.

Тэр 10 дугаар заалт дээр тавьчихсан байгаа учраас яах вэ би буруу ойлгосон байж магадгүй.

Монгол Улсад бүртгэгдээгүй эмийг сурталчлахыг хориглоно гэхээр чинь нэг логикийн хувьд зөрчилтэй болчихоод байгаа байхгүй юу.

Бүртгэгдээгүй эмийг оруулж ирэх нь өөрөө угаасаа буруу биз дээ.

Тийм учраас бүр тэрийг угаасаа оруулж ирэхгүй байх гэдэг. Хэрвээ оруулж ирэх шаардлагатай бол түүнийг нь тэр эмийн зөвлөлөөр гэдэг юм уу оруулж ирэх ийм зүйл байхгүй бол.

Яг үнэнийг хэлэхэд нууцаар гэдэг юм уу, хулгайгаар гэдэг юм уу оруулаад ирчихсэн тийм зөвшөөрөгдөөд оруулаад ирчихсэн эмүүдийг нь сурталчилж болохгүй гэдэг. Оруулаад ирчихсэн бол зүгээр нууцаар зарж болно, сурталчлахгүйгээр зарж болно гэдэг ийм хуулийн юу ойлгогдоод байгаа учраас би үүнийг засвал яасан юм бэ?

Үүний өмнөх Их Хурлын тогтоол яваад байгаа. Энэ дээрээ жоохон өөрчлөлт хийвэл яасан юм бэ гэдэг утгаар нь хэлсэн шүү гэдгийг хэлмээр байна.

Тэр ашиг сонирхлын зөрчилтэй этгээдтэй холбоотой. Яах вэ би дараа нь ярья. Үүнтэй яг шууд холбоогүй учраас.

10 жил хамт цэцэрлэгт явж байсан энэ тэр гээд. Тэр нь чамтай хамаатай гээд яваад байвал энэ өөрөө их замбараагүй балай юм болно л доо. Тэр чинь. Тийм ээ.

Тэгэхээр хэдүүлээ үүнийг бас харах хэрэгтэй юм байна лээ. Тийм.

Энэ Эмийн зөвлөл дээр ярьж байгаа асуудлуудаа, зарим үйл ажиллагааг ил болговол яадаг юм. Олон нийтэд хэрэгцээтэй нээлттэй байгаа бол тэр чинь өөрөө боловсрол байхгүй юу.

Тэгэхгүй манайхан чинь нууцаар нэг зөвлөл хуралддаг юм шиг байгаа юм.

Тэгээд нэг орсон болно, болохгүй гээд тавьчихдаг. Тэгээд үүний цаана нэлээн асуудал байдаг юм шиг байгаа юм.

Тэгэхээр би дараагийн ээлжид Байнгын хороонд ч гэсэн тэр ЭМДҮЗ[Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл]-ийн санал дотор би хэлж байсан. Зарим зөвлөл, зарим эрх бүхий тийм чухал олон нийттэй холбоотой шийдвэр гаргах юмнуудыг нээлттэй ил тод болгох тэр зүйлүүд дээр нь энэ тогтоолоор бас үүрэгжүүлж өгвөл зөв байх юм болов уу гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Би гишүүддээ дахиад тодруулаад хэлчихье ээ гэж бодож байна.

Одоо бид нарын энэ батлах гэж байгаа тогтоолын төсөл маань энэ эмийн чанарын асуудалтай холбоотой.

Энэ үнийг хянах зохицуулалт ерөөсөө хоёр амин сүнс, чухал зүйлийг нь эрчимжүүлж өгөхөөр л тогтоол дээрээ нэмэлт хэлж өгч байгаа юм.

Өмнөх 5 сарын 20 хэдэнд баталсан тогтоол маань хүчинтэй явж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэр дотор заасан зүйлүүдийн тайланг бид 11 сард тэртээ тэргүй сонсоно оо.

Тийм учраас одоо улам эрчимжүүлж 10 сарын 01-нээс хууль хэрэгжих гэж байгаатай холбоотой ерөөсөө **эмийн “чанар”, “үнэ” хоёрыг хянах хоёрхон чухал зүйл байгаа** юм.

Энэ би эмийн сонсголыг хийх гэж олон сараар суусныг хүний хувьд мэдэж байгаа зүйл бид үнийг ил болгох ёстой.

Чанарыг сайжруулахын тулд өндөр хөгжилтэй ижил байгууллагуудтай

хамтын ажиллагааны гэрээ хийгээд Монгол Улсад нэмэгдэл үнэтэй биш, боломжийн үнээр орж ирэх энэ зохицуулалтын хоёр механизмыг яаравчлаарай л гэж үүрэгдэж байгаа юм шүү. Тэгж ойлгож болох юм шүү.

Тийм учраас эрхэм гишүүд Та бүхэн 11 сард бүхэл бүтэн тогтоолтой холбоотой тайланг Эрүүл мэндийн яамнаас сонсох юм.

**Л.Энхнасан:** А.Ариунзаяагийн микрофоныг өгнө үү.

**А.Ариунзаяа:** Юуны өмнө эмийн чанартай холбоотой, эмийн хяналттай холбоотой үндэсний аюулт үзэгдлийн гэдэг юм уу, асуудлаар сонсгол зохион байгуулж, энэ асуудлыг үндэсний хэмжээнд маш томоор гаргаж ирсэн Ж.Чинбүрэн гишүүндээ нэн тэргүүнд талархлаа дэвшүүлмээр байна.

Үнэхээр энэ бол маш анхаарах ёстой асуудал мөнөөс мөн.

Т.Мөнхсайхан сайддаа бас ажлын амжилт хүсмээр байна.

Бид ковидын үед хамт ажиллаж байсан. Эрүүл мэндийн сайдаар яг ковидын үед үнэхээрийн маш сайн ажилласан.

Эрүүл мэндийн сайдаар ажилласан туршлагатай учраас одоо ажилтай танилцаад байх шаардлага байхгүй.

Маш шуурхай ажилдаа орно гэдэгт итгэлтэй байна.

Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж байсан хүний хувьд бас томоор салбарын хувьд харж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Зүгээр яг энэ тогтоолын төсөлтэй холбоотой 1 дүгээр зүйлийн 3 гэх юм уу, энэ даалгавруудын 3-т байгаа эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар судлан санал танилцуулах гэсэн хэсэг дээр миний хувийн санал маань энэ Эмийн хяналтын агентлаг маань өөрөө Эрүүл мэндийн яамны зүгээр нэг жижиг харьяа байхаар

- төсвийн хувьд ч тэр,
- лабораторийн хувьд ч тэр,
- эрх мэдлийн хувьд ч тэр

арай жоохон боломгүй багадаад байгаа юм биш үү.

Үүнийг үндэснийхээ хэмжээнд жоохон томруулбал яасан юм бэ?

Эмийн зөвшөөрөл өгдөг, эмээ боловсруулдаг байгууллагынхаа буюу дээд харьяа байгууллагынхаа, тэгээд Эрүүл мэндийн яам өөрөө

- эмийн зөвшөөрөл өгч байна,
- эрүүл мэндийн эмийн сангуудын зөвшөөрлийг өгч байна.

Энэ байгууллагыг доор нь байгаа агентлаг үйл ажиллагааг хянана гэдэг бол өөрөө бас эрх мэдлийн хувьд ч гэсэн арай сул юм.

Ийм учраас үндэсний хэмжээнд энэ агентлагаа томруулаад. Мөн дээрээс нь хүнсний хяналтын асуудлыг оруулаад.

Америкийн **FDA** буюу **THE FOOD AND DRUG ADMINISTRATION** буюу арай илүү том энэ үндэсний хэмжээнд нь авч үзвэл илүү зөв зохистой юм биш үү гэдэг ийм миний санал байна.

Ийм учраас энэ 3 дугаар заалт дээр орж ирж байгаа. Энэ талаар судлан

танилцуулах асуудалд энэ асуудлыг бас зөвөөр харж яамныхаа эрх ашиг, яамны агентлагийн эрх ашиг биш, үндэснийхээ хэмжээнд нэг томоор харж бас санал боловсруулаасай гэсэн ийм хүсэлттэй байна. Баярлалаа.

Амжилт хүсье.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Б.Бейсен гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Бейсен:** Энэ эмийн асуудал яах аргагүй чухал асуудал байна л даа.

Үндсэн аюулгүй байдалтай холбоотой.

Тэгээд сая сайд ч ярьж байна. Тэр эмийн хоруу чанар шалгах лабораторийг чанаржуулж, тоног төхөөрөмжөөр хангах асуудал байгаа. Энэ дээр бас анхаарч ажиллана биз.

Нөгөө талаар сум, багийн түвшин дэх эмийн сангийн асуудлыг анхаарахгүй бол хөнгөлөлттэй эмийг ерөөсөө авч чадахгүй байна. Эм маш үнэтэй байна.

Жишээлбэл, Эм, эмнэлгийн хэрэгслийн газар гаргаж өгсөн юм.

→ Гааль 8-аас 15 хувийн татвар оногдуулаад, тэрний НӨАТ гээд 10 хувь.

→ Эм ханган нийлүүлэх байгууллагууд 25-аас 35 хувь нэмээд, тэрний НӨАТ гээд 10 хувь байгаа.

→ Эмийн сангууд чинь бас 35-аас 40 хувь нэмээд л, тэрний НӨАТ гээд 10 хувь байгаа.



Гэтэл эмийн үнэ өссөн үү. 2020, 2021, 2022, 2023 онд нэлээн өссөн.

Монгол Улсын Засгийн газар тухайн үеийн Эрүүл мэндийн яам бас энэ дээр анхаараад л халаалтын зардал, цахилгаан, нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ, хувь хүний орлогын албан татвар, байрны түрээс, хөнгөлөлттэй зээл, тэгээд ажил олгогчийн батлан шимтгэл гэх мэт.

Гаалиас бүгдээс нь чөлөөлсөн шүү дээ.

Чөлөөлсөөр байтал эмийн үнийг зориуд нэмсэн, зарим эм ханган нийлүүлэх байгууллагууд дээр хариуцлага тооцохгүй бол эмийн үнийн өсөлт нь хотын клиникийн эмнэлгүүд болон аймгийн эмнэлгүүд дээр, Эрүүл мэндийн даатгалын санд эргэж нөлөөлөөд байгаа байхгүй юу.

Энэ дээр Эрүүл мэндийн сайд нэлээн анхаараад. Бид ч хамтаръя.

Эмнэлгүүдийн төсөв харж байхад бүр үнэ нэмэгдчихсэн. Зарим нь бүр оруулж өгөөд хаалттай систем гэдгээр маш өндөр үнээр шахдаг.

Энэ дээр анхаарахгүй бол эрүүл мэндийн салбарын маань төсөв нэлээн явж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын газар яах вэ журмын дагуу ажиллаж байгаа л даа.

Гэтэл Эрүүл мэндийн даатгалын газар төсөв өгөхгүй байгаа юм шиг ойлгуулдаг. Цаад жинхэнэ хөшүүрэг нь та нар хараарай. Аймгийн төв, тэгээд Улаанбаатар хотод бөөгнөрсөн аптекуудаа хар.

Сум, багийн түвшинд юу ч байхгүй.

Энэ дээр ер нь эрүүл мэндээ Монгол Улсын Засгийн газар ер нь анхаарч ажиллахгүй бол болохгүй асуудлууд байгаа.

Сая Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын байрны асуудлыг бас энд тусгахгүй бол жирийн юун дээр чинь зөндөө юм барьж байна шүү дээ. Тэгээд энэ чинь Монгол Улсын үндсэн аюулгүй байдалтай холбоотой том агентлаг шүү дээ.

Тэнд ажиллаж байгаа улсуудыг бас мэргэжлийн хувьд шалгаруулж авахгүй бол бас бид очоод бүр бүх шургуулгыг нь татаад үзээд, аппаратуудыг нь онгойлгож байгаад үзсэн.

Тэрийгээ ч цэвэрлэчихгүй. Тэгээд дотор нь сууж байдаг. Зарим нь эвдэрчихсэн. Зарим тоног төхөөрөмж нь ажиллахгүй.

Энд Эрүүл мэнд яам, бас Нийгмийн бодлогын байнгын хороо анхаарлаа хандуулаад дахиж үүнийг нь үзээд Засгийн газарт зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг нь авч өгөх тал дээр анхаараад сум, багийн түвшинд.

Уг нь аптекийг хувьчилснаар аймгийн төвд бүгдэд нь зориудын складтай агуулахуудтай эмийн сан байсан шүү дээ. Үүнийг хувьчилчихсан. Тэгээд л зарагдсан. Зарим нь байж байгаа.

Тэгэхээр ийм юман дээр анхаарахгүй бол одоогийн эм ханган нийлүүлэлт байгууллага зөвхөн тендер дээр тоолоод л асар баяжчихсан. Тэгсэн мөртөө ард иргэдэд өндөр үнээр эм шахдаг асуудлууд байж байгаа.

Тэгэхээр энэ дээр бас эрүүл мэндээ Монгол Улсын Засгийн газар анхаарах цаг нь болсон гэж үзэж байна.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Х.Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

**Х.Булгантуяа:** Эмийн асуудал яг тулгамдсан асуудлын нэг болсон.

2018 онд Эрүүл мэндийн даатгалыг хуучин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгал хамтдаа байсан.

2018 онд Эрүүл мэндийн даатгалыг тусад нь гаргахад 500 хүрэхгүй тэрбум төгрөгийн төсөвтэй байсан. Эрүүл мэндийн даатгалын сан.

Одоо энэ жил 2 их наяд гаруй төгрөгийн төсөвтэй болсон. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд 4 дахин нэмэгдсэн мөртөө

→ эмч нарын цалин энэ хугацаанд 4 дахин нэмэгдсэн үү гэвэл үгүй,

→ эрүүл мэндийн үйлчилгээ 4 дахин сайжирсан уу гэвэл үгүй.

Тэгээд энэ хоорондуур энэ 4 дахин нэмэгдсэн Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоор бодвол энэ эмийн салбар нь байдаг юм уу, эсвэл тааруухан менежмент хийгээд байдаг юм уу. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгө.

Нэг л байгаа онохгүй төдийгөөс өдий болтол явж байгаа.

Энэ бол уг нь шимтгэл төлж байгаа бүх хүмүүсийн л мөнгө байгаа юм.

Тэгээд би ийм хэдэн зүйлүүдийг хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт, анх энэ агентлагийг байгуулахад манай төрийн байгууллагынхан нэг тэгдэг.

Нэг бүтэц байгуулахаар л асуудал шийдэгдэнэ гээд.

Тэгээд Эм, эмийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар гээд 132 хүний орон тоотой. Энэ бол яамнаас том.

Манай зарим бодлогын яамд үүнээс хамаагүй цөөхөн хүнтэй гээд л Та бүхэн бодчих.

132 хүнтэй байгаа мөртөө одоо энэ байгууллагаас, агентлагаас ер нь асуудлаа өөрсдөө Улсын Их Хуралд оруулаад танилцуулаад Нийгмийн бодлогын байнгын хороонд энэ эм, эмийн хэрэгслийн асуудлаар өөрсдөө ахиц дэвшил гаргая гэж явж байгааг би ер нь сонссонгүй.

Аргаа бараад Ж.Чинбүрэн гишүүн өөрөө санаачилгыг гаргаад сонгол хийгээд явж байна гэдэг бол учир дутагдалтай байна.

Дээрээс нь бүтэц зохион байгуулалт нь болохгүй байна гэхээсээ илүүтэйгээр “эм, эмийн хэрэгслээ” хянаж чадахгүй байгаа дээр ахиад “хүнс” өгвөл бүр долоон доор болох байлгүй дээ.

Эхлээд эм, эмийн хэрэгслээ хянах шалгах дээрээ сайжраад, дараагийн алхам нь магадгүй үнэхээр ахиц дэвшил гаргах бол тэр Америкийн **THE FOOD AND DRUG ADMINISTRATION** шиг болж болох байх гэж бодож байна.



Эрүүл мэндийн сайдыг байгаа дээр хэд хэдэн зүйлүүдийг асуух гэсэн юм.

Нэгдүгээрт манай Баянзүрх дээр гуравдугаар шатлалын эмнэлгүүд нэлээдгүй байдаг.

Гуравдугаар шатлалын эмнэлгүүд маань Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтүүдээ авч чадахгүй байна. Авсан санхүүжилт нь тогтсон тарифаараа бид цалингаа тавьж чадахгүй байна гэдэг асуудлуудыг нэлээдгүй тавьж байгаа.

Энэ асуудлыг нэгдүгээрт яах вэ?

Хоёрдугаарт, эрүүл мэндийн.

Энэ чинь санал хэлэх дээр. Тийм ээ. Энэ дээр анхаараарай.

Ж.Чинбүрэн гишүүн, Баянзүрх дүүргээс сонгогдсон гишүүн бид энэ асуудлаар тантай тусгайлан уулзъя.

Ер нь эрүүл мэндийн салбарыг зах зээл шийднэ гэдэг зарчмаар хаяж болохгүй нэг жишээ бол яг саяын энэ аптекийн асуудал, эмийн асуудал.

Дээрээс нь нэмээд манай орон нутагт ийм асуудлыг яриад байна.

Нийгмийн бодлогын байнгын хороо маш олон эмэгтэй гишүүдтэй болж байгаа учраас.

Зарим сум нь. Түрүүн манай Б.Бейсен гишүүн хэлж байна. Аптек байхгүй гээд.

Нөгөөдөх нь, шүдний эмч ерөөсөө байхгүй гэдэг асуудал.

Ингээд хэдхэн хүнтэй сум дээр шүдний эмнэлэг ажиллуулаад ч энэ нь эдийн засгийн хувьд юугүй учраас үүнийг төрөөс анхаарч үзэхгүй бол Монгол Улсын ялангуяа гуравны нэгийг бүрдүүлж байгаа хүүхдүүд маань шүдээ эмчлүүлэх гээд л аймгийн төв явж байна гэж бараг байхгүй болчихоод байна. Энэ асуудал дээрээ анхаараач ээ гэж байгаа.

Тэгээд эрүүл мэндийн салбар дээр өнгөрсөн хугацаанд бид нэлээдгүй реформ хийхээр төсөв санхүүжилт, эрх зүйн орчныг нь ч гэсэн сайжруулсан.

Тэгэхдээ төсвөөр бүх асуудал шийдэгддэггүй гэдгийн том жишээ бол манай одоо яг энэ эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын асуудал болж гарч ирж байна.

Тийм учраас Та бүхэн маань энэ дээрээ, одоо Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан сайд өөрөө яг ковидын үед үүнийг хамгийн их мэдэрсэн.

Тийм учраас маш их санаачилгатайгаар өөрсдөө асуудлуудаа удаа дараа оруулж ирээд төсөв санхүүжилт нь болохгүй байгаа юм уу, тогтолцоо нь болохгүй байгаа юм уу.

Уг нь Их Хурлын гишүүд ингээд л энэ төрийн байгууллагуудыг авчирч ирээд л, загнаад л, зандраад л, шалгаад л байж байж энэ асуудлыг шийддэг.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэг минутаа авах уу, байхгүй юу.

М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгнө үү. Гишүүний.

**М.Нарантуяа-Нара:** Энэ тогтоол дээр ерөнхийдөө эмийн чанар, үнийн

зохицуулалтыг л хангах зорилгоор гарсан гэж байгаа.

Гэхдээ хамгийн гол нь. Түрүүн Ж.Чинбүрэн гишүүн хэлж байна.

Энэ тогтоол дээр хоёр орны. Жишээлбэл, олон улсад чанар, стандарт, шаардлагыг хангаж байгаа тэр чанартай сайн эмийг тийм ээ, одоо энэ Монгол Улсад нэвтрүүлэе гэж байна шүү дээ.

Гэтэл үүнийг улс ингээд хоёр улсын хоорондын харилцаагаар ийм байна гээд тодруулчихдаг.

Гэтэл энэ тодруулсан эмийн бүтээгдэхүүнийг ямар байгууллага, хувийн хэвшил наашаа оруулж ирэх вэ. Улс өөрөө оруулж ирэх юм уу.

Энэ өөрөө эрүүл мэндийн салбарын эм ханган нийлүүлэх бизнес дээр хувийн хэвшлийн оролцоог дэмжих ийм нөхцөлийг аягүй сайн хангаж ажиллах хэрэгтэй.

Ер нь ингээд нэг боломжийг төрүүлээд мэдчихээрээ тэр боломжийг хамгийн түрүүнд мэдсэн хүмүүсийн холбоо хамаарлын хүмүүс л тэр боломжийг оруулаад ирдэг. Энэ яг үнэндээ байдаг л асуудал.

Тэгэхээр энэ дээр яг мөрөөрөө мөчгөрөөрөө тийм ээ, үнэхээр зүрх сэтгэлээрээ хийж байгаа энэ хувийн хэвشلүүдийн оролцоог нээлттэй байлгах энэ зохицуулалтыг аягүй сайн хангаасай гэж хүсэж байна.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Баясгалан:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр энд маш зөв асуудал хөндөгдөж орж ирлээ.

Тэгээд энэ асуудлыг хөндсөн Их Хурлын гишүүддээ, Ж.Чинбүрэн гишүүндээ маш их баярлалаа.

Тэгээд яагаад вэ гэхээр би одоо өөрөө үнэхээр эмийн маш их өндөр хэрэглээтэй.

Ер нь Монголын ард түмний нийт 98 орчим хувь нь эмээс ямар нэг хамааралтай л байгаа шүү дээ. Ямар нэг эм уудаг. Тийм ээ.

Тэгээд 100 хувь ерөөсөө өвчний тохиолдолд заавал уудаг. 98 хувь нь байнга ингээд л нэг юм хэрэглэж байдаг.

Миний хувьд маш олон эм уудаг байсан. Тэгээд Монголын эмийн бүртгэлд ерөөсөө байдаггүй эмүүд маань.

Ингээд эмийн бүртгэлд байхгүй болохоор би өвдөөд үхэх, эсвэл гаднаас эм оруулж ирэх шаардлага гардаг.

Гаднаас хувийнхаа хэрэглээний эмийг. Мэдээж байнга яваад байж чадахгүй. Нэг яваад ахиу хэмжээтэй оруулаад ирэнгүүт хил гааль дээр ирэхээр дахиад л нөгөө асуудал үүснэ.

Монгол Улсын эмийн бүртгэлд байхгүй эм оруулж ирлээ.

Хоёрдугаарт, миний уудаг эмүүд, би бол өөрөө нугасны гэмтэлтэй учраас дандаа хүнд төрлийн эмүүд байдаг.

Одоо нөгөө өвчин намдаах эмүүд маань. Тийм ээ. Одоо сүүлийн үед хүүхдүүд маш их хэрэглэж байгаа нөгөө **Pregabalin** гээд эм байна, **Seduxen** байна, **Gebantin** байна.

Ингээд энэ эмүүдийг авахын тулд маш олон дамжлага дамжина.

Заавал эмч дээрээ очиж хуруугаа уншуулаад нөгөө эмээ бичүүлж авдаг байлаа.

Жорын цаас авна. Жорын цаас заавал канттай байх ёстой. Тэрийг эмч болгон бичиж өгөхгүй.

Ингээд үүнийгээ эмийн санд аваачаад өгнө.

Гэтэл миний өвчний хэрэглээ маань өндөр байдаг. Монгол Улсын стандартаар тэр нь бага хэмжээгээр олгохоор тусгагдчихсан байдаг.

Ингээд л дахиад л энэ дээр асуудал үүсдэг юм.

Одоо сүүлийн жишээ гэхэд л би энэ **Pregabalin** гээд эмээ хайгаад долоо хонож байна шүү дээ.

Ерөөсөө Монгол Улсад орж ирээгүй. Ийм болохоор ерөөсөө хүнд байдаг.

Тэгээд энэ эмийн чанарын хамгийн гол асуудлын жишээ болж байгаа хүн бол би.

Монголоос эмээ аваад уухад тунгаа хоёр дахин нэмэх шаардлага гардаг шүү. Ерөөсөө. Тэгж байж үйлчилдэг.

Гэтэл гадагшаа яваад долоо хоноход тэндээс авч уусан эм маань яг тэр тунгийн 50 хувиар байхад хамаагүй илүү үйлчилгээтэй байдаг.

Өвчин хамаагүй багасдаг. Тэр үед л ёстой нөгөө Монгол Улсын иргэн болж

төрсөндөө заримдаа харамсах сэтгэл төртөл энэ дарамт үүсдэг.

Энэ тэгэхээр нийт Монголын ард түмэнд байгаа дарамт. Энэ өвчнөөс шалтгаалаад хэчнээн хүн энэ хорвоог орхиж байгаа. Тийм биз дээ.

Тэгэхээр энэ дээр чанаргүй эм ууснаас болж.

Стандартаар тэр чинь яг л нөгөө юугаараа л ууна шүү дээ. Эмчийн бичиж өгсөн жорын дагуу тэр таблетаар ууна.

Гэтэл тэр таблетик нь өөрөө стандартад нийцэхгүй болохоор энэ хамгийн гол асуудал.

Тийм болохоор энэ дээр ерөөсөө маш нарийн яваад, одоо тэр дараагийн хяналт шалгалтын дүн 11 сард гарах юм байна шүү дээ.

Тэрний дараа дахиад энэ дээр Улсын Их Хурал маш их нарийн ярилцах байх.

Манай Байнгын хороог энэ дээр онцгой анхаарал тавиасай гэж хүсэж байна.

Эмийн чанар үнэхээр муу байгаа шүү гэдгийг хэлье.

Тэгээд энэ асуудлыг хөндөж оруулж ирсэн гишүүддээ маш их Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгнө үү.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа.

Нийгэмд тулгамдаад байгаа эмийн асуудалтай холбоотой энэ чухал сэдвийг

хөндөж, мэргэжлийн хүний хувьд амаргүй сонголыг зохион байгуулж хийсэн Ж.Чинбүрэн гишүүнд баярлалаа гэж хэлмээр байна.

Энэ шалгалтын үр дүнгээр өмнө нь Улсын Их Хурлын 38 дугаар тогтоол гарсан.

Тэгэхээр энэ тогтоол дээр нэг бүрчлэн хийж хэрэгжүүлэх Засгийн газрын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгаж өгсөн байна л даа.

Намрын чуулган эхлэхээр намрын чуулганаар Байнгын хороонд энэ тогтоолын биелэлтийг нэг бүрчлэн танилцуулахыг даалгасан байгаа юм.

Дахин тогтоол гаргах хэрэгцээ шаардлагыг Та тодруулж хэлж байх шиг байна.

Энэ дээр магадгүй бид дахин тодруулга хийж, дахин үүрэг чиглэлийг эрчимжүүлэх зорилгоор дахин тогтоол гаргалаа гэхэд өмнөх тогтоолд ороогүй асуудлыг тусгах юм уу, эсвэл өмнөх тогтоолд туссан зарим нэг засаж залруулах шаардлагатай асуудлаа оруулах юм бол дахин тогтоол гарч байгаа ач холбогдол байх болов уу гэж харагдаж байна.

Яг энэ тогтоолын эхний заалт их чухал ач холбогдолтой юм байна гэж ойлгож байна.

Хоёр дахь заалт үндсэндээ 38 дугаар тогтоолынхоо 2, 3-тай яг давхардаж байна гэж харж байна.

Тэгэхээр 2, 3 дугаар заалтынхаа 38.2, 3 дугаар заалтын хэрэгжилтийг бид хянаж үзээгүй, дүгнээгүй байгаа нөхцөлд дахин тогтоолд оруулах нь хэр оновчтой юм болоо. Үүнийг бас нэг эргэж үзээч.

Нөгөө талаар өмнөх тогтоол дээр бас асуудалтай зүйл байгаа бол бид дахин тогтоол гаргаж байгаагийн хэрэг юу билээ. Түүнийгээ залруулаад явах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Би 38 дугаар тогтоолын 10 дахь заалттай С.Эрдэнэбат даргатай гишүүнтэй санал нэг байгаа.

Бүртгэлгүй гэж байгаа шүү дээ. Энэ дээр тодотгоод хэлчихсэн байгаа. Тийм ээ.

Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлахыг хориглоно гээд заачихсан нь бүртгэлгүй эмийг сурталчилж болохгүй. Оруулж ирж болно. Сурталчлахгүйгээр зарж болно гэж байгаа юм шиг л ойлгогдоод байна л даа.

Тийм болохоор бүртгэлгүй л бол оруулж ч болохгүй, сурталчилж ч болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр харин ийм заалт нь ийм агуулгаар ойлгогдохоор байгаа дээр засвар хийвэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тайлбар өгөх үү? П.Оюунцэцэг дарга. 4 номерын микрофоныг өгнө үү.

**П.Оюунцэцэг:** Саяхан батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр эмийн зар сурталчилгааны талаар бүхэл бүтэн нэг бүлэг орсон байгаа.

Тэгэхээр эмийн зар сурталчилгааны асуудал дээр зөвхөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хүртэл эмийг

сурталчлах асуудлыг бид хориглосон байгаа.

Зөвхөн эмч, төлөөлөгчийн газрын эм барих зөвшөөрөлтэй хүнээр эм эмнэлгийн хэрэгслийн бүтээгдэхүүнүүдийг сурталчлах эрхийг нь өгсөн ийм хязгаарлалттай зүйлүүдийг бид хуульд оруулаад өгсөн байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр байгаа гишүүдийн саналтай санал нэг байна.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Асуултаа асууж үг хэлж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар

авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт хийе. /алх цохив/

Б.Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэнээр оруулна уу.

Тогтоол маань 68.4 хувьтай дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн чуулганы нэгдсэн хуралд танилцуулахыг хүсье.

Одоо хуралдааны нэгдүгээр асуудалд оръё.

---

**Хоёр. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,

**анхны хэлэлцүүлэг,**

Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

---

Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Ажлын хэсгийг оруулаарай.

Ажлын хэсгээ танилцуулья.

Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваанямбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Очиржавын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Лхагвасүрэнгийн

Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Цэрэндоржийн Эрдэнэбат Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын зөвлөх, Пүрэвжавын Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Авирмэдийн Халиунаа Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Эрдэнэчимэгийн Хулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, залуучуудын хөгжлийн Үндэсний зөвлөлийн шинжээч, Нарантуяагийн Баярмаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэлтсийн дарга, Ламжавын Бямбасүрэн Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын дарга, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батчулууны Батчимэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Л.Энх-Амгаланд сайдыг ажлын хэсэг хуралд дуудна уу.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63-ын 9-д Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хуралдаанаас хэлэлцэх бөгөөд энэхүү хэлэлцэхдээ хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг нягталж, холбогдох Байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ гэж заасны дагуу Та бүхэн зөвхөн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд асуулт асууж дэгийг баримтлахыг хүсье.

Тогтоолын төслийн [1 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

С.Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Ж.Баярмаа гишүүнийг оруулна уу. М.Ганхүлэг гишүүний микрофоныг өгнө үү.

**М.Ганхүлэг:** Байнгын хорооны гишүүддээ болон ажлын хэсгийн гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын 2024-2028 оны Засгийн газрын хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн агуулгыг бас ерөнхийд нь дэмжиж байгаа.

Үүн дээр тодотгож хэд хэдэн зүйлүүдийг би асууя.

Монгол орон бол ер нь залуучуудын орон. Хүн амын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа залуучууд руу чиглэсэн ажлуудыг Засгийн газраас аль

түвшинд хэрэгжүүлэх вэ гэдэг энэ асуултыг ерөнхийдөө олон нийт, тэр дундаа залуучууд анхаарал хандуулах нь зөв гэж бодож байна.

Хамгийн нэн тэргүүнд 2025 оныг залуучуудын хөгжлийг дэмжих, ер нь залуучуудын жил болгон зарлая гэдэг нэлээн томоохон зорилт бүхий мөрийн хөтөлбөр орж ирж байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улс залуучуудын гэж хэлж болохоор яамтай болж байна.

Тэгэхээр чиглэлийн ажил, үйл ажиллагаатай холбогдолтой гол ажлуудыг нэг дэлгэрүүлээд танилцуулаач ээ.

Өмнөх өмнөх хөтөлбөрүүд, хийж байгаа ажлууд нэг үр дүнгээ бүрэн дүүрэн өгөхгүй, залуучууд маань Монгол эх орондоо ажиллаж амьдрахад төдийлөн таатай байгаа мэдрэмжүүд сүүлийн жилүүдэд нийгэмд тийм сайнгүй байгаа болов уу гэж би бодож байна.

Гадагшаа дотогшоо ажиллах сонирхол нэлээдгүй ихтэй. Төрд болон энд ажиллаж байгаа ажлын орчин цалин хөлс, байгаа зүйлүүддээ нэлээн дутагдалтай нэг ийм нөхцөл байдал байгааг бид бүхэн мэдэх байх.

Тэр утгаараа залуучуудад чиглэсэн ажлуудыг цаашдаа яг тодорхой бодитойгоор төлөвлөж ингэж ажиллаасай гэж ингэж харж байна.

Зүгээр яг нэг жилийн уриа лоозон болгоод битгий орхичхоосой.

Үүний хүрээнд яг тодорхой нийгмийн асуудлууд, залуу гэр бүлтэй холбогдолтой асуудлууд, залуучуудын ажлын байр, ялангуяа орон сууц,

урьдчилгаа төлбөрийн асуудал гээд олон асуудлуудыг нэлээн тодорхой тусгасан.

Хэрвээ дутуу агуулгууд байгаа бол энэ дээр нэмэгдэж оруулсан ийм Засгийн газрын мөрийн хөтөлбөр болоосой гэж харж байгаа юм.

Тэгэхээр чиглэлийн яамнаас байна уу, хаанаас байна энэ дээр яг тодорхой мэдээллүүдийг өгөөч ээ гэдгийг хэлье.

Мөн дээрээс нь оюутан залуучуудад чиглэсэн олон ажлууд байгаагийн нэг нь **“Оюутан цэрэг”** хөтөлбөр байгаа. Боловсролын яам дээр мэдээлэлтэй байна уу? Сангийн яам мэдээлэлтэй байна уу?

Ер нь хэчнээн хэмжээний төсөв санхүүжилтүүд өмнөх хугацаанд гараад ямар үр дүнгүүд хүрсэн бэ?

Тэгээд энэ хөтөлбөрийг би үргэлжлүүлээсэй гэдэг ийм байр суурьтай байгаа.

Тэгээд зарчмын зөрүүтэй саналаар үүнийг оруулах бодолтой байгаа.

Гэхдээ хөтөлбөрийн өмнөх үр дүн, нөлөөлөл нь аль түвшинд байсан бэ? Ялангуяа төгсөөд ирсэн оюутнуудтай уулзахад нэлээн өндөр сэтгэгдэлтэй байсан.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад хариулна. Ажлын хэсгээс А.Даваажаргал Микрофон 6.

Та бүгдийн өдрийн амгаланг айлтгая.

**А.Даваажаргал:** М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал байна.

Бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2025 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгож зарлахаар төлөвлөсөн байгаа.

Энэ ажлын хүрээнд бид суурь судалгааны ажлуудыг эхний ээлжид хийхээр төлөвлөгдсөн. Суурь судалгааны ажлыг нэгдүгээрт

- Орлоготой залуу,
- Эрүүл, залуу,
- Бие бялдрын хөгжилтэй залуу,
- Боловсролтой залуу”

гэчихсэн ийм 4 том бүлэг дээр тулгуурлаж хийхээр төлөвлөж байгаа.

Одоо байгаа Залуучуудын хөгжлийн тухай хууль дээр 15-аас 34 насны залуучуудыг яг энэ залуучуудын салбарт оруулж бид хуульчилсан байна.

Тэгэхээр яг чиглэлээрээ 15-аас 18 насны залуучуудын хөгжлийн асуудлыг боловсролын системээр дамжуулж олгох асуудлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 оны төлөвлөгөөндөө тусгаж оруулахаар тооцсон.

Орлоготой болон эрүүл, хөгжилтэй залуучуудын асуудлыг суурь судалгааны үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх ажлынхаа төлөвлөгөөг ирэх жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгасан байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

**Л.Энхнасан:** Тодруулга авах уу? Тодруулга 2 минут.

**М.Ганхүлэг:** “Оюутан цэрэг” дээр хариулт өгөх хүн байна уу? Оюутан цэргийн ерөнхий үр дүнг нь нэг сонсчихмоор байна.

Тэгээд яг орон сууцын асуудал, гэр бүлтэй холбогдолтой асуудлууд дээр яг тодорхой орсон заалтууд байгаа юу? Тэрийг та нэг тодруулаад өгчих. Тийм.

**Л.Энхнасан:** Нэмж хариулна уу? Гишүүний хариултад А.Даваажаргал. 6 дугаар микрофон.

**А.Даваажаргал:** Гишүүний асуултад нэмж хариулъя.

Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар яамны эрх зүйн ажлын тодотголын төлөвлөгөөнд орсон байгаа.

Энэ ажлын хүрээнд одоо байгаа хууль тогтоомж дээр боловсронгуй болгох хэд хэдэн чиглэлийг барьж байгаа.

Нэгдүгээрт, залуучуудын орлогыг нэмэгдүүлэх” чиглэлээр.

Хоёрдугаарт, “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” чиглэлээр.

Гуравдугаарт, хамгийн их тулгамдаж байгаа асуудал буюу залуучуудын “боловсрол” дээр нөлөөлж байгаа хүчин зүйлсийн судалгаануудыг хийсэн.

Үүнийг зохицуулсан чиглэлийн хууль эрх зүйн орчныг оруулахаар төлөвлөсөн байгаа.

Тэгээд яг нарийвчилсан мэдээллүүдийг бид М.Ганхүлэг гишүүнд цаасаа файл хэлбэрээр хүргүүлэх болно.



**Л.Энхнасан:** 1 номерын микрофоныг нээнэ үү.

**Л.Балчинлуvsан:** Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан.

Залуучуудын хөгжлийн бодлоготой холбоотой бодлогын арга хэмжээнүүд тусгагдсан тухай сая манай яамны төлөөлөл маань хэллээ.

“Оюутан цэрэг” хөтөлбөр үргэлжлээд хэрэгжинэ.

Мөн дээрээс нь залуучууд хугацаат сая цэргийн алба хаадаг. Энэ хугацаандаа боловсрол болон өөрийгөө хөгжүүлэх боломжууд хангагдах үүднээс бид энэ заалтдаа цахимаар болон зайн байдлаар суралцах тийм боломжуудыг нээж өгсөн.

Тэгэхээр залуучууд маань ямар нэг байдлаар цэргийн алба юм уу, алслагдсан байдалд очихдоо боловсрол, бусад хөгжих асуудалдаа илүү анхаарах боломжууд нээгдэнэ гэсэн үг.

**Л.Энхнасан:** Тодруулга авах уу? Гишүүн. Ж.Баясгалан гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ж.Баясгалан:** Ажлын хэсгийн гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд яг сайхан тодорхой хариулаад өгөөрэй гэж хүсэж байна.

2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулж, гишүүдийн саналыг авсан.

Тэр үед “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн хэсэгт тусгуулахаар өгсөн миний саналууд ер нь ихэнх нь орсон.

Гэхдээ эндээс хамгийн гол нэг санал тусгагдаагүй орхисон байгаа.

Тэр нь “зорчих дэд бүтцийн стандартыг” гэгчхээд “албан байгууллагад хэрэгжүүлнэ” гэсэн миний санал орхигдсон байгаа юм. Үүнийг сайн хараад өгөөрэй.

Үүнийг төсөлд нэмж тусгах шаардлагатай гэж би үзэж байгаа.

Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “орон сууц олон нийтийн барилга, байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.” гэж заасан хэдий ч хуулийн хэрэгжилтийг төрийн захиргааны байгууллагууд, худалдаа, үйлчилгээний байгууллагууд шинээр баригдаж байгаа зарим орон сууцуудад үнэхээр стандартын дагуу тэгж хийхгүй байгаа гэдгийг нь бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй зорчих дэд бүтцийн стандартыг ерөөсөө ингэж байгаа шүү дээ.

- Орон сууц, нийтийн үйлчилгээний байгууллага гэж оруулсан хэрнээ,
- Хувийн хэвшил гэж оруулсан хэрнээ
- Албан байгууллагад хэрэгжүүлнэ гэснийг хасчихсан байгаа. Оруулаагүй.

Тэгэхээр энэ “албан байгууллагад” гэснийг оруулахгүй бол төрийн алба

өөрсдөө үүнийгээ биелүүлэхгүй бол энэ хууль хаанаа ч хэрэгжихгүй гэсэн үг.

Хоёрдугаарт, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.19 дэх хэсэг заалтад “тэтгэврийн хэмжээг инфляц, хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ” гэж тусгасан байгаа. Тийм ээ.

Тэгэхээр инфляц гэснийг нь ер нь “өмнөх оны инфляцын жилийн дундаж болон” гэж, одоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуваарилалт дээр тийм үгээр байгаа.

Тэгэхээр энэ хуультайгаа уялдуулж өөрчлөх тийм саналтай байна. Сайн тэмдэглэж аваарай.

Тэгээд энэ хоёр асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас хариулт авъя гэсэн боловч байхгүй байгаа болохоор Төрийн нарийн бичиг хариулчих байх гэж бодож байна.

Тэгээд би 1 минутаа нэмж авч байгаад гялс ярьчихъя. Тэгэх үү.

**Л.Энхнасан:** 1 минутыг нэмнэ үү.

**Ж.Баясгалан:** Хоёрдугаарт нь, Эрүүл мэндийн сайдын Сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэл, төлөвлөгөө батлах тухай 2021 оны 749 дүгээр тушаалд Монгол Улсын хүн амын 7 хүний 2 нь сэргээн засах үйлчилгээ авдаг. Авах шаардлагатай гэж бичсэн талаар бичсэн байгаа шүү.

Тэгэхээр хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж байгаа зүрхний шигдээс, харвалт, цусны даралт ихсэх, зүрх судасны өвчин, зам тээврийн болон ахуйн осол, үений үрэвсэл, ясны эмгэг,

төрөлхийн болон олдмол гажиг. Тийм ээ. Энэ өвчний үеэс сэргээн засах тусламж үйлчилгээ авах нь маш ихээр нэмэгдэж байгаа.

Тэгээд дээр манай хэрэгцээ их байгаад байдаг. Тусламж үйлчилгээ орхигдоод байгаа.

Өнөөдрийн байдлаар жишээ нь алхдаг төхөөрөмж. Энэ бол алхаж чадахаа байчихсан хүмүүст, тэр мэдрэмжээ алдчихсан хүмүүст алхах урам зориг. Түүнээс гадна тэр мэдрэмжийг өгснөөрөө эргэж хөл дээрээ босоход маш их тус болдог.

Тэгэхээр энэ үйлчилгээг авч чадаагүйгээс болоод хэвтэрт ороод цаашаагаа өвчин нь хүндрээд хорвоог орхиж байгаа хүмүүс маш их бий.

Тэгэхээр үйлчилгээний талаар иргэдэд цогц байдлаар нь хүргээд өгөөч ээ гэж сайдаас хүсэж байна.

Тэгээд энэ талаар ер нь ямар үзэл баримтлал баримталж байгаа талаар нь, ямар бодолтой байгаа талаас.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул хариулна уу. Микрофон 3.

**Л.Мөнхзул:** Ж.Баясгалан гишүүний асуултад хариулъя. Л.Мөнхзул.

Ж.Баясгалан гишүүний гаргасан найруулгын саналыг ажлын хэсгийн хүрээнд хүлээн авах боломжтой байх гэж бодож байна. Одоо байгаа найруулгын хүрээнд “албан байгууллага” гэдэг утгыг нь “орон сууц, худалдаа, үйлчилгээний

байгууллагад мөрдүүлнэ.” гэсэн байдлаар оруулсан байна.

Тэгэхээр үүнийг ажлын хэсэг дээрээ ярилцаад найруулгын түвшинд авч болох уу гээд.

Ер нь төрийн байгууллагын хувьд манлайлал гаргаж аль болохоор бүх иргэдийг, тийм ээ хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан бүгд хүртээмжтэй байх чиглэлээр манлайлал гаргаж ажиллахыг яамнаасаа байнга дэд зөвлөлүүдээрээ дамжуулж манлайлдаг.

Тэгэхээр заалтыг ажлын хэсэг дээрээ ярилцаад Нийгмийн бодлогын байнгын хорооноос томилогдсон ажлын хэсэгтэй хамтарч ажиллаад оруулах санал гаргая гэж бодож байна. Манай яамнаас.

Хоёрдугаар асуудлын тухайд тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй холбогдуулан нэмэгдүүлнэ гэсэн заалт байгаа.

Тэгэхээр нийгмийн даатгалын тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Засгийн газраас тогтоохоор хуульчилсан.

Тэгэхээр жишээлбэл тухайн жилд инфляц бий болоогүй тохиолдолд заавал жилийн дундаж инфляцын түвшин гэхээс илүү тэтгэвэр 4 сард нэмэх тохиолдолд өнгөрсөн 8 сарын инфляц дээр ч гэх мэт.

Өөрөөр хэлбэл эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тодорхой аргачлалын дагуу тогтоохоор хууль дээр Засгийн газар батлах эрх зүй нь байгаа учраас энд шууд аргачлалаа нарийн оруулах нь ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлаас зөрж магадгүй учраас

ерөнхий нэршлээрээ оруулж болох уу гэдэг саналтай байна.

Энэ бол ерөнхий үйл ажиллагаанууд мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөө дээр тусгагдаж байгаа. Үүний дараа төлөвлөгөө Засгийн газраар батлагдана.

Тэгэхээр төлөвлөгөө дээр ажил, арга хэм хэмжээ болгож оруулах боломж байгаа.

Тэгэхээр үүнийг дахин ажлын хэсэг дээрээ ярилцах саналтай байна.

**Л.Энхнасан:** Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгнө үү. Асуултаа асууна.

Эрүүл мэндийн сайдын микрофоныг өгнө үү. 4 дүгээр микрофон.

**Т.Мөнхсайхан:** Гишүүний асуултад хариулъя.

Манай улсад ер нь эмчлэгдэхгүй маш олон төрлийн өвчин байгаа. Жагсаалт нь байгаа. 26 гэж байгаа боловч үүнээс илүү олон тоонууд байгаа.

Дээрээс нь хийгдэхгүй маш олон төрлийн эмчилгээнүүд байгаа.

Манай улсын хувьд хаягдчихсан, орхигдчихсон байсан салбар бол энэ сэргээн засахын салбар.

Гэхдээ сүүлийн хэдэн жилүүдэд боловсон хүчнүүд нэлээн бэлтгэгдэж байгаа. Хөдөлмөр засал, хөдөлгөөн засал гэх мэтчилэн боловсон хүчнүүдтэй болоод байгаа.

Тоног төхөөрөмжийн хангалт нэлээдгүй дутагдалтай зүйлүүд байгаа.

Тэгэхээр сэргээн засахын тусламж үйлчилгээ шаардлагатай эмнэлгүүд дээрээ илүү их үйлчилгээнүүдээ хөгжүүлбэ гэдэг бодлого явж байгаа. Жишээ нь, Гэмтэл, Сонгог Судлалын Үндэсний Төв, Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг дээр харвалттай улсуудад гэх мэтчилэн лавлагаа шатлалын төв эмнэлгүүд дээр сэргээн засахын тусламж үйлчилгээг хөгжүүлээд, үүнийгээ эргээд сургалтын бааз болгоод дүүрэг, орон нутгуудад хөгжүүлээд явах ийм төлөвлөгөө байгаа.

Бусад эрүүл мэндийн салбар нь өндөр хөгжилтэй улсуудад “Сэргээн засах үндэсний төв” гэж байдаг. Энэ дээрээ улсын хэмжээнд цөөхөн тохиолддог шаардлагатай өндөр өртөгтэй тоног төхөөрөмжүүдийг байрлуулж тусламж үйлчилгээг явуулдаг.

Манай улсын хувьд энэ төвийг одоогоор байгуулах боломжгүй учраас лавлагаа шатлалын төв эмнэлгүүд дээрээ энэ тусламж үйлчилгээг явуулъя.

Яг Ж.Баясгалан гишүүний ярьж байгаа тэр алхдаг, ямар нэгэн хүндийн төвийн татах хүчгүйгээр алхдаг энэ төхөөрөмж манай улсад ороод ирчихсэн. Одоо Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг дээр нэг ороод ирчихсэн. Одоо эхнээсээ тусламж үйлчилгээгээ үзүүлээд эхэлж байгаа. Үйлчлүүлэгчийг авч эхлэх боломж нь бүрдчихсэн байж байгаа.

Тэгээд цаашдаа ер нь бид сэргээн засах тусламж үйлчилгээ хөдөлгөөн заслийг бодлогын түвшинд нэлээн авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ удаагийн парламент эмэгтэйчүүд маань их орж ирсэн явдалд баяртай байгаа.

Хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудал дээр их дуугарах болов уу гэж найдаж байгаа.

Энэ 2 дээр байгаа хүний хөгжлийн бодлого дээр өчигдөр би бас Хууль зүйн байнгын хороон дээр асуусан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга олигтой хариулт өгөөгүй л дээ.

Би өнөөдөр ороод ирсэн учраас дахиад асуучихъя.

Хүний хөгжлийн бодлого, ялангуяа 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай бид явж байна.

Тэгээд хүний хөгжлийн бодлого дээр эхчүүд, эмэгтэйчүүдтэй холбоотой нэг заалт байгаа юм. Хоёрхон заалт байгаа юм.

2.1.1.9.цалинтай эх, эцэг нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно гээд.

2.1.1.10.эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ гээд.

Эмэгтэйчүүдийн асуудал нь хаана байгаа юм? Эх болоогүй, ээж болоогүй эмэгтэй хүнийг эмэгтэй хүн гэж үзэхгүй юм уу?

Тэгээд эмэгтэйчүүдийн суурь асуудлуудыг шийдвэрлэж байж нийгмийн асуудал чинь бүрэн цогцоор нь шийдвэрлэх боломж бүрдэнэ шүү дээ.

Яагаад эмэгтэйчүүдийн асуудлуудыг хүний хөгжлийн бодлого дээр ингээд хаягдуулж мөрийн хөтөлбөрт оруулж ирж байгаа юм. Үйл ажиллагааны хөтөлбөрт. Үүнийг ойлгохгүй байгаа. Ажлын хэсэг ажилласан гэж бодож байгаа. Энэ дээр би нэгдүгээрт хариулт авмаар байна.

Хоёрдугаарт, хүүхдийн асуудал байна.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх гээд баахан заалтууд орчихсон байгаа юм л даа.

Тэгээд энэ дээр би өнгөрсөн арваад хоногийн өмнө “Өнөр бүл” хүүхэд хамгааллын төв дээр очсон. Танай яамны харьяа хүүхэд асрах төв.

Тэгээд тэр газраа очоод та нар өөрсдөө үзээч. Ний нуугүй хэлэхэд. Бүр арай хэтэрхий байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг аваачаад нийлүүлчихсэн. Нөгөөдөх нь 20-иос дээш насны. Ямар ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан, хүнд зориулсан стандарт тэнд анхнаасаа угаасаа хөгжлийн бэрхшээлтэй хүн авах ёсгүй учраас байхгүй.

Тэгээд тэр 20 гарчихсан залууг хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэр дээр нь өргөөд жоохон хүүхдүүд явж байгаа. Төмөр таваг, төмөр аяганд хоол цайгаа идэж ууцгааж байна. Бороо ороход дусааландаа нэвт орчихсон. Энэ “Өнөр бүл”-ийн өнөөдрийн байгаа бодит процессын нэг нь энэ.

Хоёрдугаарт, хүүхдийн асуудал дээр Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу. Та

хэд маань бодлогыг яг яаж оруулахаар төсөвлөж төлөвлөж байгаа вэ гэдгийг би асуух гэж байгаа юм.

Одоо ний нуугүй хэлэхэд тэнд эцэг, эх байхаасаа татгалзсан хүүхдүүд байна. Бүтэн өнчин нэртэй хүүхдүүд байна, хагас өнчин нэртэй хүүхдүүд байна, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.

Тэнд ямар асуудлууд байна гээч нэг гэр бүлийн 3 хүүхэд байна. Нэг гэр бүлийн 3 хүүхэд.

Эхлээд ахыг нь авчирсан. Дараа нь дүүг нь авчраад, дахиад дүүг нь авчирчихсан.

Тэр хүмүүс хүлээж байгаа хариуцлага.../минут дуусав/

**Л.Энхнасан:** 1 минут нэмнэ үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд энэ дээр ярих маш олон юм байна. Тэгээд энэ дээр та хэд маань онцгойлон анхаараад хүүхдийн асуудал дээр, ялангуяа мөрийн хөтөлбөр хүний хөгжлийн бодлого дээр оруулж өгөөч ээ гэж хэлэх гэж байгаа юм.

Дараагийн асуудал нь, нийгмийн баталгаатай холбоотой асуудал байна. Нийгмийн баталгаа дээр “нийгмийн даатгал”, “нийгмийн үйлчилгээ”, “эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг” гээд нэг ийм гурван зүйл л байгаад байгаа юм.

Энэ дээр “нийгмийн баталгаа” гэдэг үг утга агуулгаа та хэд маань өөрсдөө ба мэдэж байгаа байх.

Энэ “орчны бохирдолтой холбоотой асуудлууд”-ыг оруулж өгөхгүй юм уу? Нийгмийн баталгаан дээр.

Нийгмийн баталгаа гээд нийгмийн даатгал, нийгмийн үйлчилгээгээ оруулчихсан. Орчны бохирдлоос улбаатай хүн амын нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа асуудлууд байгаа шүү дээ.

Тэгэхээр “нийгмийн баталгаан” дотор Та бүхэн “орчны бохирдолтой холбоотой асуудлууд”-ыг оруулж тусгаж өгөөч ээ гэж хүсэх гэж байгаа юм.

Би Байгаль орчны сайдаар ажиллаж байсан. Байгаль орчны асуудал дотор байгаа юм болов уу гэж бодоод хайсан. Байхгүй байна л даа.

Ер нь байгаль орчны асуудал гэхээс илүүтэй нийгмийн баталгаа руугаа орох ёстой асуудал байгаа юм. Энэ дээр хариулт авъя гэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Л.Энх-Амгалан сайдын микрофоныг нээнэ үү. Сайдын микрофоныг нээнэ үү.

**Л.Энх-Амгалан:** Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Эмэгтэйчүүдийн асуудлууд орхигдсон байна гэсэн зүйлийг ярьж байх шиг байна. Эх, эмэгтэйчүүдүүд гээд орчихсон байна гээд.

Одоо яах вэ, бид өнгөрсөн хугацаанд явж ирсэн энэ хүний хөгжилтэй холбоотой бодлогууд, жишээ нь хүний нийгмийн хамгаалалт, халамжтай холбоотой бодлогуудыг ер нь бодлогын хувьд нэг жаахан цэгцлэх ийм хөтөлбөрүүд бид дэвшүүлж байгаа юм.

Энэ яг юу гэж хэлж байгаа юм бэ гэхээр манайх хуучин чинь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж байсан.

Ингээд шинэ Засгийн газрын бүтцээр “гэр бүл” гэдгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны түүрүүнд оруулж ирж байгаа юм.

Тэгээд яагаад гэр бүлийн яам байгуулагдах шалтгаан үүссэн юм бэ гэдэг асуудал.

Өнгөрсөн хугацаанд ер нь бид эмэгтэйчүүдийн талаар авч хэрэгжүүлсэн бодлогууд, ингээд хүүхдүүд, хүүхэдтэй эмэгтэйчүүд гэдэг юм уу, ахмадууд гэдэг юм уу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг юм уу, ингээд дандаа гэр бүлээс нь салгасан ийм бодлого явсан юм байна. Дандаа гэр бүлээс нь салгасан.

Гэтэл одоо бид нарт яг нийгэмд өнөөдөр үүсчихсэн байгаа гол асуудал бол

- ➔ Гэр бүл төвтэй эрүүл мэндийн бодлого,
- ➔ Гэр бүл төвтэй боловсролын бодлого,
- ➔ Гэр бүл төвтэй орон сууцын бодлого,
- ➔ Гэр бүл төвтэй хөдөлмөр эрхлэлтийн бодлого

гэдгийг бид цогцоор нь энэ бодлогуудыг авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй юм байна гэдэг зүйлүүдийг харж байгаа.

Энэ хүрээндээ ч гэсэн бид ер нь цаашдаа сумын төв, аймгийн төвүүд, дүүргүүд дээр байдаг **“Ахмадын төв”**. Байж болно. “Ахмадын төв”.

“Хүүхдийн төв”, “Хүүхдийн хөгжлийн төв”, “Залуучуудын хөгжлийн төв” гээд дандаа ингээд салгачихсан. Дандаа ийм салгачихсан бодлого явсан байгаа.



Тэгэхээр үүнийгээ ямар ч байсан бид одоо ингээд юуны хувьд **“Гэр бүл төвтэй нийгмийн хамгааллын бодлого”** явуулах учраас бид

- яг аавууд рүү чиглэсэн бодлого,
- яг ээж нар луу чиглэсэн бодлого,
- яг охидууд руу чиглэсэн бодлого,
- эрэгтэй хүүхдүүд рүү чиглэсэн бодлого,
- хөдөлмөр эрхлээгүй байгаа сегмент рүү чиглэсэн бодлого

гээд ийм салсан бодлого явахаар үр дүн их муутай байдаг юм байна.

Тийм учраас бид ерөнхийдөө нэг ийм, энэ англиар **“integrated policy”** гэж яриад байгаа. Бодлогууд хоорондын нэгдсэн уялдааг хангасан асуудлыг л авч явъя.

Ганцхан “эмэгтэйчүүдийн асуудал” гэдэг юм уу, энэ “гэр бүлийн асуудал” чинь яг цагаа тулбал ганцхан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал биш шүү дээ. Энэ бол “нийгмийн асуудал” байхгүй юу.

Тийм учраас салбар дундын зохицуулалтууд хэрэгтэй. Салбар дундын явж байгаа бодлогуудыг зөв уялдуулж явж байж бид яг тэр тухайн нийгмийн сегментэд хүрсэн энэ бодлого явуулах ёстой юм байна гэж.

Бид их ерөнхий явж ирсэн юм байна. Одоо жишээ нь бид **“хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал”** гээд л ярьдаг мөртөө өнөөдөр Монгол Улсад байгаа 111 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн яг тэр хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тохирсон нийгмийн үйлчилгээнүүд яг юу байх ёстой юм бэ гэдгээ бид тодорхойлж чадаагүй.

Тийм учраас яг иргэдийн хүсэж байгаа эрэлтэд нийцсэн.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайдын микрофон. Минут нэмнэ үү.

**Л.Энх-Амгалан:** Манай Б.Бат-Эрдэнэ гишүүн маань “Өнөр бүл” төв дээр очиж зөв асуудлуудыг хөндөж тавьж байгаа. Их зөв.

Тэгэхээр бид энэ жил Хүүхэд хамгааллын тухай хуультай болсон. Одоо энэ хуулийнхаа хэрэгжилтийг бид нэлээн хангаж ажиллах ёстой.

Ер нь хэрэгжилт хангана гэдэг бол санхүүжилт.

Өнгөрсөн хугацаанд бид ер нь. Одоо би дахиад л **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал** ярья.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай хууль бол одоо манай Ж.Баясгалан гишүүн ч сайн мэдэж байгаа байх, манай О.Саранчулуун гишүүн ч сайн мэдэж байгаа байх. Их сайн хууль юм билээ.

Гэтэл харамсалтай нь дандаа лоозонгийн шинж чанартай заалтууд хийчхээд. Тэрийг хэрэгжүүлэх механизм буюу санхүүгийн эх үүсвэрүүд, механизмуудыг нь ерөөсөө тавьж чадаагүй учраас ихэнх хуулиуд түүнээсээ болж хэрэгжиж чадаагүй.

Тийм учраас одоо энэ Хүүхэд хамгааллын хуулиар, тэр тусмаа өнөөдөр эмзэг бүлгийнхний хүүхдүүдээ бид төрийн яг ямар дэмжлэг, туслалцаа, нийгмийн үйлчилгээнүүд байх ёстой юм бэ гэдгээ нарийвчилж гаргая.

Одоо харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, тийм ээ



хөдөлгөөний бэрхшээлтэй гэдэг юм уу, одоо ингээд 6, 7 төрлийн хавсарсан гэх мэтчилэн бэрхшээлийн онцлог бүрд тохирсон нийгмийн үйлчилгээнүүдийг гаргаж ирж, үүнийг тарифжуулж яг тэр хүнд нь тохирсон ийм үйлчилгээнүүд нь явах нь илүү жинхэнэ нөгөө хүртээмжтэй нийгмийн үйлчилгээний энэ загвар луу шилжих нь зүйтэй юм байна гэж харж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ одоо бид нар бас “Өнөр бүл” төв дээр очиж ажиллая гэж бодож төлөвлөж байгаа. 150 гаруй хүүхдүүд байдаг юм билээ.

Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хэрэв ирэх юм бол тэр орчныг нь бүрдүүлэх, боловсролын үйлчилгээ яаж хүргэх юм, эрүүл мэндийн үйлчилгээг нь яаж хүргэх юм, нийгмийн хамгааллынх нь үйлчилгээнд яаж хүргэх юм гэдэг дэмжих төвийн хэлбэрээр бид зохион байгуулах нь их зүйтэй юм байна гэж харж байгаа.

Сүүлийн үед яах үед би боловсролын сайдаар ажиллах хугацаанд энэ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дэмжих төв” гээд 4 төвийг манай А.Ариунзаяа сайд байсан. Манай С.Энхболд сайд байсан.

Бид гурав хамтарч энэ дэмжих төвийн загваруудыг гаргаж, маш их үр дүнд хүрч байгаа шүү дээ.

**Л.Энхнасан:** Баярлалаа. С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү. Тодруулга. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээнэ үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.

Л.Энх-Амгалан сайдын ярьж байгааг ойлгож байгаа л даа. Гэр бүл. Ялангуяа хүний хөгжлийн бодлого дээр

гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого гээд оруулчихсан.

Би яагаад эмэгтэйчүүдийн асуудлуудыг дахин дахин хөндөөд байгаа вэ гэхээр. Яах вэ, сая Л.Энх-Амгалан сайдын хэлдгээр гэр бүлийн хүрэн дэх асуудлыг бүгдийг нь шийднэ. Тэр хүрээндээ бид бодлого оруулж байгаа гээд байна л даа.

→ Гэр бүлгүй хүүхдүүдийг яах вэ?

→ Гэр бүл болж амжаагүй, эсвэл гэр бүлгүй “**бүтэн өнчин**” өссөн эмэгтэйчүүдийн бодлогыг яах вэ?

2023 онд 2697 хүн байна. Монгол Улсын хэмжээнд. Хүүхдийн тоо. “**Бүтэн өнчин**”.

Тэгээд энэ “асрах” гэдэг байгууллагаараа дамжаад 18-аас дээш насанд хүрэхээрээ өөрөө нийгэмшээд яв. Энэ дээр “эмэгтэй” гэдэг утга агуулга байхгүй.

- Гэр бүлийн хүмүүжлээр явах ёстой.
- Гэр бүлийн бодлогоор явах ёстой гэдэг утга агуулгаар явах юм уу?

Би тэгээд сая харлаа л даа. Энэ дээр.

Эрэгтэйчүүд дээр байна л даа. **2.1.1.12** дээр. “Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан эрэгтэйчүүдэд зориулсан хөгжил, нийгмийн үйлчилгээг үзүүлнэ” гээд биччихсэн байгаа. Баярлалаа.

Тэгээд эмэгтэйчүүд дээр үзүүлж болохгүй юм уу?

Тэгвэл энэ үг эрэгтэйчүүд дээр байж байгаа юм чинь тэгвэл эх, эмэгтэйчүүд дээрээ тавьчихаж болохгүй юм уу гэдгийг л асуугаад байгаа байхгүй юу.

Тэгээд өнөөдөр хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд гэртээ яг ний нуугүй хэлэхэд хэчнээн сар, жилээр гэртээ хоригдож байна гэж бодож байна.

Тэр хүмүүсийн хөгжлийг бид яаж бодох юм?

“Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв” гээд ярихаар дан эмэгтэйчүүдийн асуудлыг тусад нь гаргаж ангилж ялгаад байна гээд. Болохгүй шүү дээ, наадах чинь гээд байгаа байхгүй юу.

Тэгвэл энд эрэгтэйчүүд дээр. Би эрэгтэйчүүдийг барьцаад байгаа юм биш шүү. Уучлаарай.

“Эрэгтэйчүүдийн гэр бүлдээ зарцуулах цаг оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлнэ.” гээд орчихсон байгаа байхгүй юу.

Үгүй ээ, тэгвэл гэртээ байгаа хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөгжлийн тэнцвэрт хангасан бодлогыг яаж явуулах юм? Нөгөө талдаа. /минут дуусав/

**Л.Энхнасан:** Л.Энх-Амгалан сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Гэр бүлгүй эмэгтэйчүүдийн асуудлууд орхичих гээд байгаа юм биш биз дээ гэж санаа зовниж байгаад би ойлгож байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн ээ.

- Өнчин хүүхдүүдийн асуудал байгаа.

- Гэр бүл болж чадаагүй насаараа ганц бие амьдарч байгаа эмэгтэйчүүд байгаа.

- Гэр бүлээсээ салсан эмэгтэйчүүдэд байгаа.

Тэгээд бүх зүйл рүү бид нийгмийн энэ давхарга бүр лүү чиглэсэн нөгөө хувь хүнийх нь эрэлт хэрэгцээнд нийцсэн ийм л бодлогуудыг бид явуулах нь зүйтэй гэж бодож байна.

Тэгэхээр одоо бид чинь Засгийн газрын мөрийн хөтөлбөр баталж байгаа, хэлэлцэж байгаа.

Ирэх 4 жилд Засгийн газрын мөрийн хөтөлбөр илүү их тийм томоохон салбарын реформ шинэчлэлийн концепцын бодлогууд нь орж ирж байгаа.

Үүнийгээ баталсны дараа жил бүрийнхээ улсын төсөвтэй уялдуулж бид үйл ажиллагааны нарийвчилсан хөтөлбөр оруулж ирдэг учраас магадгүй таны хэлээд байгаа яг одоо тэр орхигдох гээд байгаа сегментүүд, нийгмийн тэр давхарга руу хандсан бодлогууд илүү их тодорхой болж орж ирэх болов уу л гэж би ийм төсөөлөлтэй байгаа.

Ер нь яах вэ, Байнгын хорооныхоо гишүүдэд хэлэхэд өнгөрсөн 15-аас 20 жилийн хугацаанд нийгмийн бодлогын чиглэлээр, нийгмийн халамжийн чиглэлээр явуулсан бүх бодлого дээр нь 6 ажлын хэсэг гаргаж ажиллаж байна. 6 ажлын хэсэг.

Тэгээд бүх хэрэгжсэн бодлогууд дээрээ цөмөөрөө нэг үнэлэлт дүгнэлт өгье.

- Аль нь яг эзнээ олсон юм,
- Аль нь яг байгаа оносон юм,

- *Хэдэн тэрбум төгрөг зарцуулсан юм,*
- *Тэр нь яг ямар үр дүнд хүрсэн юм,*
- *Алиныг нь бид цааш нь аваад үргэлжлүүлэх ёстой юм,*
- *Алиныг нь зогсоох ёстой юм*

гээд энэ халамжийн бодлогоосоо авхуулаад бид засаж залруулах зайлшгүй шаардлага байгаа учраас энэ чиглэлээр.

Би Байнгын хорооны даргад бас санал гаргасан. Энэ чуулганы завсарлагаанаар би гишүүдийнхээ ирцүүдийг харж байгаад Байнгын хорооныхоо даргатай хамтраад ер нь энэ 6 ажлын хэсгийн ажиллаж байгаа мониторингийн үнэлгээнүүд гаргаад.

Үүнийг би Байнгын хорооныхоо гишүүдэд дэлгэрэнгүй танилцуулъя.

Ирэх 4 жил өнөөдрийн батлах гэж байгаа мөрийн хөтөлбөрүүдээ бид яг яаж хэрэгжүүлэх юм гэдэг тавьж байгаа шалгуур үзүүлэлт, хүрэх зорилтууд, тулгамдаж байгаа асуудлууд, эрх зүйн шинэчлэлүүдээ.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Баярлалаа. С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээнэ үү.

**С.Эрдэнэбат:** Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нэлээн олон заалтууд орсон байсан. Үг хэллэгээсээ авхуулаад олон заалтууд орсон байсан.

Ер нь энэ 4 жилийн хугацааны Засгийн газрын мөрийн хөтөлбөр учраас хүмүүст нэлээн хэдэн асуудал маш тодорхой тоо хэрэгтэй байгаа.

Ерөнхий утгаар орчихсон.

Ирэх 4 жил дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2 дахин өсгөнө гээд тавьчихсан. Дундаж цалин хэдэн хувиар өсөх вэ?

Ажилгүйдлийг тэдэд хүргэнэ гээд тодорхой тавьчихсан байсан. Тэтгэвэр хэд болох вэ?

Мөн тэтгэмж хэд болох вэ гэдэг ийм тодорхой баримжаатай тоотой явахгүй бол зөвхөн эдийн засгаа өсгөчихнө. Тэр нь өөрөө яаж хуваарилагдах нь зах зээл нь өөрөө зохицуулна гэдэг ийм байдлаар хаяж болохгүй байгаа юм.

Тийм учраас миний хувьд эдийн засгийн өсөлтөө дагаад цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлуудыг хэд болгох вэ?

Магадгүй ирэх 4 жил олон хүлээлттэй гол асуудал бол энэ байгаа.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд бид 80, бараг заримыг нь 2 дахин өсгөж чадсан. Тэтгэвэр тэтгэмж, мөн төрийн албан хаагч нар болон улсын дундаж цалин хөлс.

Ийм хүртээмжтэй хөтөлбөр маань тийм баймаар байгаа юм гэж.

Үүний гол уяж өгөх ёстой асуудал нь олон улсын байгууллагууд ч гэсэн нийгмийн баялгийн хүртээмжийн асуудлыг эдийн засагтайгаа уяж өгөх асуудал их чухал.

Үүний гол гогцоо асуудал нь юу юм бэ гэхээр төр өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсөв маань нэлээн өндөр жин эзэлж байгаа. Одоо дахиад концесс, төрийн худалдан авалт, төр, хувийн хэвшлийн түншлэл гээд нэлээн тоо нэмэгдэх гээд байгаа. Энэ дээр

нийгмийн үнэлгээний асуудал гэдэг зүйлийг л бид их яримаар байгаа юм.

Ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн бодлогын байнгын хороо.

Төсөв дээр харж байхад маш олон томоохон бүтээн байгуулалтууд байж байдаг. Үүнийг үндэсний компаниуддаа яаж өгөх вэ. Эргээд тэр дотор нь яаж байнгын ажлын байруудыг нь бий болгож өгөх вэ. Тэнд ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, тогтвортой байдал, дагаад орон сууц, дагаад тэр хүүхдүүдийнх нь сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэтчилэн зүйлүүдийг нь цогцоор нь авч үзэх ийм асуудлууд руу хөтөлбөрүүд дээр оруулахгүй бол яг ийм зүйлүүдийг л орхих гээд байдаг.

Дээрээс нь би жил болгон л хэлдэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал гэдэг юм манай төрийн албан байгууллагад ерөөсөө өөрсдөө мөрддөггүй юм.

Тэгээд нөгөө осол аваар гарчихаар яадаг вэ гэхээр хэнийг барьж авч буруудах вэ гэдэг юмыг л барьж явдаг. Ихэнх нь манай Хөдөлмөрийн яаман дээр эргэж тусчих гээд байдаг.

Тийм учраас Сангийн яамтай ярьж байж зардал мөнгүүдийг нягталж үзсэн үү? Ерөнхийдөө оруулчихсан байгаа. Өгөөгүй учраас тусгаагүй гэдэг зүйлүүд ярьдаг.

Хүний нөөцийн хомсдолын асуудал нэлээн нүүрлэсэн байгаа. Зарим гишүүд гадаадаас хамаагүй ерөөсөө орж ирье гэснийг нь оруулж ирье гэдэг хүртэл хууль санаачлаад явж байна лээ. Энэ чинь өөрөө бас нэг талаараа үндэсний ажиллах хүчнээ хамгаалах бодлогын асуудлуудыг

давхар авч үзэхгүй бол юмыг нэг талаас нь хараад байж болдоггүй. Нэмэлт минут аваад нэгмөсөн яачихъя. Тодруулгаа аваад.

**Л.Энхнасан:** Минутыг нь нэмнэ үү.

**С.Эрдэнэбат:** Дээрээс нь “цагийн хөдөлмөр” гээд их яриад байдаг болчихжээ.

“Цагийн хөдөлмөр” гэдгийг хэт их дэвэргэж, байнгын бус шинж чанартай ажлын байруудыг нэмдэг нь өндөр хөгжилтэй улс орнууд гадаадын хямд ажиллах хүчийг хямдхан ашиглая гэсэн бодлого цаана нь байж байдаг юм шүү.

Үүнийг манайх копидож дуурайгаад явах гээд байвал нөгөө тал руугаа ямар ч байнгын ажлын байр биш, зүгээр бүгдийг нь цагаар болон “sub contract гэрээ” буюу зүгээр “гэрээт ажилтан” гэдэг байдлаар ингэчихдэг нэг ийм аюул байгаа.

Тэгэхээр дээрээ бид нөгөө талд нь юуг нь хангаж өгч байхгүй бол энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дотор яг ийм зүйлүүд орж ирээд байна лээ гэдгийг хэлмээр байна.

Томоохон хөрөнгө оруулалтууд дээр, тухайлбал зам дээр гээд л авч үзэж байгаа юм.

Би замын ажилчидтай уулзсан. Манай үндэсний компаниуд ерөөсөө би гэдэг үзэлтэй 400 компани байж байдаг.

Нэгдээд өөрөө тэр том замынхаа тендерийг авъя гэхээр нэгдэж чаддаггүй. Арга буюу гадаадын компаниудад өгдөг. Гадаадын компаниуд нь буцааж хуваагаад манайханд бараг зардаг гэж хэлж болно.

Ашиг бараг үлддэггүй. Нийт ажилчид нь тогтворгүй учраас ажиллах хүчнүүд нь гараад явчихдаг.

Тийм учраас энэ тал дээрээ томоохон төслүүд дээр “нийгмийн үнэлгээний” гэдэг юмыг оруулж өгмөөр байгаа юм гэдгийг би чуулган дээр ч хэлсэн.

Тэгээд үүнийг манай яам болон бусад газрууд ярьсан уу?

Эрүүл мэнд дээр хэлэхэд Эрүүл мэндийн даатгалын сан маань ер нь ачааллаа дийлэхээ больчихсон байгаа. Одоо хөрөнгийн эх үүсвэр гаргаж ирнэ гэсэн. Хаанаас олж ирэх вэ? Хөрөнгийн эх үүсвэрийг. Шимтгэл нэмэх юм уу, эсвэл Баялгийн сангаас авах уу? Яг юу гэж оруулж ирсэн байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Нэг зүйлийг хэлэхэд “цэргийн хөдөлмөр эрхлэлт” гээд ярьж байсан. Энэ чинь олон улсын нөгөө “албадан хөдөлмөр” гэдэг юмаар орж ирээд бид эдийн засгийн хориг арга хэмжээ лүү орчих эрсдэл байгаад байдаг. Үүнийг хэрхэн яаж харж байгаа вэ?

Яах вэ үүнийг “томоохон стратегийн шинж чанартай” гэдэг дээр зарим зохицуулалтуудыг нь тодорхой болгохгүй бол бидний хувьд ийм хүндрэл рүү дагуулчих асуудал байгаа. Тэгээд энэ талууд дээр асуулт асуумаар байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ хэзээ ч.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Л.Энх-Амгалан сайдын микрофоныг нээнэ үү.

**Л.Энх-Амгалан:** С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт нь, манай Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл маань Улсын Их Хуралд, энэ хууль тогтоох байгууллагад орж ирж дуу хоолой болж байгаад туйлын их талархаж байгаа. Манай Ц.Мөнхтуяа багш маань сууж байх шиг байна. Багш нарын төлөөллүүд, эрүүл мэндийн салбарынхны төлөөллүүд.

Тэгэхээр мэдээж монголчууд нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг тэр их үнэн үг.

Одоо бид чинь ирэх 4 жилд үндсэндээ мөрийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхэд 180 гаруй их наяд төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэсэн тооцоо байгаа шүү дээ. Тийм ээ. 180 гаруй их наяд.

Тэгэхээр бид ямар ч байсан 6-аас 8 хувьд эдийн засгийнхаа өсөлтийг энэ хэмжээндээ бариад, мэдээж инфляция 6-аас 8 руу, 8-аас илүү алдчихгүй шиг энэ түвшинд бариад.

Тэгээд цаашдаа мэдээж төсвийн алдагдал гэдэг нэг ойлголт байгаа. Өрийн тааз гэдэг нэг асуудал байгаа. Зээлжих зэрэглэл гэдэг нэг асуудал байгаа.

Энэ 4 үзүүлэлтүүдээ л бид аятайхан эхнийхээ 2 жилд сууриа зөв тавиад аваад явж чадах юм бол одоо яг хүн бүхний хүсдэг нөгөө “хүртээмжтэй эдийн засаг” буюу “хүртээмжтэй хүний хөгжлийн бодлого” буюу одоо яг цалин, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн орлогуудыг яаж нэмэх вэ гэдэг асуудал дээр тодорхой эдийн засгийн орон зай боломжууд нээгдэх болов уу гэсэн ийм төсөөлөлтэй байгаа.

Энэ төсөөллөөр бид ерөнхийдөө 2025, 2026, 2027 онууд дээр тодорхой төсөөллүүд хийж байгаа.

Одоо бид ерөөсөө С.Эрдэнэбат гишүүн ээ. Одоо бид нар ингээд цалин дандаа ярьдаг. Манай Ц.Мөнхтуяа гишүүн ч байна. Цалин дандаа ярьдаг.

Одоо цөмөөрөө “бүтээмж” ярья. Хэрвээ үнэхээр өндөр цалин авахыг хүсэж байгаа бол өндөр бүтээмжтэй ийм л ард иргэдтэй болъё, ийм хөдөлмөрийн зах зээлийг дэмжье, ийм хөдөлмөр эрхлэлтийг ерөөсөө дэмжье.

Ерөөсөө Монгол Улсын бүтээмжийн асуудлаар бид бодлогын түвшинд том бодлого ерөөсөө явуулж байгаагүй юм байна.

Тийм учраас өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр гарч ирсэн.../минут дуусав/

**Л.Энхнасан:** 3 минут нэмэлт өгье. Сайдын микрофон.

**Л.Энх-Амгалан:** Тэгэхээр үндсэндээ бид бүтээмжийн асуудлуудаа ярихгүй бол одоо ингээд нэг талдаа бид 80-аас 100 гаруй мянган ажилгүй иргэдтэй. Тэгэхдээ энэ тоо бол би худлаа тоо гэж ойлгож байгаа.

Ер нь ажилгүйдлийг бид тоо статистикуудаа дахиж нэгтгэж харах ёстой юм байна. Тэр тусмаа Монгол Улсад байгаа албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудлуудыг бид цоо шинээр харах цаг нь болсон юм байна гэж.

Нөгөө талдаа хөдөлмөрийн хүчний хомсдолд орчихсон байна. 30-аас 40 мянган хүний хөдөлмөрийн хомсдолд орчихсон байна.

Тэгээд яагаад хомсдолд ороод байгаа юм бэ гэхээр хүн өнөөдөр манайхны хөдөлмөрийн зах зээл дээр

санал болгож байгаа ажлын цалин бага байгаа байхгүй юу. Тиймээс Монголчууд тэр бага цалинтай ажилд ажиллахыг хүсэхгүй байна.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад байгаа уул уурхайн салбар, мэдээлэл технологийн салбар, банк, санхүүгийн салбарууд дээр өндөр цалинтай ажлын байрууд байна. Тэнд хүмүүс илүү бүтээмжтэй, өндөр цалинтай ажлын байранд залуучууд ажиллах сонирхолтой учраас магадгүй бид хөдөлмөрийнхөө зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг мэргэжлийн боловсрол, дээд боловсролынхоо тогтолцоотой уялдуулж илүү их өндөр бүтээмж бий болгодог, өндөр цалинтай ажлын байран дээр Монголчуудаа бэлдэх, дунд болон урт хугацааны бодлого нь ингэж явж байж хүн бүрийн тэр өндөр цалинтай болох, өндөр өрхийн орлоготой болох энэ хүсэл мөрөөдөлдөө хүрэх болов уу гэсэн нэг ийм бодол байгаа.

Хоёрдугаар асуудал бол бид илүү их тийм. Мэдээж цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ёстой.

Хоёрдугаар асуудал бол ерөөсөө Монгол Улсад байгаа асуудал бол энэ орон сууцжуулах асуудал байна.

Тийм учраас ерөөсөө ирэх 3 жил, ирэх 4 жил Монгол Улсын Засгийн газрын нийгмийн бодлогын хүрээнд хийх гэж байгаа, энэ хүний хөгжлийн хүрээнд хийх гэж байгаа хамгийн том бодлого бол ерөөсөө иргэдээ орон сууцжуулья. Яаж орон сууцжуулах вэ гэдэг асуудал байгаа юм.

Тийм учраас Монгол Улсад өнөөдрийн бий болсон Баялгийн сангийн хуулиар бий болсон Хуримтлалын сангийн менежмент бол одоо энэ Гэр бүл,



хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд ирж байгаа.

Тийм учраас энэ “Хуримтлалын сан” дээр ирж байгаа эх үүсвэрийг анх удаа орон сууц авч байгаа залуу гэр бүлд яг ямар орон сууцын бодлого явуулах юм, төрийн албан хаагч нартаа бид яг ямар орон сууцын бодлого явуулах юм. Тийм ээ. Хөдөө аймгийн төвд амьдарч байгаа, сумын төвд амьдарч байгаа иргэдийг яг ямар орон сууцын бодлого явуулах юм бэ гэдэг энэ бодлого их түлхүү явна гэж харж байгаа.

Нөгөө талаасаа энэ жилээс нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж эхлээд одоо манай иргэдийн дансанд ажил олгогчийн буюу даатгуулагчийн төлсөн 2 хувь хуримтлагдаж эхэлсэн.

Одоо Та бүхний дансанд хуримтлалууд үүссэн.

Монголд нийгмийн даатгалын шимтгэл төлдөг хүн бүхэн өнөөдөр дансан дээрээ оны эцэс дээр гэхэд ямар ч байсан 700-аас 1.2 сая төгрөгийн бодитой хуримтлалууд үүсэж эхэлж байна. Бодитой хуримтлалууд.

Одоо ингээд энэ сангийн бодитой хуримтлал оны эцсээр 240 тэрбум төгрөг бодитой хуримтлал хийгдэж байгаа.

Тэгэхээр хуримтлалууд үүсэж байгаа Хуримтлалын сангийн эх үүсвэрүүд, Тэтгэврийн сангийн эх үүсвэрүүдийг бид иргэдээ орон сууцжуулах бодлого руу явуулах санхүүгийн зөв механизм тогтолцоо руу л орж байж иргэдийнхээ орон сууцын асуудлуудыг.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайд, 4 дүгээр микрофоныг нээнэ үү.

**Т.Мөнхсайхан:** Эрүүл мэндийн даатгалын сан хүнд байдалд байгаа нь үнэн.

Яагаад гэвэл 2021 оноос хойш Эрүүл мэндийн даатгалын сангийн өр маань хуримтлагдсаар байгаад өнөөдрийн байдлаар 218 тэрбум болчихсон.

Үүний гол шалтгаан нь ковидыг даван туулахад, ялангуяа омикроны давлагааг даван туулахад нэлээдгүй санхүүжилт зарцуулагдсан. Тэгээд үүнийгээ хамгийн гол нь эргэж нөхөж ирэх оны төсөв дээр нь тавьж өгөхгүй явсаар байгаад өнөөдөр 218 тэрбумд хүрсэн байгаа.

Тэгэхээр бид цаашдаа энэ оны төсвийн тодотгол дээр санхүүгийн үүсвэр тавигдаагүй. Яагаад гэвэл өнөөдөр цаашдаа явуулах нэн шаардлагатай том төслүүдийнхээ санхүүгийн эсвэрүүдийг шийднэ.

Ирэх оны төсөв дээр энэ 218 тэрбумыг шийдэж өгөхөөр болсон учраас бид одоо үлдсэн саруудад Эрүүл мэндийн даатгалынхаа санхүүгийн зарцуулалт, нэн шаардлагагүй тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх. Дээрээс нь хамтын төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байна.

Ингээд ирэх оны төсөв дээр хуримтлагдсан өрийн асуудал шийдэгдвэл ирэх оноос Эрүүл мэндийн даатгалын сан маань хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэнэ.

Гэхдээ өнөөдрийг хүртэл 2021 оноос хойш 2024 оныг хүртэл эрүүл мэндийн салбарын санхүүжилт 2 дахин



нэмэгдсэн боловч өнөөдөр санхүүжилт хүрэлцээ муутай байгаа.

Энэ нь юуг харуулж байна гэхээр ер нь өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбар маань ямар бага зардлаар ямар их зүйлийг болгож ирсэн юм бэ гэдэг нь харагдаж байгаа. Тийм ч учраас цаашдаа ирэх жилүүдэд эрүүл мэндийн салбарт тавигдах санхүүжилтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэж дотоодын нийт бүтээгдэхүүний доор хаяж 6 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийг эрүүл мэндийн салбарт тавьж байж гүйцэтгэлийн санхүүжилт маань биеллээ олж илүү их тусламж, үйлчилгээ ард иргэдэд хүрэх боломж бүрдэнэ.

Тэгэхээр ирэх оноос асуудлууд маань үе шаттайгаар шийдэгдээд явах болов уу гэж харж байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Б.Бат-Эрдэнэ гишүүний орчны бохирдлын асуултад хариулаагүй үлдчихэж. Хариулах хүн байна уу? Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. 1 дүгээр микрофоныг нээж өгнө үү.

**Л.Балчинлуvsан:** Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балжинлуvsан.

Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Та бүхэн анзаарсан бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдүгээр бодлого болох Бүсчилсэн хөгжлийн бодлого гэсэн бүлгийн хүрээнд бид нийт 6 бүс, 21 аймаг гэсэн үг.

Мөн дээрээс нь энэ бодлогынхоо хүрээнд Улаанбаатар хотын асуудлыг тусгаж өгсөн.

Зорилгыг нь уншвал “эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх” гэсэн гол зорилгын хүрээнд доошоо арга хэмжээнүүд маань тус тусгагдсан байгаа. Энэ хүрээндээ сургууль орчмыг яаж эрүүл, аюулгүй байдлыг хангах вэ, орон сууц, ард иргэдийн амьдарч байгаа орчныг яаж аюулгүй хангах вэ гэдэг яг таны сая асуусан шиг нэг бөөнөөрөө цугларч ороогүйгээр яг тухай тухай бүрд нь юу гэдэг юм чиглэлүүд нь туссан байдлаар задарч орсон байгаа.

**Л.Энхнасан:** Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн өдрийн амрыг эрье.

Нийгмийн халамж хавтгайрлаа гэж бид маш их ярьдаг. Хүн амын бараг 76.5 хувь нь ямар нэгэн төрлийн халамж авдаг гэж ярьдаг. Нөгөө 72 төрлийн 551 ширхэг халамж байна гэж ярьдаг.

Тэгээд яах вэ, мөнгөн дүнг нь тооцоолоод бодохоор хүүхдийн мөнгө авагсад их байна гэдэг. Гэтэл үгүй.

Жил болгон энэ халамж авагсдын тоо нэмэгддэг. 2016 оныг 2023 онтой харьцуулахад бараг мянган хувиар буюу 10 дахин нэмэгдсэн гэсэн статистик байгаа.

Тэгэхээр энэ хавтгайрсан халамжаас чинь үүдээд асар олон үр дагаврууд гарч байгаа. Нөгөө ажил хийх сонирхолгүй болох гэхээс авхуулаад. Тийм ээ.

Тэгээд яах вэ, энэ юунд ашгүй нэг юу орсон байна л даа. Нөгөө Засгийн

газрын үйл ажиллагааны хөтөлбөрт. Зорилтот бүлэгт чиглүүлнэ. Зөвхөн зорилтот бүлэгт гээд бүр 2.1.3.9-д.

Тэгэхээр яаж дэлгэрүүлж үүнийг оруулж байгаа юм бэ? Зорилтот бүлэгтээ чиглэсэн буюу ер нь орлогод суурилсан ийм халамжийн бодлого руу шилжиж байгаа юм уу? Гэтэл үнэн хэрэгтээ зорилтот бүлэгт нь жишээлбэл хэвтэрт байдаг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмийн мөнгө гээд сард 20 мянган төгрөг авдаг гэж байгаа. Энэ хаанаа ч хүрэхгүй байх ёстой.

Дээрээс нь хүүхэд 8 мянга, том хүн 16 мянган төгрөгийн талон авдаг.

Тэгэхээр энэ бол сард хоол хүнс авах ямар ч боломжгүй.

Тэгэхээр мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтот бүлэгт чиглүүлнэ гэдгээ яг ямар аргаар хэрэгжүүлэх гэж байгаа вэ?

Тэгээд орлогод суурилж энэ халамжийн бодлогоо явуулах гэж байгаа юу, үгүй юу гээд нэг ийм асуулт байна.

Хоёрт, ядуурлын түвшин. Ядуурлын шугамыг гаргаж байгаа аргачлал юу вэ? Дэлхийн банкнаас 2.1 доллар гэж үздэг. Монгол ядуу хүнийг хэдэн долларын, хэдэн төгрөгийн орлоготой гэж үзэж байна?

Яах вэ, мэдээлэл хайгаад үзэхээр өдрийн 13 мянга 745, сарын 412 мянга гэж байгаа юм.

Тэгэхээр 413 мянган төгрөгийн орлоготой хүн ядуу биш гэсэн үг үү? 415 мянган төгрөгийн орлоготой хүн ядуу биш болж хувирч байна уу?

Хэрвээ энэ аргачлалаа зөв тогтоох юм бол бараг 30 хувь нь биш эсрэгээрээ 60, 70 хувь нь ядуурлын шугамаас доогуур орох юм биш үү.

Тэгэхээр энэ аргачлалын талаар хэлж өгөөч ээ гэж асуумаар байна. Тэр бодлогыг асуумаар байна.

Тэгээд одоо бид энэ төсөвтэй танилцаад л явж байгаа л даа.

Тэгэхээр сумдад маш их төсөв тавигдаж байгаа. Иргэдийн мэдээллийн төв энэ тэр гээд. Гэтэл Улаанбаатар хотод байгаа иргэд, ялангуяа хүүхдүүдэд зориулсан ямар нэгэн төв байгаа юу, орж байгаа юу? Хөгжлийн төв.

Хүүхдийн ордон жишээлбэл нийт Улаанбаатарт амьдарч байгаа хүүхдийн зөвхөн 1 хувийг л хамрах боломжтой гэдэг.

Тэгэхээр бусад 99 хувь нь. “AFTER SCHOOL” гээд Америкт маш их байдаг. Тийм ээ. Тэр хамрагдалтыг яаж хангаж байгаа юм болоо гээд ийм 3 асуулт байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул хариулна уу? 3 дугаар микрофон.

**Л.Мөнхзул:** Ж.Баярмаа гишүүний асуултад хариулья.

2021 оноос хойш гүйцэтгэлийн тоон мэдээллээр авахаар тухайлах юм бол нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдын тоо 62 мянгаас төдийлөн өсөөгүй. Өсөлтийн дундаж хурд ердийн өсөлтөөр байгаа.

Нийгмийн халамж авагчдын тоо ерөнхийдөө тухайн бүлгүүдийн халамжийн хувьд хэвээрээ байгаа боловч шинэ төрлийн нэмэлт халамжууд бий болж байгаа учраас энэ тоо нэмэгдээд явах ийм асуудалтай байгаа.

Гол нь халамж авагчдын тоонд нь нөлөөлж байгаа хүчин зүйл нийт хүүхдийн мөнгө авагчдын тоо буюу нийт халамж авагчдын ихэнх нь хүүхдийн мөнгө авч байгаа.

Монгол Улсад нийгмийн халамж зорилтот бүлэгтээ бүрэн гүйцэд хүрч байгаа гэж хэлэхэд хүндрэлтэй. Яагаад вэ гэхээр халамжийг олгож байгаа аргачлал маань орлогын болон амьжиргааны түвшний үзүүлэлтээс илүү хүн амын бүлгүүдэд буюу категорийн аргад үндэслэсэн байдлаар явж байгаа.

Тийм учраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нэгдүгээрт зорилтот бүлэгт шилжүүлбэ.

Зорилтот бүлэгт шилжүүлэхдээ яг гишүүний хэлсэнчлэн Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа ядуурлыг тооцдог аргачлал, манай яамнаас гаргадаг болон Үндэсний статистикийн хорооны дарга болон сайдын баталдаг амьжиргааны түвшинд тооцох аргачлал гэх мэт орлогын аргачлалуудыг сайжруулах замаар хүн амынхаа орлогыг бүрэн зөв тодорхойлоод их өгөгдөл дээр суурилоод нэг төрийн мэдээллийн бааз сайжраад байгаа учраас амьжиргааны түвшинд тооцдог аргачлалаа сайжруулъя гэсэн зорилт бас орсон байгаа.

Тэгээд энэ хүрээндээ орно.

Халамж үндсэндээ 12 хөтөлбөрийн хүрээнд 40 гаруй төрлийн халамж авдаг ийм нөхцөл байдал байгаа.

Ядуурлын түвшний хувьд Дэлхийн банкны статистикаар өдөрт 1.9 доллароос доош бага орлоготой ядуу хүн амд тооцож байгаа.

Манай Монгол Улсын хувьд гишүүний дурдсанчлан ядуурлын түвшнийг тооцдог аргачлал маань Үндэсний статистикийн хороо буюу Дэлхийн банкнаас гаргасан ядуурлын газар зүйн зураглалд үндсэн аргачлалаар тооцдог.

Тэгэхээр бид яг халамжаа олгохдоо шууд ядуурлын шугамаар олгодоггүй. Энэ бол статистик үзүүлэлтийн төдий. Нийт ядуу хүн амын хувийн жин эзлэх зорилгоор л ядуурлын хамралтын хүрээг тодорхойлох зорилгоор л гаргадаг.

Тэгээд Монгол Улс 2022 оны статистик мэдээллээр нийт хүн амын 27 хувь нь ядуу амь ярьж байна буюу нэг хүний орлого нь 400 гаруй төгрөгөөс доош байна гэж үзсэн. Ийм байгаа.

Мөн түүнчлэн “халамжаас хөдөлмөр эрхлэлт”-д шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлын хувьд бууруулах бодлого баримтална гэсэн ийм зорилт орсон.

Тэгэхээр зорилтуудын хүрээнд арга хэмжээний төлөвлөгөө нь ингээд гараад явна.

Эхний ээлжид бид аргачлалаа сайжруулах ийм шаардлага байгаа. Яг ядуурлын дүр зургийг аваад үзэхээр хөгжлийн бэрхшээлтэй.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг нэмнэ үү.

**Л.Мөнхзул:** Ядуурлын доторх бүтцийг нь аваад үзэхээр “хүүхдийн дундах ядуурал”, “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дундах ядуурал” Монгол Улсад хамгийн өндөр байгаа.

Тэгэхээр энэ чиглэл рүү халамжийн бодлогыг зорилтот бүлэг рүү чиглүүлэх бодлого баримтална гэж тооцож байна.

Түрүүн Б.Бат-Эрдэнэ гишүүний асуулт нь ерөөсөө хариулах юугүй байсаар байгаад хариулахгүй л байгаад байгаа л даа.

Хууль зүйн байнгын хороон дээр гаргасан саналыг ажлын хэсгийн хүрээнд ярилцаад эмэгтэйчүүдийн чиглэлээр бас ажлын хэсэг рүү санал, зорилтууд оруулсан байгаа.

Манайхаас саналаа боловсруулаад өгсөн. Гэхдээ ажлын хэсэг дээр эмэгтэйчүүдтэй холбоотой холбогдох асуудлууд нь эрүүл мэнд рүү, хүний эрх рүү, хүчирхийллийн эсрэг, жендерт суурилсан байдал руу ингээд хуваагдаад орсон.

Гэхдээ одоогийн байдлаар хамгийн их зөрчигдөж байгаа асуудал бол эмэгтэйчүүд дунд хөдөлмөрлөх эрх их зөрчигдөж байгаа. Охидын эрүүл мэндийн асуудал байгаа. Энэ чиглэлээр хоёр заалт гишүүний хэлсэн санаачилгын дагуу ажлын хэсэг рүү өгсөн байгаа гэдгийг ташрамд нь хэлье.

**Л.Энхнасан:** Ж.Баярмаа гишүүн тодруулъя гэж байна. Микрофоныг нь өгнө үү.

**Ж.Баярмаа:** Нэмэлт 1 минутдаа нэг үлдсэн асуултаа асуучихъя.

Яах вэ, хүүхдийн халамж, хүүхдийн мөнгө авагсдын тоо халамж авагсдын тоог их болгоод байгаа юм гэж дандаа тайлбарладаг. Би энэ тайлбарыг мэднэ.

Гэтэл дахиад статистикаар 1 сая 377 мянга буюу 40-өөд хувь нь хүүхдийн халамж авагсад биш бусад төрлийн халамж авагсад байгаа.

Тэгэхээр одоо яах вэ дээ нөгөө одонтой ээжүүд, гавьяатууд гээд зөндөө л халамж авч байна шүү дээ. Гэтэл энэ чинь орлого нь боломжтой. Баян, ядуу гэж ярих зохимжгүй боловч боломжтой айлуудад хэрэггүй мөнгө олгоод байх шаардлагатай юм уу л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр үүнийг бүр реформын шинжтэй өөрчлөлт хийж тэр орлогод суурилсан халамжийн бодлого руугаа түлхүү явах хэрэгтэй.

Ядууралыг 2 дахин бууруулна гэсэн байгаа юм. Үйл ажиллагааны хөтөлбөрт.

Тэгэхээр одоо 28 гээд бодохоор 14 хувь болгох нь л дээ. 4 жилийн дараа. Тийм ээ. Тэгэхээр үүнийг яаж тооцоолж байгаа вэ? Жилд жишээлбэл 14-ийг зүгээр хуваагаад үзэхэд 3.5 хувиар бууруулах нь.

Тэгэхээр 250 мянга орчим хүнийг жилд ядуурлаас гаргах нь. Тэгж байж хоёр дахин бууруулах дээрээ очих нь.

Тэгэхээр үүнийг яаж бууруулна гэж төлөвлөж байгаа юм? Эсрэгээрээ дандаа ядуурлаас доош түвшин рүү нь ороод нэмэгдээд байгаа энэ үед ямар арга зам, ямар менежмент бодлого хийж байж жил бүр 250 мянга орчим хүнийг ядуурлаас бууруулна гэж тооцоолж байгаа вэ?

**Л.Энхнасан:** 3 номерын микрофоныг нээнэ үү.

**Л.Мөнхзул:** Ерөнхийдөө бид нарын яг тавьж байгаа зорилт Ж.Баярмаа гишүүний хэлсэнчлэн халамжийг ер нь орлогод нийцүүлсэн байдлаар л олгодог болъё.

Яг 2019 оны судалгаагаар аваад үзэхэд нийт халамжийн сангийн зардлын 28 хувь нь хамгийн өндөр амьжиргаатай. 40 хувь зарцуулагддаг.

Тэгэхээр үүний хуваарилалтыг сайжруулаад халамжийг бууруулах гэхээсээ илүү зорилтот бүлэгт шаардлагатай. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдаж байгаа халамжийн түвшин бусад иргэдийнхтэй ойролцоо байгаа.

Тэгэхээр үүнийг ялгаатай байдлаар оруулъя гэдэг концепц бид тодорхой ажлын хэсэг гараад ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Ер нь нөгөө талаасаа хүүхдийн мөнгийг хасахаар цаана нь дахиад 1 сая хүн халамж авч байна гээд. Энэ бол бас давхардсан тоо. Нөгөө талаасаа бодитой тоо. Учир нь гэх юм бол “ахмад настан” нэг удаа жилдээ амралт, сувиллын газар амруулдаг.

Тэгэхээр үүнийг “амралтын” болон “сувиллын” гээд хууль дээр хоёр орчихсон учраас мөн тоо нь ингээд хоёр дахин нэмэгдээд явж байна.

“Одонтой ээжүүд” гээд мөн 100 орчим мянган хүн авч байна гэх мэтийн

нийтлэг мөнгөн тусламжуудын тоог оруулж байгаа.

Шинэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр оруулж байгаа зорилт нь нийтлэг мөнгөн тусламж буюу гэр бүлийн хөгжлийг дэмжих, хүн амын өсөлтийг дэмжих бодлогоо халамжаас салгая гэсэн зорилт бас оруулчихсан байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээрээ өсөлтөө дэмжих гэж байгаа зорилгуудаа салгаж явъя гэж байгаа.

Ядуурлын түвшин салбар дундын асуудал, макро эдийн засгийн асуудал.

Манай яам дангаараа ядуурлыг төдийлөн шийдэж чадахгүй.

Тэгэхээр энд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ерөнхий макро эдийн засгийн бодлоготойгоо уялдуулж өөдрөг төсөөллөөр, мөн дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтыг дагаж энэ зорилтыг оруулж ирсэн байгаа. Тэгээд энэ чиглэлээр салбар салбарын бодлогууд нь чиглэж зорилттойгоо нийцэж байгаа гэж үзэж байна.

**Л.Энхнасан:** Б.Бейсен гишүүний микрофоныг нээнэ үү. М.Нарантуяа-Нара гишүүнийг дараалалд оруулна уу.

**Б.Бейсен:** Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт тодорхой юм тавигдаагүй.

Яах вэ, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хүрээнд л ийм юм яригдаж байна. Гэтэл бодит байдал дээр 2022, 2023 онд чинь давхардсан тоогоор 3.8 сая хүн өвчилсөн байна л даа.

2022 онтой харьцуулахад 237.8 мянган хүн. Одоо 2024 оных энэ жил гарах байх.

Тэгэхээр хотын эмнэлгүүдийн ачаалал маш маш ихсэж байна. Бид 1 дүгээр эмнэлэг, клиникийн хэд хэдэн эмнэлгээр яваад үзэхэд 50-иас 60 хувь нь хөдөөгийн иргэд байна. Хотод ирж байгаа улсууд. Тэгээд зарим нь 1-ээс 2 сар очер дараалал хүлээдэг.

Тэгэхээр бүсчилсэн хөгжил дээр Эрүүл мэндийн яамныхан маань бүсийн иж бүрэн оношилгооны төв байгуулах тал дээр ер нь санал оруулахгүй бол энэ хотын эмнэлгийн ачаалал буурахгүй.

MRI аппараттай. Бүх шинжилгээ хийдэг. Тэгээд үүнийг дагасан эмч, мэргэжилтнээр хангахгүй бол үнэхээр хотын эмнэлгийн ачаалал буурах янз алга.

Би эмнэлгийн хүн учраас байнга очоод үзэж байгаа юм. Судлаад ч үзсэн.

Сумын эмнэлгүүд дээр рентгений аппарат байхгүй. Эрүүл мэндийн салбар 100 жил болоход. Уушгины хатгаа, бэртэл гэмтэл яахад бас л аймгийн эмнэлгийн ачаалал ихэсдэг, дуудлага дууддаг. Тэгээд илүү зардал гардаг. Энэ асуудал дээр энэ юундаа бас тусгах тал дээр анхаараач гээд хэлмээр байх юм. Энэ талаар бас санал дэвшүүлсэн үү. Ер нь.

Эмийн үнийн өсөлтийн асуудал байж байна. Үүнийг ер нь сум, багийн эмийн сангийн асуудлыг шийдэхгүй бол хөнгөлөлттэй эм малчид ерөөсөө авч чадахгүй байна шүү дээ. Зарим нь бүр 200 километрээс эм хайж ирээд авчихна шүү дээ. Багийн эмч нарт би бас хувиасаа хэдэн цүнх хандивласан.

Гэтэл эм тэнд хүрэлцэхгүй өндөр үнэтэй байна.

Эрүүл мэндийн салбар 100 жил болоход үндэсний эмийн үйлдвэр ерөөсөө хөгжөөгүй. Эмийн 70 хувийг нь импортоор авдаг. 29 гаруй хувийг нь л дотоодод үйлдвэрлэдэг.

Тэгэхээр энэ асуудлыг эрүүл мэндийн салбарын хөгжил, бүсчлэлийн хөгжил дээр оруулах тал дээр анхаараач гэж хэлмээр байх юм.

Дараа нь цалингийн асуудал байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний цалин бага. Ер нь манай улс шиг бага цалинтай улс орон байхгүй. Сувилагч нар нь гадагшаа гараад явж байна. Эмч нар нь ч гараад явж байна. Эрт тэтгэвэрт гаргаж байна. Сайн сайн мэргэжилтнүүдээ алдаж байна шүү дээ. Ерөөсөө. Хувийн эмнэлгүүдээрээ явчхаад байна. Улсын эмнэлгүүд залуу эмч нартай болоод. Би 2 мянган төгрөг нэмээд авчихъя.

**Л.Энхнасан:** Нэмэлт 2 минутыг өгнө үү.

**Б.Бейсен:** Эрүүл мэндийн салбарын ажилчдын 80 хувь нь цалингийн зээлтэй. Бензин шатахуун, өргөн хэрэглээний барааны үнэ, эмийн үнийн өсөлтийг даах ерөөсөө ямар ч боломжгүй болсон.

Тэгэхээр салбар дээр сайд маань асуудал тавьж байна уу?

Сая эмнэлгүүдийн өр нийтдээ 218 тэрбум гэсэн үү? Тийм ээ.

Тэгэхээр үүний хэд нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авлага уу? Өглөгө нь хэд вэ? Ер нь.



Эрүүл мэндийн даатгалын сангаас яагаад авч чадахгүй байна гэвэл нөгөө тоног төхөөрөмж шалгуурыг нь хангахгүй. Сая рентген аппарат гэх мэтээр юм алдаж байна шүү дээ, ерөөсөө.

Тэгэхээр энэ тоног төхөөрөмжийн хангалтын асуудал дээр Эм, эмнэлгийн хэрэгслийн газар ер нь судалгаа хийгээд Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газартай хамтраад сумууд дээр зөндөө тоног төхөөрөмж, наад зах нь цус, шээс, биохими, ЭГГ, эхо, тэгээд ренгэн аппараттай байгаад шинжилгээ хийчихвэл аймаг руу явах асуудал нь багасна л даа. Аймгийн эмнэлгүүдийн ачаалал их байна.

Тэгэхээр энэ дээр хамтраад нэг судалгаа хийж байгаад сургалтын асуудлыг богино хугацааны зарим аппарат, лабораторийн тоног төхөөрөмж дээр ажиллах улс богино хугацааны дагалдан сургалт ч юм уу, орон нутгийн ажлын байрны сургалтыг хийх тал дээр анхаарч байгаа асуудал байна уу? Ер нь.

2 жилийн резидент гээд явдаг. Гэтэл энэ дээр төгссөн эмч нар нь зарим нь очдоггүй. Энэ тал дээр хийж байгаа судалгаа байна уу гээд асуумаар байх юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы микрофоныг нээнэ үү. 4 дүгээр дугаар.

**Т.Мөнхсайхан:** Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр төвлөрлийг сааруулах бодлого гээд орчихсон байгаа. Энэ дээр бүх зүйлүүд орж байгаа.

Бид ер нь төвлөрлийг сааруулж сум орон нутгийнхаа тусламж, үйлчилгээг сайжруулахгүй бол бүгдийг нь Улаанбаатарт эмчлээд угаасаа

дийлэхээргүй байгаа. Ард иргэд ч хүндрэл чирэгдэл ихтэй байгаа.

Тийм учраас энэ төвлөрөл сааруулах бодлогын хүрээнд 6 бүсийн оношлогоо, эмчилгээний төв дээр иж бүрэн цогц жишиг бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийг барьж байгуулах ажил маань эхнээсээ төсөв мөнгө нь шийдэгдээд явж байгаа.

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр 6 энэ бүсийн оношлогоо, эмчилгээний төв дээр эмнэлгүүдийг ботуудыг барихаар эхнээсээ шийдэгдээд Дархан-Уул аймагт Сэргээн босголтын банкаар энэ жил ажил нь эхэлж байгаа.

Тэгээд үе шаттайгаар ер нь энэ аймгууд руу тусламж, үйлчилгээг сайжруулна.

Гэхдээ бид ер нь цаашдаа эмнэлэг барьдаг одоо энэ орны тоогоороо Монгол Улс дэлхийд нэлээн дээгүүр ороод байгаа шүү дээ. Орны тоо, эмчийнхээ тоогоор.

Тийм учраас бид цаашдаа ард иргэдийнхээ өвдсөнийх нь дараа эмчилдэг биш яаж өвдөхгүй байх вэ гэдэг бодлого руугаа илүү сум, орон нутгийнхаа түвшинд анхаарах энэ цогц ийм тогтолцоо шаардлагатай байгаад байгаа юм.

Та түрүүн бас хэлж байсан. Суман дээр гүйцэтгэлийн санхүүжилтээс болж одоо ингээд мөнгө төгрөг байхгүй гэдэг зүйл яриад байгаа. Суман дээр гүйцэтгэлийн санхүүжилт ерөөсөө хэрэгжээгүй. Сум дээр зөвхөн нэг иргэний санхүүжилт дээрээ “Сумын эрүүл мэндийн төв” чинь төсөв мөнгөө авч байгаа.



Дээр нь нэмээд 4 төрлийн тусламж, үйлчилгээг нэмээд шүү. Нэмээд санхүүжилтийг нь олгож байгаа.

Тэгэхээр сум дээр үүсэж байгаа асуудал гүйцэтгэлийн санхүүжилтийн ямар ч холбоогүй. Бид харин нэмж төсөв мөнгө гүйцэтгэлээр нь өгч байгаа учраас энэ санхүүжилтээрээ тодорхой хэмжээний аппарат, тоног төхөөрөмжүүдээ шийдээд явж байгаа “Сумын эрүүл мэндийн төв”-үүд нэлээдгүй байна. Дансандаа үлдэгдэлтэй “Сумын эрүүл мэндийн төв”-үүд ч байна.

Бид цаашдаа “Сумын эрүүл мэндийн төв”-үүдийг илүү их барилга байгууламжийнх нь талд цогцоор нь шийдэж өгөхгүй бол энэ барилга байгууламж нь харин муудчихсан. Өнөөдөр “Сумын эрүүл мэндийн төв” гэсэн мөртлөө гадаа жорлонтой зүйлүүд их байна.

Шинээр бариг баригдаж байгаа “Сумын эрүүл мэндийн төв”-үүд нь гадаанаа жорлоной баригдаж байгаа ийм тохиолдлууд байна.

Тийм учраас бид жишиг зураг гаргачихсан. Тухайн сумынхаа орон нутгийнхаа иргэдээс хамаараад 10, 15, 20 ортой эмнэлгүүдийн жишиг зураг гарчихсан. Энэ зургийн дагуу “Сумын эрүүл мэндийн төв”-үүдийг үе шаттайгаар сайжруулна гэдэг бодлого явж байгаа.

Ингэж байж бид сум, орон нутагтаа тусламж, үйлчилгээг сайн хүргэдэг болж байж Улаанбаатарт л байгаа лавлагаа шатлалын төв эмнэлгүүд маань шинэ оношилгоо, эмчилгээнүүдийг нэвтрүүлж, нутагшуулж, Монголд эмчлэгддэггүй өвчнүүдийг эмчилдэг болгодог энэ арга хэмжээг авахгүй бол Монголчууд маань гадагшаа яваад

санхүүгийн дарамтад ороод ядууралд өртөж байгаа тохиолдол маш их байгаа учраас энэ төвлөрлийг сааруулах бодлого.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Б.Бейсен гишүүний микрофоныг өгнө үү. Тодруулах.

**Б.Бейсен:** Тэгээд сумын санхүүжилтийн асуудал дээр нэг хүнд оногдох зардлаа хоёр дахин нэмээд өгсөн асуудал байгаа л даа.

Одоо яг бодит байдал дээр сайд минь сумаар яваад үзэхэд эмнэлгийн тусламжийг үзэх хэрэгтэй.

Зун би бүх сумаар явсан. Бараг хүнгүй. Төсвийг нь зарцуулсан. Эмэнд тийм юм байхгүй. Тийм л юм явагдаж байгаа. Ерөөсөө бодит байдал дээр.

Ер нь эмнэлгийн тусламжийн газар, эм, эмнэлгийн хэрэгслийн газар энэ дээр хяналт гээд Эрүүл мэндийн даатгалыг яагаад яваандаа тоног төхөөрөмжөөр хангаж байж ажил хийснээр нь яахгүй бол ер нь сумын эмнэлгүүд ажиллах боломжгүй шүү. Яах вэ нөгөө хотод ойр байгаа эмнэлгүүд ажиллах байх. Зарим нь.

Одоо хөдөө сумууд дээр зун хүн хэвтэхгүй шүү. Бараг.

Ер нь эрүүл мэндийн салбар дээр онцгой анхаарахгүй бол байнга эрүүл мэндийн салбарын сайд, эмч нар луу дайрдаг. Ард иргэд. Бодит байдал дээр нь төр нь бас нэг онцгой анхаарч үзэхгүй. Иргэд нь гадагшаагаа явдаг. Таны хэлдгээр.

Энэ тоног төхөөрөмжийн хангалтын асуудал дээр Засгийн газар мөрийн хөтөлбөрт тодорхой тусгаад, оношилгооны төв 6 аймагт биш, яваандаа

аймаг болгонд байгуулах асуудлыг шийдэхгүй бол мөн адилхан чирэгдэл үүснэ. Ер нь.

MRI аппараттай бүх төрлийн шинжилгээ хийчихдэг юутай болгочоод мэргэжилтнээр хангах асуудлыг ер нь цаашдаа шийдэх хэрэгтэй.

Эрүүл мэндийн салбар 100 жил болж байхад бид эмийн үйлдвэр ч байхгүй. Эмийн чанарын лаборатори ч гэсэн шаардлага хангахгүй ийм асуудалтай байна шүү дээ. Энэ талын асуудлыг ер нь цаашдаа анхаараад бид хамтраад шийдэхгүй бол байнга эмнэлгийн ажилчид руу дайрдаг. Тэгээд сэтгэл санаагаар унадаг. Эрүүл мэндийн салбарын сайдаасаа авхуулаад эмч, асрагч хүртлээ дайрдаг. Зарим нь зоддог. Ийм хүнд байдалтай байна шүү дээ.

Тэгэхээр чинь энэ төр засаг анхаарах цаг нь болсон. Тэгээд Эрүүл мэндийн яам, Нийгмийн бодлогын байнгын хороо энэ дээр хамтарч байгаад асуудал тавих нь зөв байх гэж бодож байна шүү дээ. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Санал гэж ойлголоо. М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгнө үү.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр юуны өмнө төсвийн асуудалд үнэхээр бас нэг сэтгэл эмзэглэж байгаа асуудлууд байна.

Эрүүл мэндийн сайдын багцад 690.0 тэрбумыг төлөвлөхөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 859.0 тэрбум гээд бүхэл бүтэн 200 орчим тэрбумын ялгаатай дүн байгаа байхгүй юу.

**Л.Энхнасан:** Мөрийн хөтөлбөрийн хууль явж байгаа. Тийм.

**М.Нарантуяа-Нара:** Мөрийн хөтөлбөр байна. Тийм.

Тэгээд би нэг зүйлд санаа зовж байгаа нь яг одоо манай эрүүл мэндийн салбарынхны хамгийн их шүүмжлүүлдэг, хамгийн их ачаалалтай, хамгийн эрсдэлтэй энэ цаг үе эхэлж байгаа. Хичээл оров уу, үгүй юу ханиад томууны үе эхэлнэ.

Эрүүл мэндийн салбарынхан, эмнэлгийн ажилтнуудын хамгийн их түмэн олонд зүхэгддэг энэ ажил эхлэх гэж байна.

Тэгээд энэ ажил маань одоо ингээд Та бүхэн бэлтгэл сайн хангаж байна уу? Би та нарынхаа өмнөөс санаа зовоод байна. Үнэндээ.

Тэгээд дээрээс нь бас нэг асуудал. Сайд байгаа нь бүр маш сайшаалтай хэрэг байна.

Одоо Монголд эмчлэгдэх боломжгүй 120 хэдэн төрөл гэж хэлж байна. Өвчнүүд байна. Энэ бол ер нь үүнээс олон байгаа гэж хэлж байна. Гэтэл яг одоо социал дээр монгол хүүхдүүд тийм ээ, гадаадад оччихсон эмчилгээнийх нь зардал нь бүрдээгүй Та бүхэнд туслаач ээ гээд.

Одоо сүүлийн арван хэдэн жилийн туршид монголчууд хойд хормойгоороо урд хормойгоо нөхөж энэ өвчтэй, зовлонтой хүүхдүүддээ хандив босгож эмчлүүлсээр мөн л барагдахгүй байна шүү дээ.

Тэгэхээр яг одоо энэ байдалд Эрүүл мэндийн сангаас хүүхдүүдийн эмчилгээний зардлыг шийдэх боломж байна уу? Энэ дээр үнэхээр асуулт асуумаар байна.

Хоёрдугаарт, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 2-рт Хүний хөгжлийн бодлого 2.1 дээр “Чинээлэг монгол хүн” гээд заачихсан байгаа. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай холбоотой асуудал шүү.

2.1.1.9 дээр “цалинтай эцэг, эх нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлээд боловсронгуй болгоно” гэсэн байгаа.

“Цалинтай эцэг, эх” гэдэгт жишээлбэл 50 мянган төгрөгийн цалинтай монгол ээж “чинээлэг монгол хүн” байж чадах уу?

Энэ “цалинтай эх, эцэг” гээд нэрлэгдсэн байгаа бол энэ цалинг цалин хөлсний доод хэмжээтэй, хөдөлмөр хөлсний доод хэмжээтэй дүйцүүлэх боломжтой юу? Боломж байгаа юу? Боломж байгаа бол хэзээнээс эхэлж хэрэгжих вэ?

Мөн хоёрдугаарт нь, 2.1.1.10 дээр “эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлнэ” гэсэн байж байна.

Энэ дээр төрсний дараах сэтгэл гутралын сэтгэцийн эрүүл мэндэд, ээжүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд чиглэсэн ийм терапи үйлчилгээ энэ тэрийг оруулсан байгаа юу? Энэ дээр тодруулга авмаар байна.

Мөн өчигдөр Хууль зүйн байнгын хороон дээр би уг нь авлигатай тэмцэх юунаас орж ирсэн, гаднаас орж ирсэн, хөрөнгө хураасан асуудлаас тийм ээ, энэ хөрөнгийг хүүхдийн тусгай Эрүүл мэндийн даатгалын.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг нь өгнө үү.

**М.Нарантуяа-Нара:** Хүсэлт тавьсан. Тэгээд энэ дэмжигдээгүй.

Тэгэхээр өчигдөр Нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга хэлэхдээ Хүүхдийн санд 18 тэрбум төгрөг цугласан байгаа, хуримтлагдсан байгаа гэсэн.

Харамсалтай нь үүнийг 3 жил хав дарчихсан. Үүнийг зарцуулах журам нь батлагдаагүй байгаа учраас зарцуулах боломжгүй ингээд хав дарчихсан байгаа.

Би уг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандаад бүр ийм хүсэлт гаргая гэж бодсон юм. Энэ журмаа маш яаралтай батлаад, энэ 18 тэрбумаас өнөө маргаашгүй амь нас нь дээсэн дөрөөн дээр байгаа хүүхдүүдийн эмчилгээний зардлыг гаргах боломж байна уу? Энэ дээр би дахин тодруулга авмаар байна.

Тэгээд “тусгай хэрэгцээт иргэд”-ийг манайхан бүр хотын захад аваачаад тусгай хэрэгцээтэй гээд нийгмээс тусгаарлаад хаячихдаг.

Гэтэл тусгай хэрэгцээт хүмүүсийн тусгай хэрэгцээнийх нь ангиллийг судлаад. Тийм ээ. Тэгээд жишээлбэл өөрсдийнх нь амьдарч байгаа дүүрэг, хэсэгт нь ерөнхий боловсролын сургуульд хамруулах, эмнэлэг үйлчилгээнд хамруулах ийм зүйлийг хийж болдоггүй юу.

Тэгээд дээрээс нь нийгмийн хамгааллын юун дээр надад нэг тодруулмаар асуудал байсан. Энэ жишээлбэл тусгай хэрэгцээт иргэдийн тоног төхөөрөмж гэгчхээд 150 сая төгрөг төсөвлөчихсөн байгаа юм.

Энэ 150 сая төгрөгт хэдэн иргэдийг энэ судалгаанд хамруулаад, хэдэн иргэдийн ямар чанар, стандарт хангасан ямар тоног төхөөрөмжийг хаанаас худалдаж авна гээд 150 сая төгрөг төсөвлөчихсөн байна.

Өөрийнхөө хүрээнд судалсан юугаар. Тийм ээ. Жишээлбэл, Франц Улсад өдөржин энэ сандал дээр хүн суудаг учраас сандлынх нь пүрш нь хүртэл ямар зөөлөнтэй байх вэ. Тийм ээ. Дээрээс нь дугуйгаа хөдөлгөж чадахгүй. Жишээлбэл, кноп дараад ажилладаг 5 сая төгрөгийн үнэтэй техник, тоног төхөөрөмжийг иргэн өөрөө судлаад 3 сая төгрөгт оруулж ирэх боломжийг нээчихсэн байж байдаг.

Гэтэл энэ 150 сая.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Хөтөлбөртэй холбоотой асуудлаар хариулт өгнө үү. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы микрофоныг нээнэ үү. 4 дүгээр микрофон.

**Т.Мөнхсайхан:** Гишүүний асуултад хариулъя.

Сургууль, цэцэрлэг цуглахаар ханиад томууны дэгдэлт ихэсдэг.

Тийм учраас бид энэ жил өөр бодлого хийж хэрэгжүүлэх ёстой гэж харж байгаа. Эмнэлэг, орны тоо нэмэгдүүлэх биш, хүүхдүүдийг яаж халдвар авхуулахгүй байх вэ, халдвар авсан тохиолдолд өрхийн түвшинд яаж оношилж, эмчлэх вэ гэдэг.

Энэ хүрээнд бид ер нь томуугийн вакцинуудын нийлүүлэлт. Одоо эхнээсээ энэ вакцин маань ирчихсэн байгаа.

Тэгэхээр вакцины хамралтыг бид нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч байгаа.

Хоёрдугаарт, сургууль, цэцэрлэгт эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах томоохон арга хэмжээнүүдийг авч байна.

Ингээд хэрвээ хүүхдүүд ханиад томууны халдвар авсан тохиолдолд өрхийн эмнэлэгтээ үзүүлэх, тэндээ эмчлүүлэх эмийн багцыг нь бид бэлтгэл ажилд орчихсон байгаа.

Эмийн багцад томууны үед хүүхдүүдийн хэрэглэх шаардлагатай, хамгийн гол нь чанартай эм, тариануудыг хангаж өгөх энэ бодлогын арга хэмжээнүүд аваг очсон байна.

Дараагийн шатын арга бол дүүргийн эмнэлгүүдэд хүүхдийн эмч нарын мэргэжил, чадавхыг сайжруулах энэ бодлогын арга хэмжээнүүд авснаараа бид ер нь жилийн ханиад томууг ер нь аль болох хүүхдүүдийг бага өвдүүлэх, өвдсөн тохиолдолд Эх нялхаст бөөнөөрөө очдог биш, өрх, дүүргийнхээ эмнэлгээр эмчлүүлэх энэ боломжийг нь бүрдүүлээд ажлууд маань эхэлчихсэн, ажлын хэсэг маань байгуулагдчихсан. Ажлууд нэлээн урагштай явж байна.

Энэ гадаадад эмчлэгдэж байгаа хүүхдүүдийг өнгөрсөн хугацаанд эмчлүүлээд ирэхээр нь санхүүжилтийн 5 хувийг нь өгдөг байсан юм.

Тэгээд энэ харин С.Чинзориг сайдын үед хуульд өөрчлөлт ороод Эрүүл мэндийг дэмжих сангаас 50 хувь хүртэлх зардлыг нь эргүүлж олгох бодлого маань хэрэгжчихсэн явж байгаа.

Ингээд гадаадад эмчлүүлээд ирсэн тохиолдолд бичиг баримтаа сайн

бүрдүүлээд өгөх юм бол 50 хүртэлх санхүүжилтийг нь олгох нь.

Гэхдээ бид бид цаашид гадаадад эмчлүүлэх бодлогыг энэ илүү дэмжих гэхээсээ илүү Монгол Улсдаа эмчлэгдэхгүй байгаа өвчлөлийг яаж эмчлэх вэ, боловсон хүчнийг нь яаж бэлдэх вэ, тоног төхөөрөмжийг нь хэрхэн яаж хангах вэ гэдэг энэ бодлого руугаа чиглэж ажиллачихсан.

Өнөөдрийн байдлаар бид 12 багийг 9 сардаа багтаагаад явуулах гэж байна. Энэ 12 багт шаардлагатай тоног төхөөрөмжийг 11 сардаа багтааж хангахаар ажлууд маань эхэлчихсэн явж байна.

Ингээд бид цаашдаа ер нь Монгол Улсаас гаднын орныг зорьж эмчилгээ, үйлчилгээ авдаггүй болгох. Үүнийг ойрын 4 жилийн хугацаанд Монголд эмчлэгдэхгүй байгаа гээд байгаа бүх өвчлөлийг Монголдоо эмчилдэг болгох 4 жилийнхээ бодлогыг бид тодорхойлоод эхнээсээ хүмүүс маань яваад эхэлчихсэн байна.

Тэгэхээр цаашдаа Монгол иргэд, ялангуяа Монгол үрс маань гадагшаа явж эмчлүүлэх шаардлагагүй болгох л энэ бодлогоо сайн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул. 3 дугаар микрофоныг нээнэ үү.

**Л.Мөнхзул:** М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, “Цалинтай ээж” хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлээд өөрчилнө гэсэн зорилт гээд.

Ерөнхийдөө “цалинтай ээж” хөтөлбөр маань 2018 оноос эхлээд хэрэгжсэн.

Тэгээд одоо энэ өнгөрсөн хугацаанд хэрэгжилтийнхээ хөтөлбөр дээр бид үнэлгээ хийх шаардлагатай байгаа. Өөрөөр хэлбэл уг хөтөлбөрт хамрагдаж байгаа эхчүүд энэ хөтөлбөрийн үр ашгийн юу гэж үзэж байна, үр дүн нь юу гэж үзэж байна гээд ажлын хэсэг байгуулаад бид хөтөлбөрийн үр дүн, анхны дэвшүүлсэн зорилгодоо нийцэж байна уу гэдэг дээр үнэлгээ хийж байгаа.

Түүнчлэн энэ мөнгөний мөнгөн дүнгийн хэмжээ дээр мөн эхчүүд маань тодорхой хэмжээнд санал өгч байгаа.

Гэхдээ бид ерөнхий байдлаар цаашдаа халамжийн бодлогыг зорилтод бүлэг рүү чиглүүлэх үндсэн малгай байгаа.

Гэхдээ 0-ээс 3 насны хүүхэд буюу хүүхдийн эхний мянга хоног, алтан үед хөрөнгө оруулалт хэд дахин үржигддэг олон улсын жишгийн дагуу бид “Цалинтай ээж” хөтөлбөрийг хууль эрх зүйн хүрээнд дахин дизайн хийнэ.

Тэгэхээр үүнийгээ бид нөгөө халамжийн бодлогоосоо салгаад, хүн амын өсөх өсгөх бодлоготойгоо явуулаад, одоо үүнийг эх үүсвэрийг өөр байдлаар шийдэхээр ийм бодлого оруулна гэж үзэж байна.

Хоёр дахь асуултын тухайд, “Хүүхдийн төлөө сан”-гийн орлого төвлөрсөн боловч зарцуулагдаагүй байна гэдэг асуудал байгаа. Энэ бодитой асуудал.

2021 онд ковидын үеэр энэ сан байгуулагдсан. Энэ сангаас юунд зарцуулж болох вэ гэдгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулж байгаа.

Тэгэхээр энэ хууль дээр ерөөсөө маш хязгаарлагдмал хүрээнд зарцуулах эрхийг нь тавьчихсан байгаа.

Манай яамны тухайд журмаар батлаагүй дээ гэсэн асуудал байхгүй. Журам нь батлагдаж явж байгаа.

Гэхдээ хуульд зарцуулах зүйл нь:

- олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаант тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг урамшуулах,
- эдгээр наадамд оролцох гэж байгаа, бэлтгэл хангаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх,
- хүүхдийн төлөө бүтээн байгуулалтыг дэмжих

гэсэн ерөөсөө л гуравхан зүйлд зарцуулахаар хуульд хатуу заасан.

Тэгэхээр энд цаашдаа бид энэ хууль эрх зүйн орчноо сайжруулж байж шаардлагатай бүлгүүдэд зарцуулахаар байгаа.

Одоо 18 тэрбум төгрөг төвлөрсөн. Цаашдаа жилд 4-өөс 5 тэрбум орчмын орлого наад зах нь төвлөрөх гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Тэгээд энэ хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр манайх үйл ажиллагааны хөтөлбөртөө зорилт тусгачихсан. “Хүүхдийн төлөө сан”. Эх үүсвэрийг нь мөн нэмэгдүүлэх чиглэлээр зорилт тусгаж оруулсан.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Тодруулгын цагийг нэмж өгнө үү.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр харамсалтай байна л даа.

Одоо жишээлбэл Эрүүл мэндийн яамны сайдын хэлж байгаагаар “4-өөс 5 жилийн хугацаанд эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, дотооддоо эмчлэх, эмчилдэг болгоно” гэж байна.

Дорвитой хариулт ерөөсөө авахгүй байна. Тэгвэл 4-өөс 5 жилийн хугацаанд бид хэдэн хүүхдийг эмчилж чадахгүй алдах вэ гэдэг асуудал байна.

“Хүүхдийн сан” гэж нэрлээд 18 тэрбум төгрөг оруулчихаад, энэ 18 тэрбум төгрөгийг зүгээр л хууль ийм байна гэдэг юм яриад.

Өнөөдөр зүгээр наадмын бэлтгэл, гадаадад олимпиадад оролцсон хүүхдүүдийн шагнал, урамшуулыг эндээс шийднэ гээд байж болохгүй.

“Хүүхдийн сан” гээд нэрлэсэн юм бол хүүхдэд тулгамдсан нэн яаралтай зохицуулах ажлыг эндээс хийх ёстой. Энэ хуулийг өөрчлөх хэрэгтэй. Энэ дээр гишүүд дэмжих хэрэгтэй. Тийм биз дээ.

Тэгэхгүй бол одоо өнөө маргаашгүй болсон өчнөөн олон хүүхдүүд байна.

Тэгээд дээрээс нь би бодож байна. Эрүүл мэндийн үйлчилгээ аваад буцаад ирэхээр нь 5 хувь байсныг 50 хувь хүртэл нэмэгдүүлээ гээд.

Хамгийн гол нь эмчилгээний зардлыг бүрдүүлэхэд цаг хугацаа асар их шаардагдаад, энэ хооронд хүүхдийн өвчлөл, хорт хавдар нь бүр газар аваад,



хүүхдүүд маань амь насаа хамгаалуулж чадахгүй байгаа.

Үндсэн хуульд эх, хүүхэд, эх нялхсын эрх ашгийг, эх хүүхдийг төр хамгаална гээд заачихсан байгаа.

Тэгсэн мөртлөө “хууль нь ийм байна” гээд нэг гоё юм биччихээд сууж боломгүй байна.

Одоо бүгдээрээ үнэхээр шаардлагатай зүйлүүдийг өөрчилье. Тэгээд хамгийн гол нь юу тулгамдсан бэ, юу нэн яаралтай юм бэ гэдгээ бид эрэмбэлмээр байна.

Тэгээд жишээлбэл Нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга хэлж байна. Ийм 3 зүйлээр хуульчлагдчихсан. Энэ хүүхдийн сангийн мөнгө бол гээд.

Тэгтэл энэ бүх яам, сан.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт асуултад сайд хариулна уу? 4 дүгээр микрофон.

**Т.Мөнхсайхан:** Маш тодорхой хариулсан даа. Тийм ээ. Эмчилгээнд хамрагдсан хүүхдүүдэд олгодог санхүүжилт нь 5 байсан 50 хувь болчихжээ.

Тэгээд хамгийн богино хугацаанд бид яаж Монголд эмчлэгдэхгүй байгаа өвчлөлийг эмчилдэг болгох вэ гэдэг бодлогоо 4 жилийнхээ төлөвлөгөөгөө гаргачихсан байна гэдгийг тодорхой ярьсан.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чинь зайлшгүй цаг хугацаа шаардлагатай. Боловсон хүчнийг бэлдэх. Эргээд чинь хүний эрүүл мэнд, амь настай холбоотой зүйл учраас ганц

нэгхэн сар сургаж ирчхээд эргээд Монголд эмчлэгдэхгүй байгаа өвчнийг эмчилдэг болчихлоо гэж ярьж болохгүй.

Тийм учраас хугацаа дээр их орно.

Тийм учраас 4 жилийнхээ төлөвлөгөөг гаргачихсан байгаа. Энэ жагсаалтаар 26 гэж байгаа боловч яг нарийн эрхтэн системээр нь тухайн өвчлөл болгон дээр нь аваад үзэх юм бол 260 байхыг ч үгүйсгэхгүй.

Тийм учраас энэ жагсаалтуудаа бид маш нарийн тодорхой гаргаад төлөвлөлтөө гаргачихсан байгаа гэдэг хариултыг маш тодорхой хэлээд байгаа юм.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Дэгээ дагана шүү. Гишүүд ээ. Асуулт асууж дууслаа. /алх цохив/

Төслийн 1 дүгээр зүйл-тэй холбоотой зарчмын зөрүүтэй саналууд гишүүдээс ирсэн.

Гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулж санал хураалтаа хийе.

Ж.Баясгалан гишүүнээс ирсэн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

2.1.1.19-д “инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болгох” гэж өөрчлөх.

Гишүүн өөрөө тайлбар өгөх боломжтой.

Ж.Баясгалан гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ж.Баясгалан:** Дарга аа, тэгэхээр энэ 3 заалт байгаа.



Тэгэхээр 3 дээрээ нэгмөсөн өгчих үү. Эхлээд Та гурвууланг нь танилцуулчихъя. Тэгэх үү.

**Л.Энхнасан:** Дэгээрээ тус бүрээр санал хураадаг болохоор тайлбараа нийлбэрээр нь хэлчхэж болно.

Ж.Баясгалан гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ж.Баясгалан:** Энэ дээр гол нь нөгөө “инфляц”. Түрүүн бид ярьсан.

Тэгээд “оны өмнөх инфляцын жилийн дундаж болон” гэж өөрчлөх нь өөрөө бусад хууль дээр байгаа.

Тэгэхээр бидний баримталж байгаа төслийн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр болохоор “оны өмнөх” гэхгүй шууд “инфляц” гээд орчихсон байгаа болохоор хуулиудтайгаа нийцүүлж “оны өмнөх” гэдэг ийм саналыг оруулсан юм шүү.

Бусад хууль тогтоомжтойгоо нийцэх ёстой гэж үзэж байгаа юм шүү. Гишүүд ээ.

**Л.Энхнасан:** Саналыг нь уншиж танилцуулъя. “Инфляц” гэснийг “өмнөх оны инфляцыг жилийн дундаж” гэж болгон өөрчлөх.

2.1.1.19. Дэмжихээр санал хураалт явуулья.

Төхөөрөмж ажилласангүй. Хүчингүйд тооцох горимын санал гаргая. Төхөөрөмж бүгдээрээ ажилласангүй.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураая.

52 хувиар хүчингүйд тооцлоо.

Дахин санал хураалт хийе. 2.1.1.19-ийн “инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж” гэж болгож өөрчлөх. Дэмжих. Санал хураалт.

Би горимын санал гишүүд байна уу? Сая уншигдсан уншигдаагүй.

Тайлбар өгнө үү. Гишүүдэд. 1 дүгээр микрофон. Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

**Л.Балчинлуvsан:** Тийм. Яг үйл ажиллагааны хөтөлбөр дээр томьёолсон байдлаар бид холбогдох агуулгаараа явж байгаа.

Томьёолол нь хуучин байгаагаараа явсан нь зүгээр.

**Л.Энхнасан:** Ж.Баясгалан гишүүний саяын санал 52.6 саналаар дэмжигдсэнгүй.

Сая горимын саналтай хүн байна уу гэж санал хэлэхэд хэн ч дуугарсангүй.

Тайлбарыг нэмж өгнө үү. 1 дүгээр микрофон. Тайлбарыг сонсчхоод тэгээд явъя. 1 дүгээр микрофон.

**Л.Балчинлуvsан:** Ер нь цалин, тэтгэврийг бид инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх тийм ойлголт эдийн засгийн агуулгаараа явдаг.

Та жилийн дундаж гээд өмнөх жилүүдийн дундаж өсөлттэй гэдгээр тайлбарлаж байна гэж ойлголоо. Олон жилүүдийнх гээд. Суурь он заавал тавигдах шаардлага болж өгнө. Яг хэдэн жилийнхээр гэдэг. Ахиад цаашаа маргаан явчих учраас яг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдэнэ гээд. Одоо жишээ нь 2023 онд инфляцын түвшин 2022 онд 16.7

байсан бол түүнтэй уялдуулж нэмэгдүүлнэ гэдэг шиг. Тийм.

**Л.Энхнасан:** Томьёоллын дахиад хэлье. “Инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болгох” гэж өөрчлөх. Ж.Баясгалан гишүүн тайлбар өгнө үү.

**Ж.Баясгалан:** 2.1.1.19. Түрүүн хэлэхдээ гол юм нь ийм л байгаа юм л даа. Бусад хуулиудтай гэсэн л дээ. Би.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль. Түүнтэй уялдуулж энэ саналыг гаргаж байгаа юм.

Тэгэхээр тэр хууль дээрээ болохоороо “оны өмнөх инфляцын жилийн дундаж” гэж байгаа. Гэтэл бид мөрийн хөтөлбөр дээрээ болоод ороод ирэнгүүт, үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ болоод ороод ирэнгүүт “инфляц” гэсэн нь зөрөөд байгаа учраас л энэ асуудлыг ярьсан юм.

Тэгэхээр та нар баталгаатай албан ёсны мэдээлэл өгчихвөл татаж болно шүү дээ. Тийм ээ.

**Л.Энхнасан:** 2 номерын микрофоныг өгье Гишүүддээ нэлээн ойлгогдохоор тайлбарлаад өгөөч.

**Б.Алимаа:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Алимаа.

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр олгохтой холбоотой хуулийн зохицуулалт өмнөх оны. Одоо эндээс би хууль хараад л байна.

Ер нь яах вэ, дундаж гэвэл инфляцын түвшин улирал бүрийн

дунджаар л жилийн эцсийнхийгээ тооцчихож байгаа. Ингэж хатуу нарийн хийх шаардлага байхгүй болов уу гэж бодож байна.

Ер нь өмнөх ерөнхий ойлголтоороо инфляцын түвшинтэй уялдуулаад л явчихдаг ийм зохицуулалт байж байгаа.

Тэгэхээр заавал энэ дундаж гэж статистикийн аргачлалынх нь хувьд нь ингэж хэлэх шаардлага байхгүй болов уу.

Ер нь жилийн дунджаараа л 4 улирлынхаа дунджаар жилийн инфляцаа тогтоогоод л явчхаж байгаа. Одоо хуулийг нь би энд.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Гишүүд ээ, горимын саналтай хүн байвал саяын асуудлаар.

Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Баярмаа:** Зарчмын зөрүүтэй саналын оруулж байгаа үндэслэлийг нь хэзээ тайлбарласан юм бол? Тайлбарладаггүйгээр ингээд шууд уншчихдаг юм уу гэдэг нэг асуунгаа нэг их асуулт байна.

Хоёрт, тэгэхгүй болохоор чинь нэг ийм горимын санал оруулдаг. Шууд санал хураахаар чинь үндэслэл нь юу байсныг мэдэхгүй. Ингээд дундаас нь замбараагүй байдал үүсэж байна.

Тэгэхдээ зүгээр бид чинь шинэ гишүүн учир яг энэ Байнгын хорооны дэг яаж явдгийг мэдэхгүй байна.

Нэгэнт эхэлсэн тул хуульд ингээд заачихсан тул хуульдаа нийцүүлээд тэр жилийн дундаж гэдгийг оруулахгүй юм

уу л гэсэн нэг их тийм ноцтой биш юм л яриад байна л даа.

Тэгэхээр хуульдаа яагаад тэгээд тус чихсан юм. Тийм ээ. Дандаа тэгж явах ёстой бол энэ дээрээ ч гэсэн тэгээд адилхан тусгачхаач ээ л гэсэн санал хэлсэн юм байна шүү дээ.

Тэгэхээр би тэрийг нь дахиж тайлбарлуулаад, дахиад санал хураах нь зүйтэй гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Дахин санал хураах горимын саналыг хүлээж авлаа.

Түрүүн Ж.Баясгалан гишүүн өөрөө тайлбар хэлсэн. Төхөөрөмж ажиллаагүй учраас 2 гишүүний түрүүний саналыг хүчингүйд тооцох дахин санал хураалт явуулъя.

Дахин санал хураалт явуулах санал дэмжигдсэнгүй.

Дараачийн заалтыг уншъя. “Инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болгох” гэж өөрчлөх саналыг 52 хувиар татгалзсан байна. /алх цохив/

2.1.1.21-д “стандартыг” гэсний дараа “албан байгууллага” гэж нэмж өөрчлөх.

Ж.Баясгалан гишүүн тайлбараа хийнэ үү.

**Ж.Баясгалан:** Энэ дээр орон сууц, нийтийн барилга, байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна гээд орсон байгаа.

Тэгээд энэ дээр “албан газар” гэж ерөөсөө ороогүй байгаа юм. Энэ дээр

“үйлчилгээний байгууллагууд, хувийн хэвшил, орон сууц” гэж орсон байгаа.

Тэгэхээр төр өөрөө, албан байгууллага өөрөө хуулиа биелүүлэхгүй бол болохгүй. Тийм болохоор албан байгууллага гэдэг үгийг нэмж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Тэгээд Та бүхэн саналаа өгөхдөө энэ дээр онцгой анхаарч өгөөрэй. Баярлалаа.

### **Л.Энхнасан:**

2.1.1.21.“стандартыг” гэсний дараа “албан байгууллага” гэж нэмэх саналыг дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

### 63.2 хувиар дэмжигдлээ.

Гурав дахь санал. Төсөлд доор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь дэд заалтыг нэмэх:

“2.3.2.8.сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.” гэсэн заалт нэмэхээр санал оруулсан байна.

Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Баясгалан:** Энэ дээр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай хуулийн заалт дээр 2.3.2 дугаар зүйлд “эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж” гэсэн хэсэг байгаа. Энэ хэсэг 7 заалттай.

Тэгэхээр энд тусгагдаагүй би 8 дахь заалтыг оруулж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Тэр нь юу вэ гэвэл “сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана” гэж оруулж өгөөч ээ гэж хүссэн юм.

Энэ дээр жоохон тайлбар хэлэхэд түрүүчийн хэлсэн Монгол Улс эмчлэх боломжгүй гээд гадагшаа гарч байгаа 29 төрлийн өвчин эмгэг байгаа гэж байгаа.

Тэгэхээр энэ бүхнийг Монгол Улсдаа эмчилдэг болмоор байна. Цаг хугацааны хувьд алдмааргүй байна. Тэгээд мөнгө төгрөгийн хувьд бид гадагшаа явахад зөвхөн эмчилгээндээ биш тэр эмчилгээнд дагаж яваа хүмүүсийн хувьд ч гэсэн маш их хөрөнгө мөнгө гардаг.

Тэгэхээр стандарт өөрөө Монголд биелчих юм бол бид Монголдоо сайхан амьдрах бас нэг боломж бүрдэх юм гэсэн үүднээс энэ заалтыг оруулж өгсөн юм.

Ингээд Та бүхэн сайн уншаад үзээрэй. Тэгээд дэмжээд өгөөрэй. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Ж.Баясгалан гишүүний нэмэлтийг дахиж уншъя.

2.3.2.8.сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана гэсэн. Үүнийг дэмжиж байна гэсэн санал хураалт хийе. /алх цохив/

Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя гэсэн учраас гишүүний асуултыг сонсчхоод.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё. Тэгээд Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултыг сонсъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Энэ нэлээн нарийн юмнууд л яриад байна л даа. Тэгээд нэлээн чухал юмнууд яригдаад байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан, Эдийн засгийн хөгжлийн яамныхан энэ асуудлуудыг их зөв оруулж ирэхгүй тоймлоод, хариулт нь хүртэл зүгээр л аргацаасан хэлбэрээр, хүн хуурсан хэлбэртэй л яваад байх юм.

Уг нь иймэрхүү зүйлс дээр маш тодорхой, дэлгэрэнгүй мэдээллүүдийг нэгдүгээрт сайн өгдөг баймаар байгаа.

Түрүүн орчны бохирдолтой холбоотой асуудал дээр хүртэл хуваагдаад орчихсон байгаа гээд Эдийн засаг, хөгжлийн яамны хүн худлаа ярьж байгаа шүү дээ.

Бид өнөөдөр наадахыг чинь бүгдийг нь уншаад сууж байгаа. Хэчнээн орчны бохирдол байдаг гэж бодож байна.

Одоо энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлууд байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Бас түрүүн танай Төрийн нарийн бичгийн дарга худлаа ярьсаар байгаад л гараад явсан.

Тэгээд иймэрхүү юмнууд дээрээ Та бүхэн өөрсдөө мэргэжлийн үүднээс хандаач ээ гэж би хэлэх гэж байгаа юм. Тэгээд бид нарыг энэ мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрийг уншдаггүй гэж боддог юм уу. Эсвэл урьд нь байсан

Улсын Их Хурлын гишүүд нь уншдаггүй орж ирээд Та нараас мэдээлэл хийчхээд ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг юманд чинь итгээд гараад яваад байдаг байсан юм уу. Үүнийгээ Та нар их сайн анхаараарай гэдгийг би нэгдүгээрт хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ялангуяа энэ оруулж байгаа заалтуудтай холбоотой асуудал дээр “сэргээн засах”, “нөхөн сэргээх” гээд мэргэжлийн үүднээс бид тодорхой хэмжээний хандахгүй бол эд нар чинь өөрөө дотроо өөр өөр байгаа.

Тэгээд нэг хоёр үг, үсэг хаягдчих вий. Тэр нь өөрөө зөвхөн нэг хэсгийн дагнасан хэлбэр дээрээ бас явчих вий гэж санаа зовоод байна л даа.

Тэгээд энэ чинь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Энэ чинь намуудын Улсын Их Хурлын сонгуульд орсон мөрийн хөтөлбөр өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр тулгуурлаж байж 2024-2028 оны чинь улсын төсөв яригдана.

Тэгээд өнөөдөр энд бид үйл ажиллагааны хөтөлбөрөө батлах гээд энэ хэлэлцүүлэг явж байх процесс дээр Та нар зүгээр ажилласан гэсэн утгаараа л хамгаалалтаа хийгээд байгаа байхгүй юу.

Уг нь үүнийг чинь бид дэлгэрэнгүй байдлаар нь яриад, тусгаад, оруулаад зөв баталж чадвал үйл ажиллагааны хөтөлбөрөө дагаад бид ирэх 2024, 2025, 2026, 2027, 2028 гээд тодорхой хэмжээний төсөвтэй холбоотой асуудлуудыг энд хөндөх гээд байгаа шүү дээ. Та нарын асуудлыг яриад байгаа шүү дээ. Энд. Та нарыг хамгаалах байр суурин дээр биш Улсын Их Хурлын гишүүдэд тодорхой хэмжээний бүрэн дүүрэн

мэргэжлийн үүднээс хариултуудыг нь өгөөд хамтраад хэдүүлээ энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг засаад явах ёстой байхгүй юу. Засаад явах ёстой.

Түүнээс биш Та нарыг өнөөдөр энд гэрийн даалгаврыг чинь шалгах гэж байгаа юм шиг бид асуугаад Та нар тэрийгээ хамгаалаад байх хэлбэр ерөөсөө биш шүү дээ.

Наад суудал дээр чинь би өөрөө сууж байсан. Ерөөсөө Та нарт ийм юм анзаарагдахгүй байна.

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад хариулах ажлын хэсэг хариулна уу. 4 дүгээр микрофоныг өгнө үү.

**Т.Мөнхсайхан:** Ингээд өвчлөл болгоноор нь ч юм уу, эмчилгээ болгоноор нь задлаад мөрийн хөтөлбөрт оруулах юм бол одоо энэ чинь маш их юм орно шүү дээ.

“Нөхөн сэргээх”, “сэргээн засах”. Бусад төрлийн маш олон тусламж, үйлчилгээ байгаа л даа. Тэр болгоныг энэ дээр жагсааж оруулах болно.

Тэгэхээр ер нь Монголд эмчлэгдэхгүй байгаа, хийгдэхгүй байгаа тусламж, үйлчилгээнүүдийг цогцоор нь сайжруулах, нэмэгдүүлэх гэдэг агуулгаараа байж байгаа учраас бид үүнийг мөрийн хөтөлбөрт бүгдийг нь задалж оруулах юм жоохон утгагүй л юм болно.

Тэгэхээр үүнийг “сэргээн засах”, “нөхөн сэргээх” гэдгийг оруулах нь тийм оновчтой биш болов уу л гэж бодож байна даа.

**Л.Энхнасан:** Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг.

**Б.Бат-Эрдэнэ:** Юу. Зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа учраас Ж.Баясгалан гишүүнээс асуугаад байгаа юм л даа.

Одоо сая жишээлбэл Т.Мөнхсайхан сайдын хэлдэг үнэн байхгүй юу. Бид жишээлбэл дээр сэргээн засах тусламж. Одоо энэ дээр нэмээд байна шүү дээ.

2.3.2.8 дээр нэмж байна. Нэмэлтээр сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх. Тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана гэж оруулж ирээд ирээд байгаа.

Тэгэхээр миний асуугаад байгаа асуулт нь Ж.Баясгалан гишүүнээс юу гэж асууж байгаа вэ гэхээр зарчмын зөрүүтэй санал учраас сэргээн засах тусламж, үйлчилгээ гэдэг тэр чигээрээ. Энэ дотор “нөхөн сэргээх” чинь орох юм уу, эсвэл “сэргээн засах”-аараа явах юм уу? Яг зарчмын зөрүүтэй саналыг ямар томъёоллоор юу гэж оруулж байгаа юм бэ?

Саяын Т.Мөнхсайхан сайдын яриад байгаа шиг хэрвээ детальный оруулах болох юм бол бүх юм орох болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг тайлбарлаад өгөөч ээ л гэж асууж байгаа юм. Санал, асуулт гэсэн үг.

**Л.Энхнасан:** Ж.Баясгалан гишүүн хариултаа өгнө үү.

**Ж.Баясгалан:** Энд одоо тэртээ тэргүй нэгэнт энэ Байнгын хорооныхон бүгдээрээ санал бодлоо солилцож байж бидний зөв эцсийн хариу гарна.

Тэгээд “сэргээн засах” гэдэгт “нөхөн сэргээх” орохгүй байна. “Нөхөн сэргээх” тусдаа болчхоод байгаа. Нэр томъёоны хувьд ч тэр.

Тэгэхээр яах вэ, би энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг уншиж байх явцад энэ “сэргээн засах” л хаягдчихаад байсан л даа. Гол нь. Тэр утгаар нь “сэргээн засах” гэдэг юмыг ерөөсөө энэ бүлгийг тэр чигээр нь хаяж болохгүй гэдэг үүднээс энэ нэр томъёог оруулж ирсэн байгаа юм. 2.3.2.8 гэдэг энэ заалтыг оруулж ирсэн байгаа юм шүү. “Нөхөн сэргээх” энд орохгүй.

**Л.Энхнасан:** Бусад гишүүдээс асуулт байна уу? Тодруулах юм. Байхгүй бол Ж.Баясгалан гишүүний саяын 2.3.2.8-ын “сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана” гэсэн саналыг дэмжинэ гэсэн нэр томъёогоор санал хураалт хийе.

63.2 хувиар зөвшөөрөгдсөн байна.

О.Саранчулуун гишүүн зөвшөөрсөн байна.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг нь танилцуулъя.

Миний өөрийн гаргасан санал байгаа.



Төслийн хавсралтын 1 дээр Хүний хөгжлийн бодлогын 2.1.1.2 дахь заалтад “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулна” гэснийг “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүй хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх саналтай байна.

Яах вэ, ер нь сая Ж.Баясгалан гишүүний саналтай төстэй болж байх шиг байна. Тэгэхдээ ер нь гэр бүлүүдийн, залуучуудын салалт маш их байгаа. Өдөрт бараг 10 гэр бүл салж байгаа.

Гэр бүл салсан залуучуудад сэтгэл зүйн үйлчилгээ авах газар байхгүй, эсвэл эдийн засгийн боломж ч байхгүй учраас нэгэнт гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв бий болж байгаа бол гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг. Мөн гэр бүлийн гишүүдийн ёс зүйн харилцааг дээшлүүлэх гэсэн ийм заалт нэмж оруулахыг хүсэж байгаа юм.

С.Зулпхар гишүүний микрофоныг нээе.

**С.Зулпхар:** Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны даргын гаргаж байгаа саналыг бүхэлд нь саяын цогц үйлчилгээ гэдэг дотор ер нь бүгд байгаа гэдэг санал хэлж байна. Тэр бол үнэн.

Хоёрдугаарт, Хүүхэд хамгааллын тухай хууль баталчихсан. Тэр дагуу ер нь гэр бүлд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нийгмийн ажилтнуудын орон тоо батлагдчихсан. Ингээд явж байгаа юм.

Тэр бол тэртээ тэргүй чиг үүргээр байж байгаа.

Яах вэ, би зүгээр таны гаргасан саналтай холбогдуулаад сүүлийн тэр “гэр бүлийн гишүүдийн ёс зүйн” гэдэг дээр ийм “ёс зүйн харилцаа” гэж байхгүй юм. “Ёс суртахууны харилцаа” байна. Гэр бүлд.

“Ёс зүй” бол цэвэр албаны болон тодорхой байгууллагын түвшинд яригддаг учраас хэрвээ саяын санал орж байгаа бол “ёс зүй” биш, “ёс суртахууны” гэдэг байдлаар орох байх гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** М.Нарантуяа-Нарагийн микрофоныг өгнө үү.

**М.Нарантуяа-Нара:** Энэ “гэр бүл салсны дараах сэтгэл зүйн үйлчилгээ” гэдэг бол бас энэ буруу юм биш.

Ялангуяа хүүхдээ авч үлдэж байгаа тал санхүү, амьжиргааны гээд олон олон сэтгэл санааны дарамтууд үүсдэг. Энэ дээр байж болох зүйл.

Харин төрийн түшээдийн ч юм уу тийм ээ, улс төрийн өндөр албан тушаалтны ёс зүйг бид хуульчилж болно.

Гэхдээ гэр бүл доторх харилцааны ёс зүйн хэм хэмжээг хуульчилна гэвэл хамгийн утгагүй зүйл. Бүх юмыг хуульчлаад байж болохгүй шүү дээ.

Тэгээд одоо юу гэх юм. Эхнэр ёс зүйн хэм хэмжээгээ зөрччихлөө гээд Зөрчлийн хуулиар явах юм уу, гэмт хэрэг, ямар хуулийн юугаар хийх юм гэдэг чинь энэ чинь аягүй буруу зүйл байна гэж би хувьдаа бодож байна.



Бусдаар тэр “сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх”, ялангуяа үүссэн нөхцөл байдал, үр дагавартай холбоотой “сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ” энэ тэр байж болно.

Гэхдээ энэ бол бас дахиад л яаж төсөв яах вэ гэдэг ингээд л бас нэлээн том асуудал руу орох байх гэж хувьдаа бодож байна.

**Л.Энхнасан:** Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Дарга аа, сая уг нь ингэсэн шүү дээ. Би асуугаад хэлээд. Нөгөө “сэргээн засах тусламж”, “нөхөн сэргээх” хоёрын ялгааг нь гаргаж хэлүүлээд, энэ нь орж байгаа юм уу, орохгүй юм уу гэж асуусан.

Сая Ж.Баясгалан гишүүний 2.3.2.8 дээр “сэргээн засах тусламж” гээд орчихсон байхгүй юу. Энэ дотор таны саяын хэлсэн заалт чинь байгаа. Өөрөөр хэлбэл давхардах гээд байна гэсэн үг.

“Сэргээн засах” гэдэг дотор чинь өөрөө орж байгаа. “Нөхөн сэргээх” гэдэг чинь ахиад тусдаа асуудал.

Тэгэхээр түүн дээр та ямар бодолтой байгаа юм. Яг энэ “сэргээн засах” гэдэг утга агуулгын хүрээнд явж байгаа зүйлийг давхардаж оруулах шаардлагатай юм уу л гэж би асуух гэж байгаа юм.

**Л.Энхнасан:** Энэ асуудал явчихсан, дуусчихсан учраас, санал хураалт хийчихсэн учраас саяын энэ заалттай холбоотой асуудлаа ярья.

Энэ болохоор нөгөө “Гэр бүлийн цогц үйлчилгээний төв” байхгүй юу. Тийм. Нөгөөдөх бол эрүүл мэнд. Хоёр өөр заалтад орж байгаа юм.

Тэгэхдээ ер нь энэ дээр шууд санал. Дэмжиж байна уу, дэмжихгүй байна уу гээд санал хураалтаа хийчихсэн нь зүйтэй байх.

Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлээр ажиллуулж, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн харилцааг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ гэж өөрчлөхийг дэмжих санал хураалт хийе. /алх цохив/

Ирц хүрэхгүй болчих байх. Зөрүүтэй санал нэлээн их байгаа учраас бид нэлээн л ярина даа.

Горимын саналтай гишүүн байвал саналаа хэлнэ үү. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээнэ үү. С.Эрдэнэбатын. Уучлаарай. Гишүүний микрофоныг.

**С.Эрдэнэбат:** Саяын ийм задлах заалтуудыг дарга аа, дараа нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулахаар хөтөлбөр дотроо задлаад оруулах юм билээ шүү дээ. Тийм ээ. Бүлэглээд бүлэглээд.

Түүн дээрээ оруулаад явахгүй бол үлдчих вий гэж бодоод гишүүд маань яг энд үг, үсгээр нь оруулья гээд байх шиг байна.

Тэгэхээр хэдүүлээ горимын хувьд задалж болох тэр заалтуудыг нь ялгаад оруулчихъя.

Харин үзэл баримтлалын хувьд огт тусаагүй орхичих гээд байгаа гэдэг юмнууд дээрээ явчихвал дээр юм.

Яг түрүүний таны санал бол яг задлах дотор оруулаад гэр бүл, нөгөө салсан, дотроо ингээд зөндөө задарна

шүү дээ. Тийм ээ. Тэгээд явчихвал арай дээр юм болов уу гэж бодож байна. Тийм.

**Л.Энхнасан:** Саяын санал 84.2 хувиар дэмжигдсэнгүй.

С.Зулпхар гишүүний зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

2.1.2.10-г “хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурласан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэж нэмэх санал оруулсан байна.

Тайлбараа хэлнэ үү. С.Зулпхар гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Зулпхар:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтын гол зорилтуудын нэг бол “зохистой хөдөлмөр эрхлэлт” юм.

Ер нь зүгээр манай Засгийн газрын ч бай, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд дээр хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хангуулах чиглэлээрх зорилт их тийм бүрхэг тусгагдсан юм билээ.

Бид энэ “Алсын хараа”-г харахад ч гэсэн бас тийм байгаа юм. Гэхдээ энэ ажил хийгдээд явж байдаг.

Өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн насны 2.3 орчим сая иргэн, ажиллах хүчин 1.4 сая болчихсон. Ажиллагсад 1.3 сая байгаа юм. Энэ цаашдаа ингээд нэмэгдээд явна.

Үүнтэй холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг бид заавал энд зорилт болгож оруулах ёстой.

Яагаад гэхээр зэрэг Засгийн газар 2023 оны 7 сард Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчтой хамтарсан байдлаар хэлэлцээр байгуулж байсан. Энэ хэлэлцээрт үүнийг тухайлан тусгасан юм.

Тэгэхээр бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа эдгээр баримт бичгүүдээ Та бүхэн анхаараарай гэдэг саналыг анх хэлж байсан. Анхаарч явж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Тэгэхдээ их тийм явцуу байдлаар эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал дээр орсон байна лээ. Уул уурхайн салбар дахь эрэгтэйчүүдийн хөдөлмөр, аюулгүй байдал гэж.

Ингэх юм бол их тийм явцуу асуудал болчихно. Энэ уул уурхайн салбарт ажиллаж байгаа нэг хэсэг ажиллагсдын л асуудал болоод, бусад саяын хэлсэн 1.3 сая хүн ажиллаж байна шүү дээ. Эдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал орхигдох гээд байна л гэдэг ийм л саналын үүднээс үүнийг ерөнхий зорилт болгочихъё гэсэн санал хэлж байгаа юм.

Нөгөөтээгүүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал дан ганц хүний нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой асуудал биш. Энэ бол бүхэлдээ эдийн засгийн үр дагавар. Ийм зүйл байдаг л даа.

Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотойгоор заримдаа үүнийг хангаагүйгээс болоод дотоодын нийт бүтээгдэхүүний 1-ээс 3 хүртэл хувийн тийм эрсдэлүүд үүсдэг. Энэ эрсдэлийг даван туулах, цаашлаад нийгмийн хамгааллын сангуудын эрсдэлийг ямар нэгэн байдлаар багасгах зорилготой.

Нөгөөтээгүүр бидний сая дэвшүүлсэн зорилт байгаа шүү дээ. Гэр бүлийн хөгжлийн цогц хөгжил гэж. Энэ цогц хөгжлийг хангахтай холбоотой зорилт учраас үүнийг одоо жишээ нь оруулж өгөөч ээ гэж би санал оруулж байгаа юм.

Урьд нь Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч байсан С.Эрдэнэбат гишүүн маань ч гэсэн сууж байна. Сая зарим гишүүд маань ч гэсэн үүнийг онцгойлон асууж байгаад талархалтай байна.

Та бүхэн дээр анхаарч дэмжиж өгөөрэй. Баярлалаа.

**С.Энхнасан:** Санал хураалт явуулья. Асуух гишүүд байна уу?

2.1.2.10. “хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурласан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэснийг дэмжихээр санал хураалт явуулья. /алх цохив/

63.2 хувиар дэмжигдсэн байна.

Дараагийн санал. С.Зулпхар гишүүний санал.

2.2.3.2. Багшлах хүний нөөц, хүний нөөц болохоор манайтай манай Нийгмийн хороотой холбоотой гэж үзэж байна.

“Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулна” гэж нэмж өөрчлөх санал оруулж байна.

С.Зулпхар гишүүн тайлбараа хэлнэ үү.

**С.Зулпхар:** Байнгын хорооны даргад баярлалаа.

Өчигдөр бид Боловсролын байнгын хороон дээр саналаа хэлэх гээд бид амжаагүй.

Нөгөөтээгүүр хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан байдлаар, хүний хөгжилтэй уялдсан байдлаар боловсролын тогтолцооны чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр гэх юм бол энэ их чухал зорилт байгаа юм.

Одоо бидэнд багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоо бий. Ямар нэгэн байдлаар энэ ажиллаж байгаа. Тодорхой үр дүн ч гарч байгаа.

Гэхдээ үүнийг цаашид бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдэг үүднээс энэ санал орж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар 859 ерөнхий боловсролын сургуульд 36 мянга гаруй багш ажиллаж байна. Түүнээс гадна 1413 сургуулийн өмнөх болосвролын байгууллагад 9450 багш багшилж байгаа юм.

Тэгэхээр энэ бол үндсэндээ 45 мянган багшлах хүний нөөцийг үндэсний хэмжээнд чадавхжуулахтай холбоотой том тогтолцоог хэдүүлээ бэхжүүлэх, чадавхжуулах чиглэлийн энэ зорилтыг оруулах нь зүйтэй гэж үзсэн юм.

Ингээд томъёололыг бид ийм хоёр заалт нэмж байгаа юм. Энэ дотор агуулга нэмж байгаа юм.

“Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэе”, “багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулья” гэсэн байгаа юм.

Ингэхээр зэрэг энэ томъёолол багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн, багшлах эрх олгох

хялбаршуулсан сургалтын зохицуулалт бий болгож, багшлах мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар багшлах хүний чадавхыг сайжруулж, багшийн хомсдолыг бууруулна гэсэн байгаа юм.

Анх сүүлийн хэсэг нь байсан. Сүүлийн хэсэг нь байхаар зэрэг энэ арга хэмжээний зөвхөн нэг хэсгийг нь оруулаад үндсэн тогтолцоогоо орхичихсон ийм агуулга байгаа учраас тогтолцоог нь оруулаад дотор нь тухайлсан шинэ арга хэрэгслийг нь оруулсан бас байдлаар үүнийг томъёолж явуулах нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа юм.

Бүхэлдээ манай хөдөлмөрийн зах зээлийн чухал зорилт шүү гэдгийг Та бүхэн мэдэж байгаа. Энэ үүднээс Та бүхэн энэ саналаа дэмжиж саналаа өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

**С.Энхнасан:** Гишүүнээс асууя. Энэ хоёр заалт хоёр тусдаа оруулж байгаа заалт юм уу? Тийм ээ. Нэг юм уу.

Тодруулж асуух асуулт байна уу?

2.2.3.2 багшлах хүний нөөцийн заалт дээр багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж гэдгийг дэмжих нэр томъёогоор. Дэмжихээр санал асуулт авъя. Санал хураалт.

Миний өөрийн тоног төхөөрөмж ажилласангүй.

Горимын санал. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё. Түчингүйд тооцох дээр санал хураалт явуулах хэрэгтэй юу. Тийм ээ. Хүчингүйд тооцдог санал хураалт явуулъя.

52 хувиар дэмжигдлээ.

Дахиад. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулах гэсэн заалтыг дэмжихээр санал хураалт явуулъя. /алх цохив/

63.2 хувиар дэмжигдлээ.

Б.Хэрлэн гишүүнээс ирсэн саналыг танилцуулъя.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай. 2.1.2.10 дугаар заалт.

Суралцах, дадлагажуулагчийн. Уучлаарай. Энэ нөгөө гараар биччихсэн болохоор заримыг нь уншиж чадахгүй байна шүү.

Цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоё гэж нэмэхээр санал ирүүлсэн байна.

Тайлбараа хийнэ үү. Б.Хэрлэн гишүүний микрофоныг өгнө үү.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ “Хосмог сургалтын тогтолцоо”-г боловсролын тогтолцоонд нэвтрүүлж оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ нь “ажиллангаа суралцах”, мөн “суралцангаа ажиллах” ийм боломжийг залуучуудад бий болгож, хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэнэ гэсэн ийм том зорилт орж ирж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт.

Тэгэхээр энэ зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөдөлмөр

эрхлэлтийн энэ хэсэгт тодорхой нэг санааг тусгахаар би зарчмын зөрүүтэй саналаа гаргаж ирээд байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол “суралцангаа дадлагажих”, мөн “дадлагажингаа суралцах” явцад тэр дадлага хийж байгаа оюутан, залуучуудын хөдөлмөрлөх эрх, суралцах эрхийг баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн харилцааг нь илүү боловсронгуй болгох ийм хууль эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй байна гэж үзсэн.

Энэ харилцааг үндсэндээ Хөдөлмөрийн тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хууль, Боловсролын ерөнхий хуулиар ерөнхийдөө зохицуулж байгаа хэдий боловч энэ зохицуулалтын хүрээнд яг хөдөлмөрлөх эрхийг нь хамгаалах, хангах тухай гол гол санаанууд дутагдаж байна гэж хараад байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр дадлагажигчаар ажиллаж байгаа оюутан, залуучууд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660 мянган төгрөгийн цалин хөлстэйгөөр ажиллахаар тусгагдсан боловч хэдэн цаг ажиллах юм, дадлага хийж байх хугацаанд нийт цагийн хэдэн хувь нь яг суралцахад, хэдэн хувь нь хөдөлмөр эрхлэхэд зориулагдах юм гэдэг нь тодорхой сайн заагдаагүй.

Магадгүй энэ нь бас нөгөө хөдөлмөрлөх эрхийг нь зөрчих тийм нөхцөлийг бүрдүүлж байж болзошгүй талтай байгаа.

Нөгөө талаараа 3 жил хүртэлх хугацаагаар дадлага хийнэ гэсэн.

Тэгэхээр 3 жил хүртэлх хугацаагаар дадлага хийх гэдэг маань тэр

хүний ажил хөдөлмөр эрхэлсэн нийт хугацаанд тооцогдох уу. Эргээд энэ нь одоо нөгөө тэтгэвэр бодогдоход тооцогдох уу гэдэг тухай асуудал байхгүй байгаа.

Гуравдугаарт, энэ бол одоо ерөөсөө аж ахуйн нэгж, компаниудыг зүгээр ажлаар хангахаас гадна сургалт дадлагажуулах, хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд өөрөө нэг ийм нийгмийн хариуцлага хүлээж, тодорхой үүрэг хүлээхэд хүргэж байгаа.

Тэгэхээр энэ дээр нь бас яг хууль эрх зүйн орчноор нь дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа учраас энэ “хосмог ажлын байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан суралцагч, дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох” тухай энэ санааг хөдөлмөр эрхлэлтийн тухай өгүүлсэн хэсэгт 2.1.2.10-д нэмж оруулах саналыг гаргаж байгаа юм.

Ингээд Та бүхэн энэхүү саналыг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна.

**С.Энхнасан:** Гишүүд хэрвээ асуух тодруулах юм байвал гараа өргөөд, хэрвээ гараа өргөхгүй бол шууд саналыг уншаад явчихъя.

2.1.2.10-д “суралцангаа дадлагажуулагчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэсэн заалтыг дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

57.9 хувиар дэмжигдлээ.

Нэлээн олон юм байгаа. Уучлаарай. Одоо ингээд нэлээн тэвчээртэй сууна уу. Манай Байнгын

хороо хамгийн идэвхтэй Байнгын хороо юм байна.

М.Ганхүлэг гишүүний саналыг танилцуулъя.

Төслийн 2.1.1.29 дэх заалтын “орчин нөхцөлийг бүрдүүлнэ” гэснийг “орчин нөхцөлийг бүрдүүлж, Оюутан цэрэг хөтөлбөрийг үргэлжлүүлнэ” гэж өөрчлөх.

М.Ганхүлэг гишүүний микрофоныг нээнэ үү. Тайлбараа өгнө үү.

**М.Ганхүлэг:** Тодорхой байгаа байх. Би түрүүн асуулт дээрээ асуучихсан.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулахдаа байгаа гэж байх шиг байсан.

Ер нь “Оюутан цэрэг” хөтөлбөртэй холбогдолтой асуудал ороогүй байна лээ.

Тэгээд оюутан залуучуудын хувьд хамгийн тулгамдсан гэдэг юм уу, хамгийн эрэлттэй ийм асуудал байдаг.

Сүүлийн 2 жил 1000, 1500 оюутныг хамруулж байгаа.

Тэгээд энэ хөтөлбөр цаашдаа үргэлжлэх юм бол эх оронч залуучууд, оюутнууд суралцангаа цэргийн алба хаах гээд олон давуу талууд байдаг учраас нэмээд оруулчихъя гэж байгаа юм. Тийм. Та бүхэн дэмжиж өгнө үү.

**Л.Энхнасан:** Эдийн засаг, хөгжлийн яамны 1 дүгээр микрофоныг нээнэ үү.

**Л.Балчинлуvsан:** М.Ганхүлэг гишүүний заалт маань 4.4.3.9 дээр байгаа юм. Батлан хамгаалах дээр явж байгаа.

“Оюутан цэрэг” гэдэг агуулгаар явж байгаа. 4.4.3.9 дээр байгаа. Тийм.

**Л.Энхнасан:** Санал хураалт явуулъя. Дэмжихээр санал хураалт явуулъя.

Гишүүн саналаа татлаа. Давхацсан байна.

Хоёрдугаарт санал. 2.1.1.31 дэх заалт шинээр нэмэх гэж байгаа.

“Залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай нөхцөл бүхий орон сууцын тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэсэн энэ заалт дээр М.Ганхүлэг гишүүн тайлбараа хэлнэ үү.

**М.Ганхүлэг:** Яах вэ, орон сууцын нэлээн томоохон давлагаа явна. Орчихсон байгаа гэдэг агуулгаар тайлбарлах байх.

Тэгэхдээ манай Байнгын хорооны гишүүд 2025 оныг залуучуудын хөгжлийн жил болгон зарлах гэж байгаа.

Тэгээд залуучуудын орон гээд. Тэгээд энэ хөтөлбөрийн хүрээнд яг залуучуудтай хамааралтай 4-хөн л заалт байгаа юм.

Тэгэхээр орон сууцын хөтөлбөр явахад нэлээн тодотгоод, ялангуяа урьдчилгаа бүрдүүлэх боломж нэлээн хомс, ажлын байрны туршлага багатай байгаа шинэ залуу гэр бүлийнхнийгээ гадагшаа ажиллах хүчин болоод явахаас нь сэргийлж дотооддоо орон сууцын таатай орчинд амьдрах нөхцөлийг нь хангах ийм тодорхой нэг заалтыг нэмээд тусгачихъя.



Орон сууцын хөтөлбөр гэдэг агуулгаараа хаягдаж гээгдэх, яг онцгойлж анхаарах ийм шаардлагууд үүсэх вий гэдэг агуулгаар нэлээн тодотгож оруулья гэсэн ийм саналтай байгаа юм. Тэгээд гишүүд маань дэмжиж өгнө үү.

**Л.Энхнасан:** Санал хураалт. Дэмжье гэсэн санал хураалтаар санал явуулья.

57.9 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.1.1.30 дахь заалт нэмж оруулах.

“Төрийн бүх шатын байгууллагад залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.”

М.Ганхүлэг гишүүн тайлбараа хэлнэ үү. Микрофоныг нээнэ үү.

**М.Ганхүлэг:** Өнгөрсөн Засгийн газрын хүрээнд Монгол Улс Залуучуудын хуулийг батлаад, түүний хүрээнд залуучуудын эрхлэх асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа гаргаж ирж ажилласан.

Энэ удаагийн Засгийн газрын бүрэлдэхүүнд “залуучуудын асуудал эрхэлсэн тусдаа яамтай” болж байгаа.

Энэ агуулгаараа төр захиргааны байгууллагууд ер нь залуучуудын асуудал дээр тусгайлсан хөтөлбөрүүдийг батлах, тодорхой төсөв, мөнгө суулгах. Үүнтэй холбогдолтой зөөлөн ур чадваруудыг олгох сургалт хөтөлбөр, олон нийтийн ажил төрөл дээр нь дэмжих энэ чиглэлийн ажлуудыг нэгдсэн байдлаар зохион байгуулалтад оруулья.

Тэгээд энэ “Залуучуудын хөгжлийн жил” болох ажлыг шат шатад нь зохион байгуулах чиглэл дээр

тусгайлаад тодотгоод нэг заалт нэмье гэсэн ийм саналтай байгаа юм.

**Л.Энхнасан:** Саналыг дэмжихээр санал хураалт явуулья. /алх цохив/

52.6 хувиар горимын санал юм уу дахиж хийхгүй бол нөгөө аягүй бага саналаар унах гээд байна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцоорой.

С.Эрдэнэбат болохгүй гэнэ. С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье. Саналын горимоо хэлнэ үү.

**С.Эрдэнэбат:** Яах вэ, би дэмжихвэл нөгөө талдаа татгалзсан болоод л шууд хийчхэж болох уу.

Заавал дахиж саналыг хүчингүйд болгоод ингэх хэрэг байна уу?

Техник ажиллаагүй учраас санал татгалзсанаар орчихлоо. Тэгэхээр дахин санал хурааж өгнө үү.

**Л.Энхнасан:** Тэгэхээр саяын саналыг хүчингүйд тооцохоор санал хураалт хийе. /алх цохив/

52.6 хувиар хүчингүйд тооцогдлоо.

Дахин санал хураалт явуулья. /алх цохив/

57.9 хувиар дэмжигдлээ.

О.Саранчулуун гишүүнээс ирсэн саналыг танилцуулья. 2.1.1.23.

Хөгжлийн төвийг байгуулна гэсэн хэсгийг хасаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт хүртээмжтэй, тэгш боллоцоогоор хангана гэсэн



нөхцөлийг бүрдүүлж ажиллана гэсэн заалт байна.

О.Саранчулуун гишүүний микрофоныг өгье.

**О.Саранчулуун:** Сайн байцгаана уу? Энэ санал л дээр би гурван түвшний үндэслэлийг хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, Монгол Улсад нэгдэн орсон 2009 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц байгаа.

Тэр конвенцоос өгсөн зөвлөмж болон дагалдах бичиг баримтууд дээр аль болохоор байгууллага барилгыг Засгийн газар тусгайлан барихгүй байхыг зөвлөсөн байгаа. Энэ баримт бичиг нь НҮБ-ын тэр сайт дээр болон Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжүүд дээр байгаа.

Үүнтэй холбоотойгоор ингэж тусад нь төв барих тусам ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлаж байна гэж үздэг юм.

Хоёрдугаарт нь, түрүүн халамжийн тухай асуудлыг ярьж байна лээ.

Тэгэхээр энэ халамж яагаад “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс”, “зорилтот бүлэгт” энэ их байна, яагаад ялгахгүй байгаа гэдгийн цаад шалтгаан нь юу вэ гэхээр жишээлбэл би бол энгийн сургуульд сурсан.

Тэгэхээр надад тэргэнцэр хэрэггүй, тусдаа асрамжийн үйлчилгээ хэрэггүй. Би энгийн хүний амьдралаар амьдраад л явж байгаа ийм л төрлийн бэрхшээлтэй хүн.

Тэгэхээр тэр төв тэр тусдаа байшин барина гэдэг чинь тэр хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн 20 орчим хувь, 30 орчим хувьд байгаа хүнд хэлбэрийн хүмүүст зориулсан ийм бүтэц байгаа юм.

Эсвэл иймэрхүү зүйлүүдийг тусгахдаа хүнд хэлбэрийн асаргаа шаардлагатай гэж ангилаж тусгах. Тэгж өгөхгүй болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс л бол тэр төв рүү явах ёстой, ийм тэргэнцэр авах ёстой гээд ангилчихаар энэ бол тусгаарлалтын нэг асуудал болоод байна гэсэн үг.

Тэгэхээр хэн нь тэр төвд очоод, хэн нь нийгмийн амьдралд оролцох юм бэ гэдгийг ялгаад өгчих юм бол би жишээлбэл татвар төлдөг юм шүү дээ. Ажил хийгээд цалингаасаа.

Тэгэхээр тэрийг ялгаж өгөх гол асуудлын цаана тэр **ICF** [International Classification of Functioning] гэдэг зүйл байгаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ заалтын үйлдлийн чадамжийг тогтоох гээд 2.1.1.22 дээр тогтоочихсон байгаа.

Гол нь яах вэ, би дээр Эрүүл мэндийн яаман дээр төсөв тусгах тухай нарийвчлан дараа нь асуух төлөвлөгөөтэй байгаа.

Тэгэхээр үүнийг нь ялгаж өгөх юм бол хэнд яг үйлчилгээ хэрэгтэй, хэн төв дээр очих хэрэгтэй гэдгийг ялгах ийм тогтолцоо бий болох юм.

Миний гурав дахь үндэслэл болохоор тогтолцооны хувьд яримаар байна. Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны гурван янзын төлөвлөгөөн дотор хөгжлийн бэрхшээл хүртээмжтэй холбоотой 29 заалт орсон байна.

29 заалт дотор ер нь “нийгэмд чиглэсэн хандлагыг бий болгоно”, “төвөөс аль болохоор гаргана” гэсэн утга

агуулга нь их цөөхөн байна. Гол төлөв асрамж, халамж, тусад нь зүйлүүдийг барина гэдэг агуулгатай утга их оржээ.

Тэгэхээр үүнийг ерөнхийдөө одоогоос хэдүүлээ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр тусгаж байгаа энэ жижиг тухайн цаг үед таарсан заалтуудаа нэг бүрчлэн засаж явъя гэдэг ийм үндэслэлээр яг энэ “төв барина” гэдгийг хасах хэрэгтэй. Харин үйлчилгээнийхээ стандарт руу илүү тэр төв барьдаг төсвөө гаргах хэрэгтэй гэж бодож байна.

Дээрээс нь төв барихад ямар асуудал байгаа вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан, ахмадад зориулсан аливаа үйлчилгээний чинь нийт зардлын чинь 70-аас дээш хувь нь бэлэн мөнгө байгаад байна.

Гэтэл Япон, Солонгос зэрэг орнуудад тэр хэмжээний үйлчилгээ нь төрийн үйлчилгээгээр авдаг байхгүй юу. Мөнгөн бус хэлбэрээр тэр хүн үйлчилгээгээ аваад байна.

Бид алсдаа тийшээ явахгүй л юм бол бид нөгөө эрүүл мэндийн хандлагаасаа хөдлөөд нийгэм рүү явсан гэж яаж хэлэх юм бэ.

Тэгэхээр олон улсын жишиг болон олон улсын Засгийн газарт өгч байгаа зөвлөмжүүд, дэлхийн чиг хандлагаа дагаж энэ олон төв барих, тусгаарлах энэ хандлагуудаа шийдвэр гаргах түвшинд аль аль талдаа ер нь хэдүүлээ болих хэрэгтэй байна.

Тэгээд үүнийг яаж хувиргах вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийдэг бол, сурдаг бол дэмжлэг авдаг байх ёстой. Зарчмын хувьд уг нь бол.

Гэтэл би хөгжлийн бэрхшээлтэй гээд л тэгээд л дотор нь ялгаагүй учраас

халамж аваад байхаар чинь халамжийн мөнгөний хэмжээ их байна, зорилтот бүлэг нь их байна гээд байгаа.

Гэтэл нийт халамжийн мөнгөний чинь одоо бараг 80 хувь нь нийт тэр хүн амынхаа бараг 20 хувьд нь зарцуулагдаж байна шүү дээ. Тийм ээ.

Өнөөдөр 96 мянган хүн байна. Хөдөлмөр эрхлэх чадвартай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа.

16-хан хувь нь ажил эрхэлж байгаа.

25.1 гэдэг тэр зарчмаар хүн ажилд орох гээд очихоор хөдөлмөрийн ур чадвар нь хүрэлцэхгүй байгаа учраас тэр хүмүүс сурах хэрэгцээтэй байна, нийгмийн амьдралд оролцох хэрэгтэй.

Тэгэхээр хэдүүлээ энэ “төв барина”, “тусгаарлана” гэдэг өгүүлбэр болгоныхоо ард хариуцлагыг бүгдээрээ үүрэх хэрэгтэй. Монгол Улс энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн бодлогоороо хаашаа явж байгаа юм бэ гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

Тэгэнгүүтээ эсрэгээрээ бид юу хийх ёстой вэ гэхээр “бүх үйлчилгээг хүртээмжтэй болгоё” гэдэг үгийг оруулах хэрэгтэй байна. “Нийгмийн чиг хандлага” гэдэг үгийг оруулмаар байна.

Олон улсын конвенцийн дүрэм, журмынхаа үг, хэллэгийг ийшээ тусгаж өгч байж мөрийн хөтөлбөр чинь урт хугацааныхаа зорилготой нийцнэ.

Тэгэхээр миний гаргаж байгаа энэ “төв барина” гэдгийг хасаж байгаа нь өнөөдрийн хувьд зарим төв барих санал оруулсан хүний хувьд харамсалтай боловч бид алсдаа улам тусгаарлахаас сэргийлж байгаа юм. Тогтолцооны

өөрчлөлт уриалж байгаа ийм санал юм шүү.

Тийм учраас Та бүхнийг дэмжихийг хүсэж байна.

**Л.Эхнасан:** С.Зулпхар гишүүний микрофоныг нээе.

**С.Зулпхар:** О.Саранчулуун гишүүний саналыг ерөнхий саналынх нь хувьд би ойлгож байна.

Мэдээж хэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас бидэнд өгсөн гол зөвлөмж бол ер нь институцлэхгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн харилцаанд оролцох, бусад хүртээмж болон бүхий л зүйлийг нь зохицуулаарай гэдэг зөвлөмж өгөгдсөн нь үнэн.

Гэхдээ үүнийг бид нөгөө Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хуулиараа яг энд заачихсан 2.1.1.21-д байгаа Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулиараа үүнийг хийнэ гээд оруулчихсан байгаа байхгүй юу. Энэ бол орчихсон байгаа гэсэн үг. Хийх ч ёстой. Зөвлөмж бол.

Нөгөөтээгүүр бидэнд яах вэ өнгөрсөн хугацаанд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүд өөрөө сайн туршлага гэдэг талаас нь зөвлөмж өгсөн тэр улсууд бидэнд хэлсэн. Яг конвенцын хэрэгжилтийг хамгаалах үед яг ийм зөвлөмж бидэнд өгөгдсөн юм.

Тэгэхээр энэ төвүүд хэрэгтэй юу, хэрэгтэй байгаа. Одоо эхнийхийг нь бид 5-ыг нь байгуулчихсан байж байгаа.

Тэгэхээр үүнийг бусад аймгууд байгуулж өгөөчч ээ гэдэг хүсэлт сонгогчдоос ирсэн байхгүй юу. Сонгогчдоос тэр дотроо хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс өөрсдөөс нь ирсэн.

Гэхдээ энэ бол тусгайлсан хэлбэртэй, эсвэл ялгаж байгаа хэлбэртэй биш. Саяын боломжийг нь илүү олгох бас нэг арга хэрэгсэл л гэж үзэж байгаа юм. Арга хэрэгсэл. Байж болох зохион байгуулалт гэж үзэж байгаа юм.

Энэ үүднээс нь энэ төвүүдээ цааш нь байгуулна гээд Засгийн газар их том зорилт тавьчихсан. Манай төслийг хэрэгжүүлж байгаа. Бараг Азид манай төсөл чинь боломжийн сайн арга хэрэгслүүдийн нэг болж байна. Үр дүн өгөх байх гэсэн ийм хандлагатай байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг шууд аваад хаячхаж бас болмооргүй байна.

Харин О.Саранчулуун гишүүний хэлсэн тэр тодруулж байгаа зүйл байна шүү дээ. Тодруулж байгаа нийгмийн бүхий л харилцаанд ороход нь тэр боломжийг нь олго гэдгээр нь тодруулж оруулаад. Тэгээд саяын төвийг нь үлдээвэл яасан юм бэ гэсэн миний санал байна. Энэ чухал шүү гэдгийг хэлье.

Та бүхэн маань зөв юм бодож байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Гэхдээ аль аль нь зөв. Нөгөөтээгүүр бас нэг юм байгаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагатай бид уулзалт дээр хэлсэн.

Аливаа улс өөрийнхөө нийгэм, эдийн засаг, соёлын болон бусад дэд бүтцийн онцлогт тохирсон байдлаар ялгаатай өвөрмөц бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлж болно шүү гэдэг зөвлөмж өгөгдсөн.

Бид энэ талаас нь манайд байж болох арга хэрэгсэл гэж ойлгосон учраас үүнийг оруулсан гэж ойлгож байгаа.

**Л.Энхнасан:** О.Саранчулуун гишүүний микрофоноо өгнө үү.

**О.Саранчулуун:** Тийм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар Монгол Улс маш олон их сайн ажлуудыг хийж байгаа. Ахиц дэвшилтэй байна.

Тэр ч байтугай 2 хүн парламентад өнөөдөр саналаа өгөөд сууж байгаа нь үнэхээр гайхалтай.

Хамгийн гол нь бодлого боловсруулах түвшин, шийдвэр гаргах түвшинд шийдвэр гаргаж байгаа энэ үйлдэл болгоныхоо ард бид 10 жилийн дараа, 20 жилийн дараа хаашаа явах вэ гэдгээ үргэлж харах хэрэгтэй.

Тэгэхээр зөвлөмжүүд дотор бараг 60 зөвлөмж, зүйл, заалт байгаа.

Ер нь аль болохоор хүнээ тусгаарлах, тэр хүмүүсийг нийгмийн харилцаанд ороход нь дэмжээч гэдэг нь давамгайлж байгаа. Улс орны онцлогт тохируулсан байна гэдэг нь нэг, хоёрхон л заалт дээр байгаа байхгүй юу.

Тэгэхээр би төв барих гээд төсөв гаргаад өгчхөж байхад чинь ямар сонин юм бэ гэж хүмүүс гомдоллож магадгүй. Жишээлбэл, одоо тусдаа манай Хан-Уул дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв” гээд барихаар би тийшээ очих юм уу, очихгүй юм уу. Миний хувьд тэр төвөөс би юу авах вэ. Жишээлэх юм бол. Тийм ээ.

Түүнээс илүү би зүгээр энгийн “community center”-тэй болмоор байна. “Гэр бүлийн төв” рүү очмоор байна шүү дээ. Би хүүхдээ дагуулаад ахмад настууд дээр очмоор байна. Тийм ээ.

Түүнээс надад тусад нь ингэж төв барих нь бие даах чадвартай байгаа, амьдралаа аваад явж байгаа мянга мянган хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дахиад тусгаарлаад байгаа байхгүй юу. Энэ чинь хандлагын өөрчлөлт байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ дахиад өөрөөр хараач ээ гэдгийг би бүр Та бүхээсээ хүсэж байна.

Тэгээд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэг чинь дандаа асрамж хэрэгтэй байдаг хүн биш. “Ахмад настан” гэдэг чинь зөвхөн асрамж хэрэгтэй байдаг хүн биш. Тэр нийт хүн амын чинь 30 хүртэлх хувь нь л тусгай үйлчилгээ, хүнд хэлбэрийн байгаад байгаа шүү дээ.

Бид яагаад бие даах чадвартай, нийгмийн амьдралд оролцож байгаа хүмүүсээ дэмжихэд төсвөө зориулахын оронд тусад нь ингээд л нэг байшин, эмнэлгийн, эрүүл мэндийн хандлагаар явах ёстой юм бэ.

Тэгэхээр үүнийг өөрчилж чадах энэ 29 заалт дотроосоо өнөөдөр л бид энэ дээр үүнийг өөрчилж ярилцахгүй юм бол ер нь хэзээ ярилцах юм бэ гэдгийг л би хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр Та бүхний хувьд төвийг хасаж өгөх дээр дэмжлэг үзүүлнэ үү гэж дахиж хүсье.

**Л.Энхнасан:** Энэ дээр яамнаас нэг тодруулаад хэлээд өгчихвөл зүгээр байна.

Тэгэхдээ яамны хүн байна уу? Ж.Баясгалан гишүүн түрүүлээд гараа өргөчихсөн байсан. Ж.Баясгалан гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ж.Баясгалан:** Яг энэ дээр ингээд санал бодлоо солилцох бол маш зөв байна.

Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол үнэхээр дотроо хоёр янз л даа.

Хөнгөн хэлбэрийн болоод хүнд хэлбэрийн. Өнөөдөр энд яг хөнгөн хэлбэрийг төлөөлөөд манай О.Саранчулуун. Хүнд хэлбэрийг төлөөлөөд би сууж байна.

Тэгэхээр Монгол Улс өөрөө газар нутгийн хувьд, эдийн засгийн хувьд, тэгээд дээр нь зам харилцааны хувьд өвөрмөц, Цаг агаарын хувьд.

Тэгэхээр сумд байгаа иргэн, аймагт байгаа иргэн, хөгжлийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй иргэн тэр болгон хот руу ирээд үйлчилгээнд хамрагдаж чадахгүй.

Өрхийн тэргүүн эмэгтэй аймаг дээрээсээ хот руу ирээд хөгжлийн төвд орж чадахгүй. Би бол энэ дээр яг энэ хүнд хэлбэрийн хүмүүсээ төлөөлж ярьж байна л даа.

Хөнгөн хэлбэрийнхэн бид нарт юу байгаа юм бэ гэж. Мэдээж О.Саранчулуун гишүүн та бол шууд тэр гэр бүлийн төвд өөрөө очих боломжтой юм чинь очиж болно. Боломжгүй бас мянга мянган хүн байгаа гэдгийг ойлгоорой.

Энэ дунд чинь боломжгүй иргэд ерөөсөө халамжийн ч боломжгүй. Өнөөдөр тэгэхэд бид “халамжийн тухай” ярихгүй байгаа. Бид “хүртээмжийн тухай” ярьж байгаа.

Үнэхээр хүртээмжтэй болгоод өгчих л дөө.

- Бүх зам талбай нь,
- бүх орон сууц нь,
- бүх төрийн байгууллага нь,
- бүх үйлчилгээнд хүртээмжтэй болчихсоны дараа үүнийг ярихад болж байна.

Гэтэл энэ бол арай болоогүй байна. Өнөөдрийн түвшинд.

Тэгэхээр үйлчилгээг ойртуулж өгөх нь өөрөө хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн том асуудал. Үүнийг бүгдээрээ олж харсан. Бүх намууд олж харсан. Энд баярлаж байгаа.

Дээр нь нэмэгдээд тэр төвд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлнэ ч гэсэн ойлголт биш шүү дээ.

- Харвалтын дараах нөхөн сэргээлтийг хийж болно;
- сэтгэл зүйч тэнд байгаа. Хүүхдүүд сэтгэл зүйч дээрээ очиж болно.

Ингэхээр энэ төвүүдийг харин би бүр олон байгаасай гэж хүсэж байна. Олон байгаасай гэж бодож байна.

Тэгэхээр үүнийг хасах нь буруу шүү. Яагаад гэвэл 1000 километрийн цаанаас 1500 километрийн цаанаас Улаанбаатар хотод ирээд энэ үйлчилгээг авах боломж маш муу байгаа шүү.

Одоо яг бүс бүсүүд дээр төвүүд байгуулагдсан. Гэхдээ бусад аймгуудаас нь хүртэл очиход хэцүү байгаа шүү дээ. Байгуулсан аймаг л давуу эрхтэй, давуу талтай байгаа.

Би 5 төвөөр тавуулангаар нь орж үзсэн. Тэгээд тэнд хүмүүстэй уулзахад ерөөсөө хүмүүсийн асуудал ойрхон болохоор орж ирж байна гэдэг л юм байгаа шүү. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тэгэхээр хангалттай сая ярилаа.

О.Саранчулуун гишүүний 2.1.1.23 дугаар заалтад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна гэснийг хасах” гэснийг дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

84.2 хувиар дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ, дэгээ бариад дараачийн саналдаа орёё.

О.Саранчулуун гишүүнээс зарчмын зөрүүтэй дараагийн санал ирсэн байгаа.

4.1.3.4-д нэмэхээр. Иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах.

Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг жил бүр үйлчилгээ хүргэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх гэсэн саналыг оруулж байна.

О.Саранчулуун гишүүн тайлбараа хэлнэ үү.

**О.Саранчулуун:** Баярлалаа. 4.1.3 дээр иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа хэсэгт 3 санал орсон байгаа.

Энэ 3 дотор гурвуулан дээр нь иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, оролцоо,

санаачилгыг дэмжинэ гэсэн утга агуулгатай заалт байгаа.

Яг одоо [legal-info.mn](http://legal-info.mn) дээр байгаа хүчинтэй хууль эрх зүйн актууд дээр иргэний нийгэм гэдгээсээ илүү төрийн бус байгууллага гэдэг нэрээр байгаа.

Төрийн бус байгууллага гэдэг нэрээр чанарын судалгаа хайгаад үзвэл 77 илэрц бараг байгаа. 77 илэрцээс 4-хөн хувь нь иргэний нийгэм, тухайн чиглэлээр төрийн тэр үйл ажиллагаанд дээр хянах, үйл ажиллагаанд нь оролцох гэдгээс байгаад. Бараг 96 хувь нь тухайн чиглэлээр тухайн хуулийг олон нийтэд түгээх, сурталчлах, таниулах гэдэг утга агуулгатай байдаг.

Үүнийг Та бүхэн интернэтээс хамгийн сүүлд 2019, 2020 онд хийсэн 700-аад төрийн бус байгууллагаас хийсэн судалгааны тайлангаас харж болно.

Тэгэхээр бид ер нь иргэний нийгмийн оролцоо, төрийн бус байгууллагуудын оролцоог төрийн үйл ажиллагаанд хянуулах. Тийм ээ. Зарим юман дээр саналаа хэлэх энэ үүргийг нь 1997 оноос хойших хуулиа нэг нэгээр нь өөрчилсөөр байгаад ингээд хүчгүй болгочихсон юм.

Тийм учраас төрийн үйл ажиллагаанд тодорхой чиглэлээр зарим нэг саналуудыг өгдөг, чанга дуугардаг энэ чиглэл нь жеңдэрийн чиглэл эмэгтэйчүүдийн байгууллагаас өөрөөр бага болсон. Үүнийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор нэгэнт л Засгийн газрын урт хугацааны төлөвлөгөө нь төр, иргэний түншлэл тийм ээ, “хүний эрхийг дээдэлсэн нийгэм” гэдэг энэ агуулга дээр явж байгаа бол Монгол Улсын Статистикийн



Үндэсний Хороон дээр байгаа одоо 20 мянга, Сангийн яам руу очихоор 10 мянга болчихдог. Улсын бүртгэлийн ерөнхий газар очихоороо бараг 3 мянга гаруй тайлан өгсөн бүртгэлтэй байдаг. Зөв төрийн бус байгууллагуудаа ялгаж ангилмаар байна.

Тэгж байж одоо энэ шинэ мөрийн хөтөлбөрт орж байгаа хамтын түншлүүдээ баталгаатай болгоно.

Альныг нь нөгөө жинхэнэ ЖДҮ гэдэг шиг альныг нь төрийн бус байгууллага гэж үзэх юм, хэдэн жил явсныг нь жинхэнэ төрийн бус байгууллага, хэднийг нь хулхи гэж явах юм. Тийм ээ.

Төрийн бус байгууллага үүсгэхэд хэчнээн амархан билээ. 14 хоногийн дотор бараг бүх хүмүүсийн гарын үсэг зураад л ингээд л явчихдаг. Тийм ээ.

Гэтэл жинхэнэ төрийн бус байгууллагууд яадаг вэ гэхээр өнөөдөр 6 янзын тайлан өгч байна.

Нийгмийн даатгал, аж ахуйн нэгжийн орлогын тайлан, спонсорууддаа, олон нийтэд гээд тайлангуудаа өгдөг.

Эргээд Улсын бүртгэлийн ерөнхий газарт тайлан өгдөг.

Тэр тайлангийн ач холбогдол нь яадаг гээч. Улсаас тендерт оролцох Засгийн газрын үйл ажиллагаатай гэрээ хийхийн тулд тэр тайлангаа заавал улсын бүртгэлд өгөх ёстой.

Өөр тэр тайлангийн мөрөөр төрд хийж байгаа арга хэмжээ алга байна. Яагаад гэхээр манай 1997 оноос хойш байгаа Төрийн бус байгууллагын тухай хууль маань өнөөгийн цаг үеэ, хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа.

Тэгэхээр үнэхээр төрийн бус байгууллагаа цэгцэлье, энэ оролцоог нь төрийн үйл ажиллагаа руу оруулъя гэж үнэхээр бодож л байгаа л юм бол бид төрийн бус байгууллагаа олон улсын зөв ангиллаар нь тооцож сурмаар байна.

Өнөөдөр Статистикийн хороон дээр “**өрхийн бүртгэлийн систем**” болох **COPNI**<sup>1</sup> /Classification of the purposes of non-profit institutions/ гэдэг ангиллаар төрийн бус байгууллага тоологдож байгаа шүү дээ.

Тэр дотор дандаа “**бусад**” гэдэг ангилал дээр, эсвэл “**боловсрол**” гэдэг ангиллаар явж байгаа.

Түрүүнээс хойш ярьж байгаа одоо энэ “гэр бүлийн үйлчилгээ”, түрүүн “сэтгэл зүйн үйлчилгээ” гээд хэлэхэд энэ дээр чинь төрийн бус байгууллагууд гэр бүлийн чиглэлээр сэтгэл зүйн үйлчилгээ явуулдаг, хүүхэд залуучууд гээд зөндөө явж байгаа.

Гэтэл энэ мөрийн хөтөлбөрт “**төрийн бус байгууллагын оролцоо**” гэдэг их цөөхөн тусгагдсан байна лээ.

Тэгэхээр миний хувьд жишээлбэл төрийн бус байгууллагын чиглэлээрээ ажиллаж 10 жил ингээд гудамжинд тоос шороотой хутгалдаж, тайлан өгч явж байсан хүний хувьд үүнийг заавал бид анхаарах ёстой гэж үзээд энэ хоёр заалтыг санал болгож байгаа.

Эхний заалт бол иргэний нийгмийн байгууллагынхаа бодит оролцоог баталгаажуулахын тулд бүгдээрээ одоо энэ шинэ хуулийн төсөл дээрээ эргэж ажиллах, 3 жилийн өмнө

<sup>1</sup> Ашгийн бус байгууллагуудын зорилгын ангилал



татагдсан тэр хуулийн төслөө сайжруулах ёстой байгаа.

Яаж оролцох юм, ямар төрийн бус байгууллагыг жинхэнэ төрийн бус байгууллага гэж тооцох юм гэдэг дээрээ бүгдээрээ ажиллах хэрэгтэй байна.

Дараагийн санал нь, төрийн бус байгууллагын ил тод байдлын түвшнийг гаргаад өгчих юм бол энэ чинь ингээд хэн нь зөв юм хийж байна, хийхгүй байна гэдэг нь явж байгаа байхгүй юу.

Америк, Австрали, Канад зэрэг ардчилсан улс орнуудад төрийн бус байгууллага чинь өөрөө нөгөө зочид буудал шиг ингээд 5 од шиг системээр үнэлэгддэг шүү дээ. Ил тод байдал, хариуцлагатай байдлын үнэлгээ гээд.

Тэгээд донорууд нь ч гэсэн өөрсдөө үнэлэгддэг. Ямар байгууллага төрийн бус байгууллагад би хандив өгсөн гэдгээр ингээд үнэлэгддэг систем байдаг байхгүй юу. Манайд тайлангийн мөрөөр авдаг цэгцтэй ийм юм алга байгаад байна.

Тэгэхээр үүнийгээ цэгцлэхгүйгээр бид мөрийн хөтөлбөрт тусгагдсан “иргэн, төрийн түншлэл” энэ тэр гэдэг өгүүлбэрүүд бол утга агуулгын хувьд амьдрал дээр хэр хэрэгжихүй вэ. Аягүй ийм хол сонсогдож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ заалтыг хэрвээ оруулчих юм бол үүнтэй холбоотой холбогдох төрийн байгууллагууд тодорхой хэмжээний арга хэмжээ төлөвлөөд, бас төсөв гаргаад төсөв гаргаад ороод ирэх байх гэдэг ийм бодлоор санал оруулж байна.

Тэгээд манай гишүүд дотор шинэ хүмүүс зөндөө байгаа. Иргэний нийгмээс орж ирсэн хүмүүс зөндөө байгаа.

Тэгэхээр дээр Та бүхэн ч гэсэн өөрсдийнхөө бодол саналаа, байр сууриа илэрхийлнэ байх гэж бодож байна. Дэмжиж өгнө үү л гэж хүсэх гэж байна.

**Л.Энхнасан:** 2 заалт байгаа. Тэгэхдээ эхнийхийг нь уншъя.

4.1.3.4.Иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг батлах, төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээ хүртээгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлэх.

Энэ саналыг дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

Гишүүдийн ирцийг бүрдүүлнэ үү. Энд сууж байгаа гишүүд бүгдээрээ л дэмжээд байх шиг байна. Тийм.

Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгнө үү.

**Д.Үүрийнтуяа:** Сая санал хураалт дээр дэмжиж саналаа өгсөн боловч миний төхөөрөмж ажилласангүй.

Тийм учраас энэ саналыг хүчингүй болгож дахин санал хурааж өгнө үү.

**Л.Энхнасан:** Горимын саналын дагуу саяын саналыг хүчингүйд тооцохоор санал хураалт хийе. /алх цохив/

Дэмжигдлээ. Саяын санал хураалт хүчингүй боллоо.

Дахиад саяын заалтыг дэмжихээр санал хураалт явуулъя. /алх цохив/

57.9 хувиар дэмжигдлээ.

Д.Үүрийнтуяа дэмжсэн байна. Үүнийг протоколд тусгана уу.

О.Саранчулуун гишүүнээс ирсэн гурав дахь санал.

4.1.3.5-д иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг үндэсний тогтолцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, тэдний татвар, нийгмийн даатгалын чиглэлээр тодорхой хөнгөлөлт үзүүлэх механизмыг бүрдүүлнэ үү гэсэн ийм заалт байна.

Түрүүн өөрөө тайлбараа хийчихсэн үү. Нэмж хийх юм уу. Нэмэлт 1 минутын тайлбар.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Энэ хоёр дахь заалтын утга юу гэхээр сайн дурын ажлын тогтолцоо.

Яагаад гэвэл одоогийн байгаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудын хүний нөөц болон бүтцийг харахаар дунджаар дээд тал нь 3 хүнтэй байдаг.

Ихэнх үйл ажиллагаанд буюу нийт байгууллагуудынх нь 85-аас дээш хувь нь сайн дурынхны хүчин дээр иргэний нийгмийн үйл ажиллагаа оршдог.

Бүх төрийн бус байгууллагуудыг Та хэд бодоод үзэх юм бол ихэнх нь сайн дурын үйл ажиллагаа, сайн дурынхны оролцоо байдаг.

Энэ асуудлыг залуучуудыг дэмжих хөтөлбөр болон үндэсний сайн дурын журам зэрэг дээр энэ төрийн бус байгууллагад ажиллаж байгаа сайн

дурынхныг үнэлэх, тодорхой цаг ажиллаад тэрийг нь ажилд авахдаа тооцох зэрэг тогтолцоонууд олон улсад байдаг.

Тэгэхээр энэ заалтыг хэрвээ бид тооцооллын гаргаж өгөөд манайд ийм механизм байх юм бол залуучууд гэлтгүй ер нь энэ сайн дурын үйл ажиллагаа нь ихэнх дээр босдог иргэний нийгмийн олон үйл ажиллагаан дээр тэр татвар болон нийгмийн даатгалын хувьд нэлээн том дэмжлэг болох учиртай байгаа юм.

**Л.Энхнасан:** Энэ дээр С.Зулпхар гишүүний микрофоныг нээнэ үү.

**С.Зулпхар:** О.Саранчулуун гишүүн ээ, би зүгээр тодруулах гээд л байна л даа.

Сая та тэр төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад ажиллаж байгаа хүнийг нийгмийн даатгалаас чөлөөлөх хэрэгтэй, татвараас чөлөөлөх хэрэгтэй гэсэн ийм агуулгаар томъёолж оруулж ирсэн санал гаргаж байна уу? Тодруулж байгаа шүү.

**Л.Энхнасан:** О.Саранчулуун гишүүний микрофоныг нээнэ үү.

**О.Саранчулуун:** Нийгмийн даатгалаар ажилласан жилүүдийг тооцдог шүү дээ. Тийм ээ. Нөгөө хөдөлмөрийн тэдэн жил ажилласан гэдэг дээр.

Тэгэхээр сайн дурын үйл ажиллагаагаар тодорхой хэмжээнд ажилласан. Сайн дурынх нь хуваагдаад байгаа юм. Дотроо.

Одоо мэргэжлийн сайн дурын ажил хийсэн, эсвэл бага насны хүүхдүүдийн зүгээр дэмжих чиглэлтэй сайн дурын ажил хийсэн гээд хуваагдаад байгаа.

Тэгэхээр сайн дурын ажлаар ажилласан тэр хагас цаг болон төрийн бус байгууллагад ажиллаж байгаа энэ олон мянган ажилтнуудын энэ хөдөлмөрийг ажилласан жилд тооцох байдаг юм уу, хөдөлмөрийн харилцаагаар нь зохицуулах байдаг юм уу, нийгмийн даатгалын талаас нь дэмжих ийм тогтолцоог л яриад байгаа гэсэн үг.

**Л.Энхнасан:** Энэ дээр ажлын хэсгээс хариулах хүн байна уу? Ер нь татвартай холбоотой болохоор.

Томьёоллын дахиад хэлье.

“Иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тогтолцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, тэдний татвар, нийгмийн даатгалын чиглэлээр тодорхой хөнгөлөлт үзүүлэх механизмыг бүрдүүлнэ” гэсэн заалт байна.

С.Зулпхар гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Зулпхар:** О.Саранчулуун гишүүн маань мэдээж хэрэг иргэний нийгмийн байгууллагын нийгмийн оролцоог хангах чиглэлээр их чухал санал байна л даа. Эхний хэсгийн томьёолол нь.

Гэхдээ энэ дотор саяын хэлээд байсан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлж чөлөөлөх чиглэлээр дэмжлэг үзүүлэх гэдэг ийм заалт яваад байна.

Хэрвээ тэр хүн төрийн бус байгууллага дээр, иргэний нийгмийн байгууллагад байвал байгууллагаар

дамжуулаад албан журмын нийгмийн даатгалд хамрагдаж нэг болно.

Сайн дурынх байх юм бол өөрөө сайн дураар нийгмийн даатгалд хамрагдаж болох учраас энэ дээр бид энэ заалтыг шууд оруулах нь өөрөө их тийм өрөөсгөл гэж байгаа юм. Шаардлагагүй гэж байгаа юм. Нийгмийн даатгал.

Татвар дээр ч гэсэн мөн адил. Яг саяын нөхцөл байдал үүсэх учраас таны саналын эхний хэсгийн хэсгийн агуулга яваад, сүүлийн тэр татвар, нийгмийн даатгалаас хөнгөлж чөлөөлөх гэдэг бол одоо байгаа хуулиудынхаа хүрээнд зохицуулагдаад явчих учраас тэрийг хасчихвал яасан юм бэ, хасах нь зөв байх гэсэн саналтай байна.

**Л.Энхнасан:** С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Яг энэ асуудал дээр төрийн бус байгууллагуудыг дэмжинэ гээд ер нь бүх л намын мөрийн хөтөлбөр дээр байгаа байх.

Тийм учраас төрийн бус байгууллагуудын чиглэлээр ажил хийж байгаа маш олон хүн байдаг. Зарим нь нөгөө төрийн дэмжлэгүүд дээр орж ирэнгүүт нь төрийн бусуудыг ингээд дандаа хаагаад явчихдаг байхгүй юу.

Тэгэхээр магадгүй төрийн зарим чиг үүрэг хууль сурталчлах, дэмжих, урьдчилан сэргийлэх гээд маш их мөнгөөр хийж болохуйц ийм ажлуудыг хийдэг энэ төрийн бус байгууллагыг нь тодорхой хэмжээгээр үнэлээд, түүнийг нь эдийн засаг болон зарим төрийн салбарт ажилласнаар нь тооцох ч гэдэг юм уу, өргөн утгаар нь оруулчихвал болох юм биш үү.

Нөгөө талдаа яах вэ шууд татварын тэрнээс нь хөнгөлнө, шууд нийгмийн даатгалыг чөлөөлнө гэх юм бол энэ арай өөр асуудал.

Тийм учраас нийгэм, эдийн засгийн чиглэлээр дэмжих хөшүүргийг бий болгоно гэдгийг нь. Бусад хуулиудтай нийцэх байдлаар эрх зүйн зохицуулалтуудыг нь хийгээд явчихвал харин яг энэ зүйлийг байх ёстой заалтуудын нэг гэж харж байгаа. Тийм.

**Л.Энхнасан:** О.Саранчулуун гишүүний микрофоныг өгье.

**О.Саранчулуун:** Баярлалаа.

Тэгвэл ингэж болж байна уу. Та хэд сонсвол.

Иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистик мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.

Эхлээд тоолж судалъя. Тийм ээ. Үнэхээр эдийн засагт сайн дурынхан иргэний нийгэмд ямар хувь нэмэр оруулж байгаа тогтолцоотой болчихвол дараа дараагийн жилүүдэд бид тэр асуудлыг ярьж болох байх гэсэн ийм саналтай байна.

Тийм. Тэр сүүлийн өгүүлбэрийг хасаад.

**Л.Энхнасан:** О.Саранчулуун гишүүний саналын дагуу өөрчлөөд “иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тогтолцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх”

гэдгээр дэмжихээр санал хураалт явуулъя. /алх цохив/

57.9 хувиар дэмжигдлээ.

**С.Эрдэнэбат** гишүүний хоёр санал байгаа.

2.1.2.6-д “монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ гэсэн. “Жил бүр” гэсэн нэмэлт оруулахаар саналтай байна.

Тайлбараа гишүүн хэлнэ үү.

**С.Эрдэнэбат:** Маш ойлгомжтой санал.

Ер нь төсөв хэлэлцэх болгонд цалин хөлсний асуудлыг жил бүр тэр бүтээмж, өсөлтийг нь ярьдаг байя л гэж байгаа юм. “Жил бүр”.

“Ерөнхийд нь нэмэгдүүлнэ” гэдэг биш. Төсөв хэлэлцэхээс өмнө болон энэ үедээ зайлшгүй ярих зүйлийн нэг байгаа учраас ганцхан санал л нэмье гэсэн.

**Л.Энхнасан:** 2.1.2.6 гээд. “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлнэ” гээд ер нь заалт байгаа юм. Тийм.

Түүн дээр нь “жил бүр” гэж нэмэх гэж байгаа юм байна. Тийм ээ.

**С.Эрдэнэбат:** Тийм. Нийгмийн даатгалын хуулиар “гэтгэврийг жил болгон” гээд бүр хуульчлаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр инфляцтай уялдуулаад жил бүр ер нь үүнийгээ нэмэгдүүлэх ямар нэгэн арга хэмжээг авч байя гэдэг байдлаар орж өгөхгүй бол сүүлдээ дараа нь энэ цалин хөлсний асуудлыг 4 жилдээ нэг л удаа ярья ч гэдэг юм уу ингээд

замхраад явчих гээд. Энэ нь маргаан үүсгээд асуудал болох гээд байдаг юм.

Тийм учраас ер нь жил бол ярих нь тодорхой. Гэхдээ хөтөлбөр дээрээ тодорхой тавьж өгье л гэж байгаа юм.

**Л.Энхнасан:** С.Зулпхар гишүүний микрофоныг өгье.

**С.Зулпхар:** Цалин хөлстэй холбоотой асуудал дээр угаасаа гурван талт бид зөвшилцлийн хүрээнд хөдөлмөрийн хөлсийг яаж тогтоов гэдгээ яриад шийдчихдэг.

Төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотойгоор жил болгон инфляцтай уялдуулсан байдлаар нэмэгдүүлнэ гээд Засгийн газрын тогтоол гарчихсан. Энэ мөрийн хөтөлбөрт ч гэсэн ингээд орчихсон байгаа юм.

Бүтээмж бол бас шууд хэн нэгнээс шалтгаалах зүйл биш л дээ. Нэг жилийн дотор.

Бүтээмж нь цаанаа технологитой холбоотой зүйл байж байгаа. Хүний нөөцийн ур чадвартай холбоотой зүйлд байж байгаа.

Тэгэхээр шууд “жил болгон бүтээмжийг нэмэгдүүлнэ” гээд заачхаар энэ зорилтыг яаж хэмжих вэ, дараа нь бид үүнийг яаж тайлагнах вэ гээд асуудал гарах байх.

“Цалин” бол болж байна. “Бүтээмж”-ийг ялгаатай авч үзэх ёстой шүү гэдгийг энд хөдөлмөрийн эдийн засгаар, эдийн засгаар мэргэшсэн улсууд их сайн мэдэж байгаа даа.

Үүнийг зөв оруулахгүй бол дараа нь ахиад жилийн дараа тайлагнаад

эхлэхээр зэрэг үр дүн гарахгүй л байдал үүсчихдэг юм шүү л гэж байгаа юм.

Гэхдээ 4 жилийн дараа бол мэдээж хэрэг “бүтээмжээ нэмэгдүүлнэ” гэдэг зорилт тавих нь бол зөв л гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Энэ дээр ажлын хэсгээс хариулах хүн байна уу? Эдийн засаг, хөгжлийн яамнаас. Микрофон 1-ийг өгнө үү. 1 дүгээр микрофоныг өгнө үү.

**Л.Балчинлуvsан:** Энэ заалт маань хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх тухай асуудал энд яригдаж байгаа.

Тэгэхээр сая С.Зулпхар гишүүний өгсөн тайлбар ер нь зөв.

Энэ хоёрыг ялгаж салгах болж таарна. Таны яг хэлсэн томъёоллын дагуу жил бүр гэж нэмэгдүүлбэл хоёуланг нь тусад нь бичиж байж агуулга болно.

Яг агуулгын дагуу бол “бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлнэ”, бүтээмжтэй нь уялдуулж гэдэг санаа явж байгаа шүү.

**Л.Энхнасан:** Тэгэхээр саналаа хураая.

2.1.2.6 дээр “монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ” гэсэн. Дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

73.7 хувиар дэмжин дэмжигдсэнгүй.

Гишүүний хоёр дахь санал нь манай Байнгын хорооны хүрээний асуудал биш учраас.

Тэгэхдээ өөрөө саналаа өгсөн учраас уншъя. Тайлбар хэлнэ гэсэн.

“Тендер үнэлгээнд төсөл, хөрөнгө оруулалт, шууд нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно.” гэсэн ийм заалтыг нэмж байгаа юм байна.

С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

**С.Эрдэнэбат:** Хариуцах Байнгын хорооны асуудал би бол мөн гэж бодоод байгаа юм.

Одоо бид чинь сая төсөв хэлэлцэхэд бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, зээл, өр гээд л баахан юм яриад байгаа.

Тэгэхээр асуудал энэ дээрээ эдийн засгийнх нь хөшүүргийн аргаар нь холбож өгөхгүй бол тэр нийгмийн чиглэлийн юмнууд чинь унана.

Одоо олон улсын Азийн хөгжлийн банк дээр юу гэж яригдаж байна вэ гэхээр энэ хөрөнгө оруулалт шууд болон шууд бус замаар үр дүн хүртэгчдийг олон байх юм бол үүнийг дэмжинэ гэдэг ийм аргачлалууд байдаг.

Одоо бүр хувийн хэвшлийн банкууд хүртэл 100 сая төгрөг буюу түүнээс дээш зээл олгохдоо энэ компани энэ зээлийг авснаараа хэчнээн ажлын байр бий болгох вэ, хөдөлмөр хамгаалал, нийгмийн аюулгүй байдлыг нь хангадаг компани уу, үгүй юу гэдэг үнэлгээгээр зээл олгодог болчихоод байгаа. Хувийн хэвшлээсээ.

Тэгэхээр манай төр өөрөө эндээсээ хоцроод баахан бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт баталлаа гээд л манай тойрог тэрний юугаа хаядаг. Тэрийг нь

барьж байгаа хүмүүс, маш их хүмүүсийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой эрсдэлтэй зүйлүүд хийдэг. Хөдөлмөр хамгаалал “тэг”.

Мөн нөгөө талаасаа тендерээ зүгээр аваад бие биедээ зардаг. Байнгын ажлын байргүй гэх мэтчилэн ийм үнэлгээнүүдийг ерөөсөө тендерийн юунууд дээр оруулж өгдөггүй болохоор.

Одоо саяхан өчигдөр хүртэл томоохон маргаанууд гараад байсан. Чадавхтай компани гэдгийг шууд сонгоно, болно гэдэг дээр хүртэл орж ирээд байсан.

Тэгэхээр ийм үнэлгээнүүдийг бид хийхгүйгээр зүгээр ганцхан хамгийн бага үнийн аргаар ч гэдэг юм уу, эсвэл зөвхөн гадаадын том компаниуд ч гэдэг юм уу, үндсэн дамнасан корпорацууд ч гэдэг юм уу ийм байдлаар юмыг дандаа эдийн засаг, санхүү, мөнгө талаас нь хараад байвал нийгмийн маш олон үнэлгээнүүд унана.

Нөгөө давхар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авч байна уу, ахмад настyg дэмжиж байна уу, эмэгтэйчүүдийг дэмждэггүй. Ажлын байрны тэр дарамт, хүчирхийллийг хийдэг үү, үгүй юу гэх мэтчилэн ийм нийгмийн үнэлгээнүүдийг нь давхар эдийн засгийн хөшүүргүүдээр л холбож өгөхгүй бол бид нарын энэ яриад байгаа юмнууд дандаа мөрөөдөл болно.

Тийм учраас энэ тал дээр оруулж өгвөл. Энэ яах вэ ерөнхий санал л даа. Шууд дээр тийм мөнгө төгрөг оруулна, ингэнэ тэгнэ гэсэн юм бол байхгүй.

Тийм учраас тал энэ дээр нь 4 жилийн хугацаанд эрх зүйн орчныг нь л бий болгож өгье гэж байгаа юм.



Түрүүний хэлдэг тэр барилга байгууламж байгуулбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэр хүртээмжтэй юм, хүүхэд харах үйлчилгээнүүдтэй хэр ойр юм, цэцэрлэг сургууль нь хавьд нь байдаг юм уу ч гэх юм уу. Тийм үү.

Тэгэхээр ийм хэчнээн ажлын байрыг бий болгох юм, цалин дунджаар хэд байх вэ, нийгмийн хамгааллынх нь асуудлууд давхар шийдэгдэх вэ гэх мэтчилэн ийм үнэлгээнийх нь эрх зүйн орчныг бий болгож өгөхөд маш чухал.

Хувийн хэвшлүүд хүртэл энэ дээр аягүй дэмжих ийм саналуудыг ярьдаг юм гэдгийг хэлмээр байна.

**Л.Энхнасан:** Нийгмийн үнэлгээ гэж байгаа учраас санал хураалт хийе.

Санал хураалтаа хийе. Гишүүний санал ирсэн учраас тендер үнэлгээнд төсөл, хөрөнгө оруулалт, шууд дам нөхцөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгох” гэснийг дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

63.2 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Хоёр гишүүн гаргасан байгаа. С.Эрдэнэбат болон О.Саранчулуун гишүүн.

2.3.4.3-д нэмэхээр.

Эрүүл мэндийн ажилтны цалин хөлс гэж нэмж, нийгмийн баталгааг сайжруулж, алгасгасан гэдгийг хасаж, төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал нэмнэ гэж байгаа юм уу. Тийм ээ. Нэмнэ гэж оруулахаар оруулжээ.

Тайлбараа хийнэ үү. Хэн хийх вэ? С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Санал оруулаад л байдаг. Унаад байдаг.

Хоёр гол чухал салбар байгаа. Бид боловсрол дээр цалин, үнэлэмжийг нь нэмэгдүүл гээд тавьчхаад, эрүүл мэндээ орхичихсон байна. Цалингийнх нь асуудлыг нэмнэ гэдэг юмыг. Хөдөлмөрийн үнэлэмжийг нь сайжруулна гэдэг.

Тэгэхээр нөгөө мэргэжил, ажил, албан тушаал гэдгээр нь ялгахгүйгээр энэ хоёр чухал суурь салбар дээрээ адилхан оруулаад өгчихье. “Цалин хөлс” гэдгийг нь нэмээд өгчихье.

Дээрээс нь бас нэг асуудал байгаа юм. Хөнгөлөлт, дэмжлэгийг зөвхөн алслагдсан бүсэд гээд тавьчхаад байгаа юм.

Тэгэхээр энэ чинь Улаанбаатар хотод байгаа маш олон эрүүл мэндийн салбар маш их ачаалалтай ажиллаж байгаа газрууд байгаа. Эд нар маань ирэх 4 жил ямар нэгэн дэмжлэг, хөнгөлөлтийг үзүүлэхгүй гэсэн үг үү гэдэг шууд дээр гарч ирэх гээд байгаа юм.

Тийм учраас хүн амынхаа суурьшлын бүс Улаанбаатар хотод байгаа энэ зам гүүртээ хөрөнгө оруулж байгаатай ижилхэн ачааллыг нь харгалзаж хүндээ хөрөнгө оруулалт хийе.

Тэр тусмаа одоо энэ эрүүл мэндийн салбар, боловсролын салбар гэх мэтчилэн энэ зүйлийг нь давхар авч үзэхгүй бол хэт зөвхөн хаана амьдарч байгаагаас нь хамааруулаад ялгаж байгаа гэдэг ийм асуудлыг энэ салбарт яриад эхэлчихсэн байгаа учраас дэмжиж өгөхийг хүсье.



Нийтэд нь тавья. Алслагдсанд нь ямар дэмжлэг үзүүлэх вэ, хотод нь ямар дэмжлэг үзүүлэх вэ гэдгээ дараа нь хөтөлбөрийг задалж бичихдээ тавьж болох байх.

Тийм учраас байршлаар нэг их тийм ялгаад байх бол хэрэггүй болов уу гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайдаас тодруулга авъя. 4 дүгээр микрофоныг нээж өгнө үү.

**Т.Мөнхсайхан:** Энэ хэсэг маань яах вэ, хөдөө орон нутагт, ялангуяа сум, орон нутагт ажиллах боловсон хүчний дутагдал улам нэмэгдэж одоо тийм тогтвортой ажлын байраар хангагдахгүй байгаа.

Тийм учраас алслагдсан орон нутагт илүү их дэмжлэг, энэ нийгмийн баталгааг нь хангаж өгье л гэдэг утга агуулгатай байгаа юм.

Гэхдээ энэ дээр ерөнхийд нь эрүүл мэндийн салбарынхныг цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгааг хангаж өгнө. Гэхдээ алслагдсан болон Улаанбаатар хоёрын хоорондын ялгааг нь илүү сайн гаргаж, зааглаж, хөдөө орон нутагт илүү их боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах боломжийг нь хангаж өгөх чиглэл рүү явна гэдэг заалтаар ороход болохгүй юм байхгүй болов уу гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Тэгэхээр саяын энэ заалтыг уншъя.

2.3.4.3. эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллийг нэмэгдүүлнэ.

Орон нутагт гэдгийг хасах юм уу? С.Эрдэнэбат гишүүн. Микрофоныг өгнө үү.

Ц.Идэрбат гишүүний микрофоныг өгнө үү. Микрофон нээчихсэн байна. Ц.Идэрбат гишүүний микрофоныг дахиж өгнө үү.

**Ц.Идэрбат:** Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр Нийгмийн бодлогын байнгын хороотой холбоотой нэлээдгүй асуудлууд орж ирж байна.

Үндсэндээ тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэд ахмад настан гээд. Бас урьд өмнө нь байгаагүй олон зүйлүүдийг сегментийг төлөөлж орж ирсэн манай хүмүүс маш сайн их тод томруун гаргаж ирж байна гэж би харж байна.

Тэгээд нэлээдгүй зүйлүүд Нийгмийн бодлогын байнгын хорооны мөрийн хөтөлбөрийн санал дээр ингээд явах нь байна.

Бид нэг зүйл дээр жоохон бодолтой хандахгүй бол Монгол Улсын 3 сая 300 мянган хүний сайн сайхны төлөө л ажиллаж байгаа энэ төрийн албан хаагчдыг энэ салбар нь их чухал юм гэж ингэж ангилж ялгахгаа одоо больё гэдгийг өнгөрсөн 4 жилийн хугацаанд.

Энэ төрд ажиллаж байгаа хүмүүсийн цалин цагааны асуудлыг жигдхэн л аваад явъя гэдэг ийм үндсэн зарчим өнгөрсөн 4 жилээс амжилттай хэрэгжээд, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа хүмүүст орон нутгийн нэмэгдлүүд олгоод, гар дээр ирж байгаа үндсэн цалингийн хэмжээ 10, 20 хувь нэмэгдсэн боловчиг яг гар дээр ирж байгаа мөнгөн дүнгийн хувьд бас нэлээдгүй нэмэгдээд.

Ингээд Монголын төрийн албаны цалин цагааны бодлого нэг салбарыг онилдоггүй нийт төрийн албан хаагчид руугаа чиглэдэг ийм зарчим руугаа яваад давгүй үр дүнд хүрээд явж байгаа гэж харж байгаа. Ялангуяа орон нутагт ажиллаж байгаа хүний хувьд, орон нутгаас сонгогдсон хүний хувьд.

Тэгэхээр энэ ингээд зүгээр голдиролдоо орж эхэлж байгаа юмыг бид өнөөдөр зүгээр мөрийн хөтөлбөр дээр нэг салбарыг нь татаж аваад л эвдэж болохгүй байх гэж би зарчмын байр суурьтай байгаа.

**Л.Энхнасан:** С.Зулпхар гишүүний микрофоныг нээе.

**С.Зулпхар:** Баярлалаа. Манай гишүүдийн гаргаж байгаа санал зөв өө.

Гэхдээ бүгдээрээ зөв гэж бид ойлгож болох ч гэсэн төрийн бодлого, үйл ажиллагаа нэгдмэл байх ёстой гэдэг үндсэн зарчмаа бид барьж байх ёстой. Хөтөлбөр дээр түүнийгээ тусгах ёстой байгаа юм.

Чуулганы хуралдаан дээр ч гэсэн ийм саналууд гарсан.

Боловсролын салбарт багш нарын цалинг нэмье. Зөв өө. Нэмээд явж байгаа.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд төрийн албан хаагчдын цалинг боломжийн түвшинд нэмэх зорилтыг Засгийн газар хэрэгжүүлсэн. Цаашдаа ч гэсэн хэрэгжүүлэх ёстой. Тийм тогтоол нь байгаа гэж байгаа юм.

Гэхдээ энэ төрийн албан хаагч чинь “төрийн захиргааны”, “төрийн тусгай”, “төрийн үйлчилгээ”, “төрийн улс төрийн албан хаагч” байхаас үл

шалтгаалаад тодорхой чиг үүргийг нийгэмд хэрэгжүүлдэг.

Энэ цалин хөлсний бодлогыг нэгдмэл болгоё гэдэг үндсэн бодлогыг Засгийн газар бариад явж байгаа. Үүнийг Улсын Их Хурлаас бидэнд чиглэл болгож байсан. Тухайн үед.

Тэгэхээр энэ чиглэлээ бариад явах нь зөв байх.

Би яах вэ, манай хоёр гишүүний санал зөв учраас одоо маргааш Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг нь өгье.

**С.Зулпхар:** Маргааш Төрийн байгуулалтын байнгын хороон дээр тэр “**засаглалын реформ**” гэдэг хэсэгт яг энэ цалин хөлсний асуудал байгаа юм.

Түүн дээр саналаа гишүүд бүгд нэгтгээд оруулчихвал яасан юм бэ.

Төрийн албан хаагчдын цалин хөлс нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл бол ер нь бэлэн болчихсон байгаа шүү дээ. Гэхдээ энэ хуулийн төсөл нь. Одоо энэ бол бас амаргүй ажил.

Тэгэхээр нэгтгэсэн байдлаар засаглалын реформ дээр оруулаад, тэгээд түүн дотор багш нарын цалин ч, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин ч тэр, төрийн захиргааны болон төрийн тусгай чиг үүргийн албан хаагчдын цалин ч гэсэн тэр дотроо нэгдмэл байдлаар явдаг ийм бодлогын зорилтоо оруулчихвал яасан юм бэ гэсэн саналтай байна.

**Л.Энхнасан:** Тодруулга хэлье. С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээнэ үү.

**С.Эрдэнэбат:** Тэгэхээр зарим салбарыг яах вэ, онцлоод байгаа асуудал ерөөсөө биш байгаа.

Бид саяхан Нэгдсэн Үндэстний Байгууллагад Монгол Улс хүний хөгжлийнхөө тайлан өгөхөд хамгийн чухал хоёр салбараа Та нар анхаар. Боловсрол, эрүүл мэнд хоёр гэдэг чинь тухайн салбарыг дэмжээд байгаа юм биш. Дагаад боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ гэдэг юм дээр чинь хүний нөөцийн асар том дутагдалд орох нь. Эхний шинж тэмдгүүд нь эхлэх юм руу орно.

Сувилагч гэхэд өнөөдөр эмнэлгүүд дээр бараг сувилагч байхгүй болж эхэлж байгаа. Гадаадын бүх улс орнууд сувилагч гэдэг орон тоо бол ирэх 10 жилд ерөөсөө маш хамгийн өрсөлдөөнтэй буюу цалин хөлс нь бараг 10 дахин өсөхөөр байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид зарим салбар дээр. Би огт байхгүй юмыг яриагүй. Угаасаа энэ дээр байгаа юман дээр нь тодруулаад тавьчихъя.

Нэг салбар дээр нь байлгаад нөгөө салбар дээр нь байлгахгүй байхаар нөгөө хоёр салбар маань намайг орхилоо гэдэг байдлаар тавьчих учраас онцолж хоёр салбар. Тэртээ тэргүй хөтөлбөр дээр байгаа.

Одоо бүх намуудын. Тийм. Бүх мөрийн хөтөлбөр дээр байгаа.

**Л.Энхнасан:** Санал хураалт хийе.

Тэгэхээр эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг

сайжруулж. Орон нутгийг нь үлдээгээд. Тийм ээ. Орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулыг нэмэгдүүлнэ гэж өөрчлөхөөр энэ саналыг дэмжихээр санал хураалт явуулъя.

57.9 хувиар дэмжигдсэнгүй.

Одоо сүүлийн санал.

2.1.2.2. Ж.Баярмаа гишүүний санал байгаа. Нэмэхээр.

Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно гэсэн заалт байна.

Ж.Баярмаа гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ж.Баярмаа:** Сая бараг хальт яригдаж байна. Тийм ээ.

Тэгэхээр багш, эмч гэхгүй ерөөсөө төрийн албаныхаа цалин хөлсний сүлжээг шинэчилбэл яасан юм бэ. Өөрчилбөл яасан юм бэ.

Нэг ёсондоо бараг чөлөөлбөл яасан юм бэ гэсэн агуулга.

Одоо манайх чинь гурван зах зээл. Эд бараа чөлөөтэй зах зээлд орчихсон шүү дээ. Шилжчихсэн. Бараг 30 гаруй жил болж байна.

Санхүүгийн зах зээл тодорхой хэмжээнд хөгжөөд явж байгаа.

Хөдөлмөрийн зах зээл ерөөсөө эрэлт, нийлүүлэлтдээ тохирохгүй. Энд нь төрийн албаны цалингийн сүлжээ нөлөөлөөд байна гэж үзэж байгаа.

Тэгээд манай үндсэн концепц чинь аль аль нам л ерөөсөө “төрийг цомхон, чадварлаг болгоё” гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр “цомхон болгох”, “чадварлаг болгох” дээр одоо тэр цалин хөлсний тариф сүлжээг чөлөөлж байж тэр нь тэр зүг рүүгээ орно.

Энэ бол ер нь нэлээн зарчмын том реформын л асуудал л даа.

Тэгэхээр яах вэ, тогтолцоог бүрдүүлнэ гэж явж байгаа. Тийм ээ. Тэгээд яваандаа эрх зүйн тэр тогтолцоо нь бүрдэх байх. Тэгээд энэ рүү орох нь зүйтэй л гэж бодож байна.

Ингэхээр одоо чинь аяндаа төрийн алба чинь өөрөө зах зээлийн горимд шилжчихнэ шүү дээ. Тэгээд зах зээлийн горимд шилжээд цалин хөлсөөрөө явагдаад ирэхээр чинь бусад салбар луу оролт нэмэгдэнэ.

Тэгээд магадгүй төрийн албанд шаардлагагүй хүмүүс чинь гараад бусад салбар дахь ажиллах хүч нь нэмэгдэнэ гэсэн үг.

Ингээд ирэхийн цагт. Одоо жишээлбэл яг хувийн хэвшлийнхэн чинь төрийн албаны цалингийн сүлжээг харж цалингаа тавиад байгаа байхгүй юу. Түүнтэй дүйцүүлэх маягаар.

Тэгэхээр төрийн албаны цалин сүлжээний минь тогтолцоо өөрөө ингээд шинэчлэгдээд нэг ёсондоо чөлөөлөгдөөд, либералчлагдаад ирвэл аяндаа хувийн хэвшлийнхний цалин ч гэсэн өөрчлөгдөнө, нэмэгдэнэ. Тийшээ очих тэр ажиллах хүч нь ч нэмэгдэнэ.

Тэгээд сонгодог утгаараа төр маань чадварлаг, цомхон болно.

Тэгээд бүр том реформ гэх юм бол салбарын сайдуудад бараг эрхийг нь олгоод. Тийм ээ. Өөрийнхөө салбарын тэр багцад тааруулж цалингаа хүргэ. Аль сайн ажиллаж байгаа, аль үр дүнтэйд нь цалинг нь нэм. Шаардлагагүй орон тоогоо хас гээд.

Ингээд бараг салбар луу нь тэр цалин мөнгөнийх нь чөлөөлөх тэр эрхийг нь ч юм уу олгоод явбал яваандаа зах зээл чинь чөлөөлөгдөнө л дөө.

Манайд ерөөсөө огт либералчлагдаагүй байгаа ганц зах зээл чинь л энэ хөдөлмөрийн зах зээл.

Тэгэхээр ямар ч байсан нэг ийм маягаар оруулаад үзвэл яасан юм бэ гэсэн саналаар оруулж байгаа юм. Либералчлах гэж үг байгаа. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг дэмжээд өгвөл аяндаа энэ чинь цаашаа төрийн алба маань ч гэсэн цэгцрээд ирнэ, цомхон болоод ирнэ, чадварлаг болоод ирнэ. Нөгөө дутагдаад байгаа ажлын талбар дахь ажиллах хүчин чинь нэмэгдээд ирнэ гэсэн ийм ийм давуу тал буюу онцлогууд байгаа. Тэгээд нэлээн том л реформын шинжтэй санал л даа.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс хариулах хүн байна уу? С.Зулпхар гишүүний микрофоныг.

**С.Зулпхар:** Ж.Баярмаа гишүүнд баярлалаа.

Их чухал санал биднээс гарч байна. Гэхдээ яах вэ, бас мэдээллийн чанартай хэлэхэд төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ шинэчлэгдсэн.

Сүүлийн 4 жилийн хугацаанд. Ер нь 360 гаруй янзын цалин байсан юм.

Тэгээд тэрийг нь багасгасаар байгаад зохих түвшинд хүрчихсэн байгаа.

Түүнээс гадна гүйцэтгэлийн үнэлгээгээр цалин олгож байгаа салбаруудад шинэчлэл хийгдсэн шүү дээ. Эрүүл мэнд болон боловсрол дээр зохих түвшний үр дүн гарч байна.

Цаашдаа төрийн захиргааны зарим байгууллагууд руу үүнийг оруулна, туршина гэсэн хэлбэр лүү чиглээд явж байгаа гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол огт хийгдээгүй гэж ойлгох нь бас жоохон өрөөсгөл болчих байх.

Бүхэлдээ хөдөлмөрийн зах зээл либерал биш гэж хэлэх бол их өрөөсгөл л дөө. Яг цэвэр эрэлт, нийлүүлэлт дээрээ л байж байгаа.

Аль ч салбар дээр ажлын байраа нээлттэй зарлаад тэр цалин хөлс ажлын нөхцөлийг сонгосон хүн л очиж байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг шууд хэлж болохгүй байх. Гэхдээ яг саяын томьёоллоор хэлчихээр зэрэг би яг ямар үр дүн гарах бол оо гээд эргэлзээд байна л даа.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтдээ уялдсан цалингийн систем бий болгоно гэхээр зэрэг ийм зүйлийг бид дангаараа төр хийх боломжгүй.

Энэ цалин хөлсийг ажил олгогч болон ажилтан өөрөө харилцан тохирч байж шийддэг зүйл шүү дээ. Ялангуяа хувийн хэвшил дээр.

Төрийн албанд тогтсон цалингууд өгөгдөнө. Төрийн захиргаан дээр ч бай, төрийн тусгай дээр ч бай тэр бол албан тушаалын, ажил үүргийн, түүнээс гадна

тодорхой нөхцөлүүдтэй уялдсан байдлаар.

Үүнийг харин бид төр өөрөө мэдээд зохицуулаад явах боломжтой. Энэ бол хийгдэж байгаа шүү.

**Л.Энхнасан:** Ж.Баярмаа гишүүний микрофоныг. 1 минут товчхон.

**Ж.Баярмаа:** Тайлбар дотроо гарах үр дүн нь хувийн хэвшилд нөлөөлнө, бүтээмж дээшилнэ, хувийн хэвшилд ажиллаж байгаа хүмүүсийн цалин үүгээрээ дагаад нэмнэ гэдэг агуулгаар хэлсэн болохоос биш бид мэдээж хувийн хэвшлийнхний цалинг нэмэх, хасах тухай яригдахгүй л дээ.

Энд цэвэр төрийн албаны цалингийн тарифыг л ярьж байгаа. Үүнийг л чөлөөлөх тухай.

Одоо яг эсрэгээрээ зоогоод хатуу тогтчихсон. Үүнийг нь чөлөөлье. Тэр салбарын сайдууд нь мэддэг болог. Шаардлагатай байгаа тэр орон тоогоо нэм, цалинг нь нэм, шаардлагагүй юм бол хас гэдэг.

Одоо дандаа л яригдаж байна шүү дээ. Багш, эмч нарын цалин гээд.

Тэгэхээр энэ чинь хатуу чөлөөлөгдөөгүй учраас зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр явахгүй байгаад байгаа байхгүй юу. Огт явахгүй байна шүү дээ. Багш нар байхгүй. Дутагдалтай. Сувилагч байхгүй. Дутагдалтай. Эмч байхгүй. Дутагдалтай.

Тэгээд цаана нь ямар асуудлууд байна гэдэг талаас нь харах юм бол чинь энэ нөгөө л хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж, цалин хөлсний л асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхээр угаасаа хөдөлмөрийн зах зээлийг бид огт хөндөөгүй. Төр дэх хөдөлмөрийн зах зээлийг огт хөндөөгүй.

**Л.Энхнасан:** Санал хураалт хийе. И.Идэрбат гишүүний микрофоныг нээе.

**Ц.Идэрбат:** Улсын Их Хурлын Байнгын хороо гэдэг өөрөө их том чухал бүтэц л дээ.

Ялангуяа мөрийн хөтөлбөр яригдаж байгаа энэ цаг үед Их Хурлын гишүүн маань санал хэлнэ, нөгөө гишүүн нь хариулаад тэгээд шууд санал хураагаад явна гэж.

Тэгвэл тэнд сууж байгаа хүмүүс ямар үүрэгтэй сууж байгаа юм. Би Байнгын хорооны даргад хандаж хэлж байгаа юм.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төслийг боловсруулж ирсэн хүмүүс нь Их Хурлын гишүүдээс гарсан санал туссан уу, тусаагүй юу, төрийн бодлого хаашаа явж байгаа вэ гэдгийг энэ зүүн, баруун жигүүрийн хоёр гишүүн хоорондоо ярилцаад байхаас биш тэр Засгийн газрын төлөөлөл хариулах ёстой л доо.

Тэгээд тийм байдлаар нэгд хурлын маань зарчим нь тийм байх ёстой шүү дээ. Түүгээрээ нэгдүгээрт явмаар байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь зүгээр яах вэ, би төрийн албаныхан дээр хэлэхэд одоо ердөө дарга цэрэггүй л төрийн алба данхайлаа л гэж яриад байдаг юм.

Тэгэхдээ нөгөө тал руугаа харангуутаа 4100 багш дутуу байна гээд халаглаад байгаа юм.

Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувилагч олддохгүй байна гээд л халаглаад байгаа юм.

Хүн ам өсөхийн хэрээр сургууль, соёл, нийгмийн байгууламжууд нэмэхийн хэрээр тэр төрийн албан хаагчдын тоо нэмэгдээд л байгаа шүү дээ.

Харин бид бол харин өнөөдөр Х.Булгантуяа дэд даргын хэлдэг нэг агентлаг бодлогын яамнаас илүү 130 хэдэн хүнтэй хэрнээ ажил нь явахгүй байгаа гэдэг энэ юмыг ялгаж салгаж ярихгүй бол нийт төрийн албан хаагчдыг бүгдийг нь л аваачиж хамруулаад л.

Одоо яг цэрэг, цагдаа гэвэл 21 мянга л байдаг юм билээ шүү дээ. Цагдаагийн орон тоо нь бас дутуу. Тэгээд болгоныг нэмэх юм бол одоо ер нь юу болох юм бол.

Тэгэхээр яах вэ, зүгээр ер нь төрийн албаны цалин цагаан юмнуудыг бид энд ингээд босон суун яриад нааш нь цааш нь болгоно гэхээсээ илүүтэйгээр энэ төрийн алба гэдэг том зургаар нь хараад байх ёстой, байх ёсгүй, эсвэл төрийн албаныхаа ангилал юмыг нэг хараад ингэж дуугарахгүй бол ер нь төрийн албыг хэдэн хүн ирээд л татвар төлөгчдийн мөнгөөр сул цалинжаад байгаа хүмүүс шиг ийм ойлголтыг тараагаад байдаг болчихсон юм билээ. Ер нь.

**Л.Энхнасан:** Ж.Баярмаа гишүүний зарчмын зөрүүтэй санал дээр санал хураалт хийе.

Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн. Тэндээс би сая ажлын хэсэгт хариулах хүн байна уу гээд. Одоогоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын.



1 дүгээр микрофон.

**Л.Балчинлуvsан:** Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан.

Хөдөлмөр эрхлэлт эрэлт, нийлүүлэлтэд нийлүүлэн зохицуулах тийм заалтууд орсон байгаа. Бүр тодорхойлон заавал “Хүний хөгжил” бүлгийн 2.1.2.1 дээр “хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилнэ” гэдэг агуулгын хүрээнд саяын яригдсан томьёоллууд багтаж байгаа.

С.Зулпхар гишүүний хэлдэг саналууд зөв. Одоо зах зээл дээр бид боловсролын салбараараа дамжуулж зохицуулалт хийх боломж байгаа.

Яагаад вэ гэхээр нийгмийн болон эрэлт хэрэгцээтэй, шаардлагатай мэргэжлүүдийн харьцаа 1:7 гэсэн харьцаатай байгаа.

Нийгмийн мэргэжилтэй боловсролын тогтолцоонд бэлдэж байгаа хүмүүс маань 1:7 харьцаатайгаа байгаа учраас үүнийг бид боловсролын бодлогоороо дамжуулж зохицуулах шаардлагатай байгаа.

Сая Ж.Баярмаа гишүүний ярьдаг төрийн албан хаагчийн цалингийн асуудал дээр манай “Төрийн реформ” гэсэн дэд бүлгийн хүрээнд бид гүйцэтгэлийн менежмент рүү шилжих бодлогын реформын ажлуудыг энд тусгасан байгаа.

**Л.Энхнасан:** Саналаа хураагаад явчихъя.

Ер нь энэ ажлын хэсэгт Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны төлөөлөл байхгүй болчихсон байна. Цаашид оруулаарай. Нэг ч төлөөлөл алга.

Ажлын хэсгээс хариулах хүн байхгүй байна.

Ж.Баярмаа гишүүний санал дээр санал хураалт хийе.

“Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно” гэсэн. Дэмжихээр санал хураалт хийе. /алх цохив/

57.9 хувиар дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийн [2 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүн байхгүй байна. Санал ирээгүй байна. /алх цохив/

Тогтоолын төслийн [3 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Санал ирээгүй байна. Байхгүй байна. /алх цохив/

Тогтоолын төслийн [4 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Санал ирээгүй байна.

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар Төрийн байгууллагын

байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

---

**Гурав. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

---

Хэлэлцэх хоёрдугаар асуудал руугаа орё. Ажлын хэсгийг оруулна уу.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэцэгсүрэнгийн Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Лувсандагвын Мөнхцацрал аудитын менежер, Юрагийн Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамбалдоржийн Алтантуяа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Ваанчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Жаргалсайханы Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан

үүргийн түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Бямбасүрэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батчулууны Батчимэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга гээд бүрэлдэхүүнтэй ирсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг нээнэ үү.

**Б.Жавхлан:** Баярлалаа.

Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

**“Хурдтай хөгжлийн төлөөх зориг”** хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

**“Алсын хараа-2050”**, **“Шинэ сэргэлтийн бодлого”** Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн их бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу GoMongolia ган татлагат гүүр, Хөшгийн хөндийн туннел, Хөшгийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, Шинэ Хархорин төсөл, Шинэ 100 мод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг, төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

**Хоёрдугаарт**, Гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

**Гуравдугаарт**, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ, тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах, хувийн хэвшилд тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

**Дөрөвдүгээрт**, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийж байна.

**Тавдугаарт**, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, “Ирээдүйн өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан”

гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон.

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон тэдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Л.Энхнасан:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Микрофоныг нээнэ үү. 3 дугаар микрофон.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагдаж хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж,

улс төрийн гурван намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дүгнэж байгаа юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зардалд нийт 41.9 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд асуулт асуух гишүүн байна уу?

Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын

газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн Та бүхэнд ирүүлсэн байгаа.

Ингээд С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

**С.Эрдэнэбат:** Нэгдүгээрт, зарим нэг сургуулийн цэцэрлэг, барилга гээд маш олон юунууд байгаад байдаг.

5, 6 жил, 7 жил, 8 жил гээд аягүй урт яваад байх юм.

Тэгэхээр зарим маш цөөхөн үлдэгдэлтэй байгаа ч гэдэг юм уу, тийм сургууль, эмнэлэг ч гэдэг юм уу, эд нарыг энэ жилдээ багтаагаад дуусгачих тийм боломж бололцоо байгаа юу гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт, томоохон бүтээн байгуулалтын зардлууд эхний байдлаар ороод ирж байгаа. Гол төсвийн зардлууд.

Энэ маань ирээдүйд ер нь ирэх жилүүдэд нөгөө нийгмийн зардлуудтай чинь шууд ачааллыг үүсгэх вий. Өөрөөр хэлбэл цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгаалалттай холбоотой зардлуудыг төсөвт дараа нь ачаалал үзүүлээд, ийм зардлуудыг гаргахад сөрөг нөлөө үзүүлэх үү гэж асуумаар байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын санд хүү тооцох асуудлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл болон иргэдээс тавьсан. Энэ тал дээр чөлөөт үлдэгдлүүдэд нь хүү тооцох ийм зүйл туссан уу?

Хамгийн сүүлд нь төсөв хөрөнгө тусчихсан байж байгаа эдгээр төсвүүдэд нийгмийн үнэлгээний тийм зүйлийг ер нь та хэд тооцдог уу? Сангийн яамнаас.

Хамгийн бага үнийн аргаараа гэдэг байдлаар яваад байгаа. Одоо шинээр орж ирж байгаа төсөв дээр шаардлага хангасан байх юм бол шууд гэрээ байгуулж болно гээд байгаа.

Шаардлага хангасан гэдэг дотроо яг ямар ямар үзүүлэлтүүдийг тусгаж оруулж ирж үнэлж тэр тендер болон тэр шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулах юмнуудаа хийх гээд байгаа юм бэ гэдэг асуулт байна.

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан хариулна уу? 4 дүгээр микрофон.

Сангийн яамнаас асууж байгаа юм байна. Тэгвэл Сангийн яамны М.Санжаадорж даргын 1 дүгээр микрофоныг нээнэ үү.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Эхнийх нь сургууль, эмнэлгүүдийг дуусгах асуудал ярьж байна.

2018 болон 2019 онуудад эхэлсэн сургууль, эмнэлгүүд хэд хэдэн юмнууд байгаа. Нийслэл дээр ялангуяа нэлээд их байгаа. Энэ асуудалтай холбоотойгоор бид ажиллаж байгаа.

Нэгдүгээрт, төсөвт энэ жилдээ зохицуулалт хийх замаар сайн явж байгаа гүйцэтгэлүүдийг аль болох хурдан дуусгах, ялангуяа 9 сарын 01-нээс өмнө дуусгах асуудал.

Хоёр дахь нь, нийслэл мөн энэ дээр зохион байгуулалтынхаа ажлыг аваад явж байгаа.

Дэд дарга Л.Хосбаяр даргаараа ахлуулсан ажлын хэсэг гаргаад яаралтай одоо энэ удсан эмнэлэг, сургуулиудыг ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа. Зохион байгуулалтын хувьд.

Ер нь цаашдаа бид яаж энэ асуудлыг болих юм бэ гэхээр ТЭЗҮ нь маш бодитой байх хэрэгтэй, газрын асуудал нь шийдэгдсэн байх ёстой.

Өөрөөр хэлбэл төсөвт тусгахдаа эхлээд бэлтгэл ажлаа маш сайн тооцсон байх юм бол ийм асуудал гарахгүй ээ гэж бид хараад байгаа юм.

Хоёр дахь нь, том бүтээн байгуулалтын зардлуудаа тавихаар дараа нь дагаад урсгал зардал явах уу гэж байна. Том бүтээн байгуулалтын зардлууд дээр нөгөө замын асуудлууд байгаа учраас зам дээр урсгал зардлын асуудал одоо их засвар, тэгээд нөгөө арчилгаатай холбоотой зардлууд бага зэрэг гарах байх.

Хүн хүчний хувьд тийм айхтар гарна гэж бид тооцохгүй байна. Яагаад гэхээр аль болох хувийн хэвшилд энэ замыг хариуцуулах, мөн дээрээс төлбөртэй зам байгуулах. Энэ төлбөрөөрөө эргээд энэ замынхаа арчлалтыг хийгээд явах энэ агуулгаар бид харж байгаа. Тэгэхээр айхтар зардал гарахгүй.

Дараагийн асуудал бол Эрүүл мэндийн даатгалын санд хүү тооцох асуудал ярьж байна.

Нийгмийн даатгалын сан ч тэр, Эрүүл мэндийн даатгалын сан ч тэр. Хэрвээ чөлөөт үлдэгдэл байгаа бол энэ дээр бид хүү тооцоод явахад ямар нэгэн байдлаар татгалзах зүйлгүй.

Яг одоо явж байгаа бодлогоор Эрүүл мэндийн даатгал маань ч тэр, нийгмийн даатгал маань ч тэр чөлөөт үлдэгдэл байнгын эргэлзээтэй байгаа. Яах вэ, Нийгмийн даатгалын сан дээр нөгөө ажилгүйдлийн сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжил. Түүн дээр боломжийн хэмжээнд мөнгө хуримтлагдсан байгаа.

Энэ дээр арилжааны банканд хадгалуулах, цаашдаа хүү тооцох асуудлыг бид ерөнхийдөө харна.

Тэгэхдээ аль болох нөгөө өмнө нь учирч байсан эрсдэлийг гаргахгүй байхаар. Арилжааны банк маань ямар ямар шалгуурыг хангачихсан байх вэ, найдвартай байдал нь аль вэ гэдэг талаар харж байгаа.

Хэрвээ төрийн санд хадгалсан тохиолдолд төрийн сан дээр бодлогын хүүгээр бас хүү өгөөд явах ийм боломж байгаа.

Нийгмийн үнэлгээг хөрөнгө оруулалт дээр тооцдоггүй гэж асууж байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дээр яг энэ агуулгаар тавьсан байдаг. Жилийн хөгжлийн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр гэж баталдаг. Энэ дээр нийгмийн ач холбогдлыг эрэмбэлж авч үзээд, дээрээс нь хөрөнгө оруулалтын өгөөж нь ямар байх вэ гэдгийг бас авч үзэх ёстой гэсэн ийм хуулийн заалт байгаа. Энэ дагуу үнэлгээ хийгдээд явдаг. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг өгье. Тодруулга.

**С.Эрдэнэбат:** М.Санжаадорж дарга аа, эхний асуултыг арай жоохон өөрөөр ойлгочих шиг боллоо.



Одоо нэлээн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтууд дээр мөнгө тавигдаад байна. Зээл, концесс, гаднын хөрөнгө оруулалт. Энэ чинь эргээд дандаа төлөгдөнө. Тодорхой хэмжээгээр.

Тэгэхээр энэ төлөх заалтууд чинь ирээдүйд. Хамгийн их бидний ярьдаг. Цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлуудыг шийдье гэнгүүт нь одоо зээл төлж байгаа учраас боломжгүй байна гээд маргаан үүсээд эхэлдэг.

Тэгэхээр ирэх жилүүдэд ийм хүндрэл эрсдэлүүд үүсэх нөхцөл байдал хэр байх вэ? Тухайлбал, сарын дараа төсвийн тодотголоор цалин хөлсний асуудал ч гэдэг юм уу, орж ирнэ.

Тэр үед хөрөнгө оруулалтууддаа мөнгө тавчихсан учраас цалин нэмэх мөнгө байхгүй ээ, тэтгэвэр нэмэх мөнгө байхгүй ч гэдэг юм уу, ийм зүйлүүд яригдах болов уу гэдэг дээр би их санаа зовоод байгаа юм.

Энэ тал дээр бас үүнийг давхар тооцож байна уу? Ийм зүйл гарах уу гэдэг зүйлийг асууж байгаа юм. Тийм.

**Л.Энхнасан:** М.Санжаадорж даргын микрофоныг нээе. 1 дүгээр микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулья.

Уучлаарай. Буруу ойлгосон байна.

Тэгэхээр одоо тавигдаж байгаа том төслүүд өөрөө нэгдүгээрт нийгмийн өгөөжтэй төслүүд дээр гадаад зээлийн ашиглалтыг нэмж байгаа. Эрдэнэбүрэний усан цахилгааны станц. Дээрээс нь

цэвэрлэх байгууламж, газрын тосны үйлдвэр гэх мэт.

Тэгэхээр энэ бол эргээд бас өөрөө үр өгөөжөө өгөх төслүүд гэж нэгдүгээрт харж болно.

Хоёрдугаарт, бид төсвийн н хүрээний мэдэгдэлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиар бид 2 хувийн хуримтлал үүсгээд, үүнийгээ үндсэн төлбөрөө төлнө гэдэг ийм хуулийн заалт орж ирж байгаа.

Яг одоогийн зохицуулалтаар ямар нэгэн өр төлөх тийм зохицуулалт манай хуульд байдаггүй. Энэ шинээр орж ирж байгаа.

Тэгээд 29-н хүртэл товчхондоо бид тооцоолол хийж үзсэн. Өрийн ямар нэгэн дарамтад орохгүй. Дээр нь урсгал зардал дээрээ бид 30 хувийн хязгаар гэдэг орж ирсэн. Эндээ цалин хөлсөө, тэтгэвэр, тэтгэмжээ нэмээд явахад хангалттай хүрэхээр байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Ц.Идэрбат гишүүний микрофоныг нээе.

**Ц.Идэрбат:** Засгийн газраас өргөн барьсан төсвийн тодотголыг бүхлээр нь дэмжиж байгаа гэдгээ илэрхийлж байгаа.

Байнгын хорооны хуралдаануудаар яригдаж байгаа учраас.

Өнөөдөр Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн тодотголтой, тэр дундаа эхний асуулт Үндэсний баялгийн сантай холбоотой асууя гэж ингэж бодож байгаа юм.

Үндэсний баялгийн сангийн хууль өнгөрсөн парламентаар батлагдаад

тодорхой хугацаа өнгөрч байгаа. Хуулийг хэрэгжүүлэх үйл явцууд төсвийн тодотголоор бас нэлээдгүй тусгагдаж орж ирж байна гэж харж байгаа.

Үүн дээр манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндтэй холбоотой асуудлууд орж ирж байгаа юм. Үндсэндээ боловсрол, эрүүл мэнд, орон сууц гэсэн гурван үндсэн хэрэглээг хангахад Баялгийн сангийн хууль маань чиглэгдэж байгаа гэж үзэж байгаа.

Тэр дундаа одоо энэ баялгийн сангийн хуулиар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэг энэ зүйл, заалт одоо хэрэгжиж байгаа Эрүүл мэндийн даатгалаар авч байгаа эрүүл мэндийн үйлчилгээ хоёрын хооронд ер нь ямархуу зөрүү гэх үү, давхардал гарахгүй байх ямар үйлчилгээнүүдийг тусгаж үзэж байгаа юм бэ?

Ялангуяа эрүүл мэнд дээр яригдаад байдаг тэр өндөр үнэтэй, эсвэл гадаад руу явах байдаг юм уу, тийм хэрэгцээнүүд бас энд тусгагдаж байгаа юу гэдгийг асуух гэж байгаа юм.

Тэгээд үүнийг иргэд, олон нийт маш ихээр сонирхож байгаа юм.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоогоор авч байгаа эрүүл мэндийн үйлчилгээнээс баялгийн сангаар авах эрүүл мэндийн үйлчилгээ хоёрын хооронд ямар зөрүү ялгаа байгаа юм бэ гэдэг, яаж төлөвлөж байгаа юм бэ гэдэг нэг ийм асуулт байгаа юм.

Хоёр дахь нь, сая С.Эрдэнэбат гишүүний асуултад гарч байна. Энэ бас л ярих ёстой зүйл юм билээ. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн энэ хөрөнгийг. Нийгмийн даатгалын сан ч ялгаагүй хэдхэн хүний буруутай үйл ажиллагаанаас болоод банканд

байршуулсан. Өнөө банк нь дампуурсан. Өнөөдөр төлж чадахгүй хэдэн зуун тэрбумын асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр цаашдаа энэ хүмүүсийн гаргасан алдаа шиг алдааг гаргахгүйгээр энэ санг эдийн засгийн эргэлтэд оруулах хүүгийн орлого олох олон бололцоонууд бол би байгаа юм билээ гэж өнгөрсөн хугацаанд бас харсан.

Тэгэхээр цаашдаа энэ хүмүүсийн гаргасан алдаа шиг алдааг гаргахгүйгээр энэ санг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүүний орлого олох олон бололцоонууд би байгаа юм билээ гэж өнгөрсөн хугацаанд харсан.

Тэгэхээр цааш эрүүл мэндийн даатгалын сан хөрөнгийг бэхжүүлэх, өсгөх тал дээр ямархуу зүйл, заалтыг ер нь цаашидаа төлөвлөж байгаа юм.

Одоо жишээ нь өнөөдөр гэхэд дөнгөж сая л манай Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг дарга ирээд л Эрүүл мэндийн төвийн машины асуудал яриад л явж байгаа. Энэ 330 сум тулгамдсан байдаг юм билээ.

Тэгэхээр ер нь цаашдаа Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үүнийг бас зөв зарцуулж чадвал эдгээр юмнуудыг шийдчих ийм бүрэн дүүрэн бололцоо байгаа гэж ингэж харж байгаа юу? Ийм юм судалж үзэж байгаа юу л гэж хоёр асуулт байна.

**Л.Энхнасан:** Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр микрофоныг өгнө үү.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Би баялгийн сантай холбоотой хэсгийг нь хариулъя.

Одоогийн Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар ямар зардлуудыг, ямар тусламж, үйлчилгээг ямар эх үүсвэрээс, хаанаас яаж санхүүжүүлэх талаар тодорхой заасан байгаа.

Тэр хүрээндээ Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зардлууд ингээд хуулийнх нь дагуу гараад явж байгаа. Улсын төсвөөс мөн гарах ёстой зардлууд түүгээрээ гараад явж байгаа гэж ойлгогчхож болно.

Баялгийн сангийн хуулиар эдгээр чиг үүрэгтэй давхцуулахгүйгээр зарлага гарах боломжтой гэж бид харж байгаа.

Энэ удаагийн төсвийн тодотголтой хамт Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хууль буюу одоо шинээр энэ хуулийг оруулж ирж байгаа. Энэ хууль дээр орлого талыг нь бид оруулж ирсэн байгаа.

Энэ дээр зарлага бичигдээгүй байгаа. Ер нь Хуримтлалын сан дээр нийтдээ 500 орчим тэрбум төгрөг энэ жил хуримтлагдахаар байгаа.

Засгийн газрын түвшинд эхний ээлжид хуримтлагдаж байгаа зардлаар орон сууцын асуудлыг, орон сууцжуулалтын хөтөлбөрийг дэмжиж ажиллах нь зүйтэй байна гэж үзээд шийдвэрээ гаргасан байгаа.

Баялгийн сангийн хуулиар энэ сангийн хөрөнгийг Монголбанканд байршуулахаар байгаа. Яг энэ дагуу бид Монголбанканд байршуулаад, мөн ипотекийн хөтөлбөрийг илүү дэмжих байдлаар ингээд оролцоод явж байгаа.

Тэгэхээр товчхондоо эрүүл мэндийн чиглэлээр болон боловсролын чиглэлээр энэ удаадаа зарлага гараагүй байгаа гэж хэлье.

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан. 4 дүгээр микрофон. Гишүүний асуултад хариулна уу.

**Т.Мөнхсайхан:** Эрүүл мэндийн даатгалын сан ямар нэгэн арилжааны банканд байрлах боломжгүй болсон шүү дээ. Хууль тогтоомжоороо.

Яагаад гэвэл өмнө нь арилжааны банканд байрласнаас болж маш их хэмжээний алдагдалд орсон. Хүү авч байснаасаа илүү их мөнгийг эргэж авч чадахааргүй болсон.

Тэгэхээр энэ дээр Төрийн сан. Зөвхөн Төрийн санд байрлахаар хууль тогтоомжтой. Харин энд байрлахдаа чөлөөт үлдэгдэл дээр нь хүү нь бодогдох ёстой гэж үзэж байгаа.

Сум, орон нутгийн машин тэрэгний хангамжийн хувьд яам 330 сумын машины асуудал, тэр барилгын дээврийн асуудлыг шийдээд байхаар энэ бүтэхгүй юм билээ.

Тийм учраас эрүүл мэндийн салбар бол гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо руу орсон. Энэ тогтолцоо руу одоо харин сумын Эрүүл мэндийн төвүүд бүрэн ороогүй ээ. Нэг иргэнээрээ санхүүжиж байгаа.

Дээрээс нь 4 төрлийн тусламж, үйлчилгээгээр гүйцэтгэлийн санхүүжилт авч байгаа.

Тэгэхээр энэ эрхийг нь орон нутар руу.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмээд цаг өгнө үү. Сайдад. 4 дүгээр микрофон.

**Т.Мөнхсайхан:** Тэгэхээр орон нутгуудад нь сумын Эрүүл мэндийн төвүүдээ цааш нь яаж машин тэрэг, унаагаар нь хангах юм, яаж байр саваар нь хангах юм гэдэг энэ эрх мэдлийг нь өгмөөр юм билээ.

Гэхдээ энэ удаад бид бүх сумыг туулах чадвар сайтай машинаар энэ 2 жилдээ багтааж хангахаар төлөвлөсөн.

Үүний эхний ээлжийн хангалтууд 100 гаруй суманд машинууд нь хуваарилагдсан байгаа. Одоо ингээд 11 сард дараагийн ээлжийн тодорхой туулах чадвар сайтай машинууд ирнэ.

Ингээд ирэх оны төсвийн төсөөлөлд үлдсэн сумуудыг автомашинаар хангах энэ төсвийн төсөөлөлдөө өгчихсөн, суулгачихсан байгаа.

Ингээд 2 жилдээ багтаагаад бид бүх сумандаа хүнээ тээвэрлэх боломжтой машинаар нь хангаад өгчих юм бол цаашдаа 5 жил тутамдаа парк шинэчлэл хийгээд явах юм бол зөв болохоор юм билээ гэж харж байгаа.

**Л.Энхнасан:** Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээе.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны чиг үүрэгт холбоотой, хамааралтай 4 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тодотгол өнөөдөр танилцуулагдаж байна.

Тэгээд энэ тодотголын товч танилцуулга буюу шинжилгээг манай Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт

шинжилгээний хэлтсээс хийгээд ирүүлсэн байна л даа.

4 сайдын багцын 3 нь үндсэндээ яагаад энэ төсвийн тодотгол хийх, төсвийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна вэ гэдэг нь тодорхой орж ирсэн байна.

Харин Эрүүл мэндийн сайдын төсвийн тодотгол дээр 22.7 тэрбум төгрөгөөр урсгал зардал өсөж байгаа.

Тэгээд түүн дээр ерөөсөө ганц л өгүүлбэр байгаа юм. Энэ нь болохоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл худалдаж авахаар төлөвлөсөн болон урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын зардлыг тооцсонтой холбоотой болно оо л гэсэн тайлбартай.

Энэ зардал чинь угаасаа 2024 оныхоо төсөв дээр тавигдаад орж байгаа л зардал шүү дээ.

Үүнийг тодотгох болсон шалтгаан нь юу юм бэ гэдэг нь энэ хийгдсэн шинжилгээ дээр байхгүй байна л даа.

Тэгэхээр Эрүүл мэндийн яам маань энэ дээр өгч байгаа мэдээлэл нь ийм байв уу? Манай Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс хийгдэж байгаа энэ шинжилгээний ажлын чанар өөрөө ингэж орж ирээд байна уу?

Тийм учраас би Эрүүл мэндийн сайдаас энэ асуудлыг тодруулах гэсэн юм. Урсгал зардал дээр өсөж байгаа 22.7 тэрбум төгрөгийн өсөлт ямар хүчин зүйлээс хамаар нэмэгдэж байгаа юм бэ? Ямар асуудлууд байгаа юм бол.

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы микрофоныг өгье. 4 дүгээр микрофон.

**Т.Мөнхсайхан:** Энэ цаг үеийн байдалтай холбогдож төсөв нэмэгдсэн.

Улаан бурхны дэгдэлт ер нь олон улсад 170 гаруй улсад дэгдэлт байгаа. Манай улсад гаднаас улаан бурхан тээвэрлэгдэн орж ирж дотоодод халдварын тохиолдол бүртгэгдсэн.

Сүүлд Баян-Өлгий аймагт 4 тохиолдол бүртгэгдсэн байгаа.

Ингээд улаан бурхан өвчний дотоодод дэгдэлт тархсан тохиолдолд бид бас тодорхой хариу арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

Үүн дээр бид урьдчилсан байдлаар тооцооллуудыг гаргаж, 22 тэрбум санхүүжилтийн тооцооллийг гаргаж Сангийн яаманд саналаа өгсний дагуу орсон байгаа юм.

Тэгэхдээ энэ дээр тодорхой улаан бурхны дэгдэлттэй холбоотой, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой гэдэг энэ тодорхойлолтуудыг бичиж өгсөн. Та бүхэнд очсон материалууд дээр энэ маань тодорхой тусаагүй байна.

Тийм учраас энэ дээр нэмэлт тайлбарт хийлээ. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? С.Эрдэнэбат гишүүн гишүүний микрофоныг нээе.

**С.Эрдэнэбат:** Тэр төсвийн урсгал зардлыг 30 хувьд байна уу. Одоо чинь 38 хавьцаа байна уу. Төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь.

Тэгэхээр эргээд 30 хувь гэхээр 8 хувь бууруулна гэсэн үг. Пунктээр.

Тэгэхээр эргээд ямар зардал танах гэдэг асуудал яригдах гээд байна уу гэж би ойлгоод байгаа. Сангийн яамных гараад явчихсан уу? Тийм.

Тэгэхээр энэ тал дээрээ анхаарахгүй бол нэг талаараа баахан юм нэмнэ, сайжруулангуутаа нөгөө талдаа хамгийн чухал хүмүүсийн иргэдийн хүлээж байдаг урсгал зардал гэдэг юмнуудаа дээд талыг нь хязгаарлаад, тэгээд Сангийн төсөв хэлэлцэж байх үед хөрөнгө оруулалтынхаа дээд хязгаарыг байхгүй болгоод хаячихсан гэж ойлгосон.

Б.Жавхлан сайдын танилцуулж байгаа. Одоо засах гэж байна гэж ойлгосон.

Тэгэхээр яг энэ зүйл дээр автоматаар зарим зардлууд дээр нь дээд хязгааруудыг нь бууруулж оруулж ирээд, зарим дээр нь бүр байхгүй болгоод гэдэг нэг ийм зүйлийг орж ирж байгаа дээр би бас гайхаад байгаа юм.

Тэгэхээр яах вэ, нэг талаараа түрүүн Ц.Идэрбат гишүүн хэлсэн. Бид зарим талаараа хэт ерөнхий их ярьдаг. Халамж хавтгайрлаа л гээд байгаа.

Түүний цаана нь юу байна вэ гэхээр хүүхдийн мөнгө байгаад байдаг. Төрийн албаны хүмүүс нэмэгдлээ гээд байдаг.

Одоо энэ төсөв дагаж орж ирж байгаа баахан байшин барилгууд чинь дотор нь хүн ажиллана шүү дээ. Нөгөө багш нар, ажилчид ажиллана, эрүүл мэндийнхэн ажиллана.

Тийм учраас энэ зүйл дээр ерөнхийдөө нэг ийм хэт улс төржсөн

байдлаар асуудалд хандаад, тэр нь өөрөө нарийн тоонууд руу явж орж ирээд, эргээд бид нарт ямар ч гарцгүй дараа дараагийн төсөв, төсвийн хүрээний мэдэгдлүүд дээр ч гэсэн ийм байдал руугаа ороод ирэх юм бол бас хүнд байдал руу туулж болзошгүй ээ гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд яах вэ, төсвийн ерөнхийдөө томоохон нийгмийн шинж чанартай тэр зам гэх мэтчилэн энэ зүйлүүдийг дэмжиж байгаа.

Гэхдээ бид нарт төсвийн хөрөнгө оруулалтын зохистой харьцаа гэдэг зүйл байх ёстой.

7, 8 жил нэг байшин барилга барьдаг биш, ерөөсөө нэг байшин баривал дээд тал нь 2 жил гэдэг л ийм юм тавьж өгөхгүй бол 7 жил болдог, 7 жилийнх нь анхных нь өртөг нь хоёр, гурав, дөрөв дахин өсчихсөн ч юмнууд бас яваад байдаг.

Тэр хувийн хэвшлийн компаниудыг буруутгах аргагүй. Бас нэг талаар үнэ өсөөд байгаа учраас.

Тийм учраас энэ зүйлийг бас хараарай гэдгийг хэлмээр байна.

Тэгээд баялгийн сан орж ирж байгаа. Баялгийн сангаас тэр эрүүл мэнд, боловсрол, орон сууц гээд чухал чухал юмнуудыг санхүүжүүлэх боломж орж ирж байгаагаар энэ удаагийн төсвийн тодотгол, бусад дагаж гарч байгаа хуулиуд чухал.

Би дахиад түрүүнийхээ тэр тендерийнхээ юмыг ярья.

Сая Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Төсвийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын

хороогоор оруулья гэдэг байдлаар ерөнхийдөө уначихлаа.

Нийгмийн үнэлгээний гэдэг зүйлүүдийг давхар тавьж, нийгмийн олон бодлогууд буюу зөвхөн төсвөөр хийж чадахгүй байгаа зүйлүүдийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, бусад дам болон шууд нөлөө үзүүлж байгаа эдгээр зүйлүүдээ эдийн засаг, татвар, нийгмийн бодлогуудаар давхар хөшүүрэгдэж дэмжихгүй бол зүгээр мөрөөдлийн сайн дураараа болно гэдэг байдлаар орхиж болохгүй юм.

Тийм учраас би Сангийн сайд ирэх төсөв оруулж ирэхдээ дагаад ямар нийгмийн шинж чанартай үйл ажиллагаанууд дээр татварын хөнгөлөлт үзүүлэх үү.

Нийгмийн даатгалын хөнгөлөлт гэж байхгүй. Бусад НӨАТ-ын хөнгөлөлт гэдэг зүйлүүдээ оруулж ирье гэж хэлж байсан.

Тийм учраас удахгүй ирэх жилийн төсөв яригдах учраас энэ удаагийн төсвийн тодотголын тогтоолын төсөл дээр дэмжиж байна гэдгийг хэлмээр байна.

**Л.Энхнасан:** Төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан Төсвийн байнгын хорооны хуралд танилцуулна.



Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа. Хуралдааныг хаалаа.

Хуралдаан 5 цаг 16 минут үргэлжилж, 16 цаг 54 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**